

ЧИ (МОН)
К 328

Министерство Высшего Образования СССР
Московский Институт Востоковедения

В. Ф. СЫЧЕВ М. Ф. КОЗЫРЕВ

ИЗБРАННЫЕ ТЕКСТЫ НА МОНГОЛЬСКОМ ЯЗЫКЕ

ВЫПУСК II

ИЗДАТЕЛЬСТВО М. И. В.
1950

И 328

Министерство Высшего Образования СССР

Московский Институт Востоковедения

-23849-
7820

195
1985


ИЗБРАННЫЕ ТЕКСТЫ НА МОНГОЛЬСКОМ ЯЗЫКЕ

ВЫПУСК II



Составители: В. ф. СЫЧЕВ
М. ф. КОЗЫРЕВ

Редактор М. И. СОКОЛОВ



ИЗДАТЕЛЬСТВО М. И. В.
1950 г.

Институт Востоковедения
Академии Наук СССР

НАЧАЛЬНЫЕ ТЕКСТЫ
ДЛЯ КОЛЛЕКЦИОНЕРОВ

1949 г.

Издательство Академии Наук СССР
Москва

1949


Издательство Академии Наук СССР

~~БИБЛИОТЕКА~~
~~ИХИМОВ. ИСТИНА~~

инв. 226/ч.

БИБЛИОТЕКА

Ин-т Востоковедения
АН СССР



МОСКВА, КРЕМЛЬ

**СССР-ИЙН САЙД НАРЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,
ЗӨВЛӨЛТ ХОЛБООТ УЛСЫН ГЕНЕРАЛИССИМ
ИОСИФ ВИССАРИОНОВИЧ СТАЛИН ТАНАА**

Октябрийн Нийгэм Журмын. Их Хувьсгалын 31 жилийн ойг тохиолдуулан Монголын ард түмэн ба Бүгд Найрамдах Монгол Ард Улсын засгийн газар болон өөрийн өмнөөс нийгэм журамт их гүрний ард түмний суут удирдагч танд ба Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Бүгд Найрамдах Холбоот Улсын засгийн газар, Зөвлөлтийн бүх ард түмэнд халуун баярыг хүргэж сайн сайхныг хүсье.

Хүн төрөлхтний түүхэнд шинэ үеийг нээсэн Октябрийн Нийгэм Журмын Их Хувьсгал нь дэлхий дахины дарлагдсан ард түмний хувь заяа, колони ба хагас колонийн орнуудын хувь заяанд үндсэн эргэлт болсон юм.

Дэлхийн зургааны нэг хувь дээр зөвлөлт засгийг тунхаглан тогтоосноос хойш даруй 31 жил болов.

Зөвлөлт засгийн 31 жилийн дотор их Зөвлөлт Холбоот Улс нь коммунизм өөд зоригтойгоор явж байгаа хамгийн хүчирхэг нийгэм журамт гүрэн болон хувирчээ.

Монголын ард түмэн 27 жилийн өмнө өөрийн хувь заяаг бүх давшилт хүн төрөлхтний манлай болсон бөгөөд шинэ дайныг шатаагчид империалист нарын балмад хорт төлөвлөгөөг эсэргүүцсэн дэлхийн ард түмний тэмцэлд оройлох суурийг эзэлж байгаа Зөвлөлт Холбоот Улсын ард түмний хувь заяатай мөнхөд холбосондоо бахархан байна.

Монголын ард түмнээс их зөвлөлтийн ард түмэнтэй байгуулсан хэлбэрч эвдэршгүй нөхөрлөл нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын эрх чөлөө, тусгаар тогтонолыг бэхжүүлэх ба эдийн засаг, соёл боловсролыг цуцалтгүй хөгжүүлэх хөгжил-

тийн найдвартай баталгаа болсоор ирсэн ба болж ч байгаа болно.

Монголын ард түмэн нь өөрийн улс ардын аж ахуй, соёл боловсролыг анхдугаар таван жилийн төлөвлөгөөний үндсэн дээр хөгжүүлэх бүтээлт хөдөлмөрт хамаг хүтээ чиглүүлэн ажиллаж байгаа бөгөөд их Зөвлөлт Холбоот Улсаар толгойлуулсан ардчилсан лагерь нь империалист лагерийг ялах явдалд дүүрэн илтгэлтэй байна.

Октябрийн Нийгэм Журамт Их Хувьсгалын 31 жилийн ойн өдөр, бүх дэлхийн хөдөлмөрчдийн зол жаргалан ба Монгол-Зөвлөлтийн ард түмний тусын төлөө танд эрүүл мэндийг хүсье.

Дэлхийн бүх ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолыг хувиралтгүй бат хамгаалагч эв найрамдал, ардчиллын найдвартай тулгуур ба туг болсон Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Бүгд Найрамдах Холбоот Улс мандтугай!

Зөвлөлт Монголын ард түмний мөнхийн нөхөрлөл мандах болтугай!

**Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Ерөнхий сайд маршал ЧОЙБАЛСАН**

УЛАНБААТАР ХОТ 1948 г. 11/6.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖНЫ ТУШААЛ

№ 464

1948 оны 11 дүгээр сарын 7. Улаанбаатар хот.

Нөхөд цэрэг, түрүүч, ахлагч, офицер, генералуудаа!

Ардын сайн дурын морьт отрядын байлдагч, дарга нараа!

Өнөөдөр манай орны хөдөлмөрчин ард түмэн ба зэвсэгт хүчин нь агуу их Зөвлөлтийн ард түмэнтэй бүх дэлхийн хөдөлмөрчдийн хамт Октябрийн Агуу Их Түүхт Социалист Хувьсгалын 31 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлж байна.

Орос оронд мандсан Октябрийн Агуу Их Социалист Хувьсгал бол монгол оронд ардын хувьсгалыг байгуулах явдалд хүчтэй түлхэц нь болж өгсөн учраас манай Монголын нам ба

өөрийн хайрт удирдагч Сухбаатарын удирдлагын дор Агуу Их Зөвлөлт Улсын тусламжтайгаар манай ард түмэн нь хувьсгалаар босож, гадаад дотоодын боолчлон дарлагч нарыг устагаад, ардын засаг төрийг тогтоож, тусгаар тогтоносон хувьсгалт улс гүрнийг байгуулсан юм.

Манай улс энэ 27 жил гаруйн турш Зөвлөлт Холбоот Улсын ах дүүгийн тусламжтайгаар ардын аж ахуй ба соёлыг хөгжүүлэх хэрэгт их амжилтыг олж, одоо тус орны ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх анхдугаар таван жилийн төлөвлөгөөг биелүүлэхийн төлөө ард түмэн нийтдаяараа амжилттай тэмцлийг явуулж байна.

Манай ардын хувьсгалт арми нь Зөвлөлтийн зэвсэгт хүчний тусламжтайгаар Монгол Улсын эрх чөлөө, тусгаар тогтонолыг гадаадын дайснаас хамгаалж, цэргийн эрдэм, агуу их эх орны дайны туршлагыг амжилттайгаар эзэмшиж өөрийн эх орны, ард түмний энх тайван цагийн бүтээлт хөдөлмөр ба хөгжлийг найдвартайгаар хамгаалж байна.

Октябрийн Агуу Их Социалист Хувьсгалын 31 жилийн ойг хүндэтгэн тэмдэглэж та бүхнийг мэндлэн баярыг хүргэж.

Тушаах нь:

Өнөөдөр 1948 оны 11 дүгээр сарын 7-ны 20 цагт манай эх орны нийслэл Улаанбаатар хотноо хорин их буугийн буудлагаар ёсолсугай.

Октябрийн Агуу Их Социалист Хувьсгалын ялалтыг зохион байгуулагч ЛЕНИН-СТАЛИНЫ Эвхамт нам мандтугай!

Монгол Зөвлөлтийн ард түмний ах дүүгийн үнэнч найрамдал мандтугай!

Бүх дэлхийн хөдөлмөрчин ард түмний агуу их удирдагч бөгөөд манай ард түмний хайрт хань Генералисим СТАЛИН мандтугай!

**Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
зэвсэгт хүчний жанжин, улсын
шалгарсан хошой баатар маршал
ЧОЙБАЛСАН**

**СССР-ИЙН САЙД НАРЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
ЗӨВЛӨЛТ ХОЛБООТ УЛСЫН ГЕНЕРАЛИССИМ
ИОСИФ ВИССАРИОНОВИЧ СТАЛИН ТАНАА**

Гитлерийн Германыг бүрмөсөн бут ниргэсний хоёр жилийн ойн баярыг тохиолдуулан, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн Газар ба Монголын бүх ард түмний өмнөөс болон хувиасаа манай үеийн суут мэргэн стратегч Танд ба Зөвлөлтийн ард түмэнд чин зүрхний халуун баярыг хүрэгье.

Зөвлөлтийн ард түмэн, түүний эрэлхэг Улаан Армиас баатар чадал, бат зориг гаргасны ач үрээр Гитлерийн Германыг бут ниргэж, дэлхий дахинаа түүхт ялалтыг байгуулсан нь, бүх дэлхий дахины соёл боловсролыг балран сөнөх аюулаас аварсан байна. Дайны дараахь үед Зөвлөлтийн ард түмнээс өөрийн улс ардын аж ахуйг сэргээн босгож хөгжүүлэх явдал дээр нэг адил баатар чадал, бат зоригийг гаргаж, энх тайван байдлыг сахиж хамгаалах хэрэгт нүд цавчилгүй ажиллаж байна.

Шинэ дайныг дэгдээн гаргахаар ажиллагчдаас түрэмгийллийнхээ төлөвлөгөөг шургуулан тавьж байгаа боловч Зөвлөлтийн засгийн газраас биелүүлж байгаа гадаад бодлого нь, ардчилсан ёсны энх тайван байдлыг шудрага ёсоор бат бэх тогтоож чадна гэдэг итгэл найдварыг бүх дэлхийн эрх чөлөө эрмэлзэгч улс үндэстэнд төрүүлж байна.

Өнөөдөр манай Монголын ард түмэн, ялалтын их баярыг ах дүү Зөвлөлтийн ард түмний нэг адил баяр баясгалантайгаар угтан өнгөрүүлж байхдаа, түүний оргилсон ажиллагаанд зориг бадран, түүний тусламжтайгаар өөрийн тусгаар тогтносон улс төрийг цааш нь улам цэцэглүүлэн хөгжүүлэхэд бүх хүч чадлаа гаргаж байна.

Манай хоёр улсын ард түмний хоорондын найрамдал нь дорно дахинд ба дэлхий даяарт аюулгүй энх тайван байдлыг бэхжүүлэх үйл хэргийн төлөө олон зуун үед улам улмаар бэхжин мандтугай!

**Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Ерөнхий Сайд Маршал ЧОЙБАЛСАН**

УЛААНБААТАР ХОТ. 1947 оны 5 дугаар сарын 8.

МОНГОЛ АРД УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖНЫ ТУШААЛ

1847 оны 11 дүгээр сарын 7

Улаанбаатар хот

Ардын Хувьсгалт Цэргийн генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагчдаа! Ардын сайн дурын морьт отрядын дарга байлдагчдаа!

Энэ өдөр манай улсын ард түмэн, агуу их Октябрийн нийгэм журамт их хувьсгалын алдарт 30 жилийн ойн баярыг ёслон өнгөрүүлж байна.

Үүнээс 30 жилийн өмнө Орос орны хөдөлмөрчин тариачин нар, большевик нам ба түүний их удирдагчид Ленин-Сталин нарын удирдлагын дор капитализм ба помещикийн дарлалыг устгаж, дэлхий дээр анх удаа Зөвлөлт засгийг байгуулжээ.

Зөвлөлтийн ард түмэн, эв хамтын нам ба нөхөр Сталины удирдлагын дор, эв хамтын нийгмийг байгуулах замаар бат найдвартай хөгжиж байна.

Бөмбөрцгийн зургааны нэгэн хувь дээр ялсан, пролетарийн нийгэм журамт хувьсгал нь манай оронд ялж дийлсэн ардын хувьсгалын хүчтэй түлхэц нь болсон юм.

Манай нам, өөрийн их удирдагч Сүхбаатараар удирдуулан залуу Зөвлөлт Улсын дэмжлэгтэйгээр ард түмнийг гадаад дотоодын дарлагчдын эсрэг ариун тэмцэлд босгож тэр тэмцлийн хүчээр эрх чөлөө ба тусгаар тогтнолоо байлдан олж авсан билээ.

Манай улс, Зөвлөлт Улсын ах дүүгийн тусламжтайгаар эрх чөлөөт тусгаар улс болон тогтносоор 26 жил гаруй цэцэглэн хөгжиж ирлээ.

Зөвлөлт, Монголын ард түмний агуу их нөхөрлөл нь Германы фашист, Японы империалист нарыг эсэргүүцсэн тэмцлээр бэхжисэн бөгөөд дэлхий дээр энх тайван, ардчилсан ёсыг бэхжүүлэх тэмцэлд ч улам бүр батжин бэхжисээр байна.

Нөхөд — байлдагч, түрүүч, ахлагч, офицер генералуудаа! Манай эх орны хөдөлмөрчдийн өмнө алдартай жишээг үзүүлэн марксизм-ленинизмийн онолыг цуцалтгүй эзэмшиж, цэргийн сахилгыг батжуулан, өөрийн хувьсгалт нам, засгийг улам нягтаар хүрээлэгтүн!

Манай ард түмний бүтээн байгуулах хөдөлмөрийг хамгаалах их үүргээ үнэнчээр биелүүлэгтүн!

Октябрийн Нийгэм Журмын Их Хувьсгалын 30 жилийн ойг тохиолдуулан та нарт баярыг хүргэж мэндэлье.

Октябрийн Нийгэм Журмын Их Хувьсгалын 30 жилийн ойг тэмдэглэхийн тулд тушаах нь:

Өнөөдрийн 20 цагт манай эх орны нийслэл Улаанбаатар хотноо их буугаар 30 удаа буудаж ёсолсугай.

Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Бүгд Найрамдах Холбоот Улс ба тусгаар тогтносон бүрэн эрхт Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын тэмцлийн агуу их нөхөрлөл маиндтугай!

Октябрийн нийгэм журамт их хувьсгалын ялалтыг зохион байгуулагч бөгөөд удирдагч Ленин-Сталины нам мандтугай!

Октябрийн нийгэм журмын их хувьсгалын ялалтыг зохион байгуулагч манай ард түмний үнэнч нөхөр агуу их Сталин мандтугай!

**Зэвсэгт хүчний жанжин улсын шалгарсан
хоший баатар маршал ЧОЙБАЛСАН**

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД МАРШАЛ ЧОЙБАЛСАНД

УЛААНБААТАР

Фашистын Германыг ялсны 2 жилийн ойг тохиолдуулан, найрамдалт ёсоор баярыг хүргэсний хариуд эрхэм танд ба танаар уламжлан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн Газар чин сэтгэлийн талархлыг илэрхийлье.

Зөвлөлтийн ард түмэн, Эх Орны Их Дайны жилүүдэд Монголын ард түмнээс Зөвлөлтийн Армид тусалж байсан ах дүүгийн тусламжийг сэтгэл хөдлөн тэмдэглэж байна.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн Газар ба хөдөлмөрчин ард олонд эрхэм сайхан амжилтыг хүсье.

И. СТАЛИН

МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ ЦЭРГИЙН ТАНГАРАГ

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын харьяат би, Ардын Хувьсгалт Цэргийн тангаргийг хүлээж, шудрага баатарлаг, са-

хилга батгай, сонор сэрэмж бүхий байлдагч болохын дээр, цэргийн ба улсын нууцыг хатуу хадгалж, цэргийн дүрэм заавар ба дарга, захирал, нарын тушаалыг ямар ч үг дуугүй биелүүлэхийг тангараглана.

Би, цэргийн аливаа нэгэн сургуулийг шудрага суралцан судалж, цэргийн ба улсын эд хогшлыг нүдний цөцгий мэт аль болохоор хайрлан хамгаалах ба хамгийн Эцсийн амьсгал ба цусны дуслыг дуустал өөрийн ард түмэн, Эх орон ба Нам, Засагтаа үнэнч шудрага болохыг тангараглана.

Ардын Хувьсгалт Нам, Засгийн тогтоол, тушаалаар өөрийн Эх орон болох Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг батлан хамгаалахдаа би, хэзээд бэлэн ба Монгол Ардын Хувьсгалт Цэргийн байлдагчийн хувиар Эх орноо хамгаалж, дайсныг бут цохихын тулд эрэлхэг чадвартай бөгөөд өөрийн амь биеийг хайрлахгүй тэмцэхийг батлан тангараглана.

Хэрэв би, санаатайгаар энэ тангаргаа няцвал Монголын ард түмэн үүрт жигшигдэн, хувьсгалт хуулийн хамгийн дээд хэмжээгээр шийтгэгдэхэд гомдохгүйг тангараглан батална.

ШИНЭ ЦЭРГИЙГ ХҮЛЭЭН

АВАХАД БЭЛТЭГЬЕ

1946 оны ээлжийн хугацаат цэрэг датлагыг явуулахаар гаргасан, Сайд нарын Зөвлөлийн тогтоолыг энэ өдрийн дугаарт нийтлэв.

Сайд нарын Зөвлөлийн 27 дугаар хурлын тогтоолын ёсоор энэ онд 20 насанд хүрсэн, мөн өнгөрсөн жилүүдэд цэргийн албан хаах явдлаас элдэв шалтгаанаар чөлөөлөгдөж байсан учраас цэргийн албан хаагаагүй байгаа 21-гээс 28-ыг дуустлах насны эрчүүдийг дайчлан татаж, цэргийн ба дотоодын хийгээд хязгаарын цэргийн ангиудад албан хаалгах болно. Эдгээр залуучууд нь хугацаа дуусгаж халагдах, хуучин дайчин нараа залгамжлан, цэргийн эрдэмд боловсрохын хамт эх орноо хамгаалах ариун үүргийг биедээ хүлээнэ. Цэргийн жагсаалд хүрэлцэн ирж байгаа шинэ залуучуудыг цаашид дэс дараатайгаар сурган хүмүүжүүлэхийн учир тэдгээрийг анги, нэгтгэлүүдэд хүлээн авах ажлын бэлтгэлийг олон талаас

хангаж гүйцэлдүүлэх нь чухал байна. Өөрийн жагсаалд шинэ хүмүүсийг нэмэн авах өргөн ажил нь манай цэргийн ба улсын 25 жилийн алдарт ойд бэлтгэж байгаа их ажлын цагаар тохиолдсон явдал бол анги, салбарын дарга улс төрийн ажилтны санаачлага хөдөлмөрийг шаардаж байна. Улаанбаатар ба хязгаарын гарнизонуудад шинэ цэргийн карантиний газар ажиллах офицер нарыг шилэн томилж ажиллуулахын хамт, карантиний байрыг аж ахуйн хэрэглэгдүүнээр хангаж, элдэв нэгэн талаар дутагдалгүй бөгөөд боловсон тохилог болгох хэрэгтэй. Цугларах газар (дамжлага баз уудад шинэ цэргүүдийн орон сууцыг боломжтойгоор бэлтгэж, хоол ундыг хүрэлцээтэй, чанарлаг, амттай байлгах үүрэг тэнд ажиллаж байгаа офицер нарт оногдоно.

Дайчлагааны үеэр чухам ийм байдалтай байлгахыг одоогоос төлөвлөн бэлтгэх нь чухал байна. Нэгтгэл, тусгай ангиудын карантин хийгээд төв ба хязгаарын дамжлага базын газар олон нийт, гэгээрлийн ажлыг янз янз хэлбэр маягтайгаар, боловсруулсан нарийн төлөвлөгөөг баримтлан тогтмол зохиох ёстой байна.

Тухайлбал: Улаанбуланг байгуулж, шинэ цэргүүдийн улс төрийн мэдрэлийг нээгдүүлэн, цаашид өргөтгөх агуулгыг хадгалсан, төгөлдөр утга бүхий самбаруудыг зохиож, тэр буланг тоноглохын хамт цэргийн албан хаах явдалд ардын үүрэг юу болохыг үндсэн хуулийн зохих бүлгээс иш татаж үзүүлсэн уриа лозунг зөвхөн улаанбуланд төдий биш, тэдний явах зорчих газар ба суух, хооллох байруудад өлгөж танилцуулах хэрэгтэй болно. Завтай цагийг ганцхан шуугианаар өнгөрүүлэх байдалд хүргүүлэхгүйн учир, сонин унших, суртал ухуулга хийх чадварлаг ухуулагч нарыг тусгай томилж, цагийн хувиарын ёсоор ажиллуулах хийгээд шатар даам, бусад ашиг тус бүхий наадам тоглоомыг өргөн дэлгэрээр зохиох нь чухал болно. Гарнизон ба нэгтгэлүүдийн улс төрийн хэлтсүүд нь ангиудын уран сайхны хэсгийг, төлөвлөн хувирлаж шинэ цэргүүдийн дунд ажиллуулахын зэрэгцээгээр, уран сайхан, олон нийтийн ажилд шинэ цэргүүдийг (өөрсдий нь) өргөнөөр оролцуулахыг хичээх хэрэгтэй бөгөөд жишээлбэл: тэдний зохиосон шүлгийг уншуулах, эрмэлзлэлийг дагуулан ямар нэгэн урт богино дууг өөрсдөөр нь дуулуулах зэрэг болно. Өөрөөр хэлбэл, шинэ цэргийн гарнизоны ба дамжлагын газрууд нь хөдөлгөөн чимээгүйхэн уйтгарын байдалтай биш, харин залуусын сэтгэлийг хөгжөөн, тэднийг соёлжуулан хүмүүжүүлэх нөхцөл бүрдсэн бөгөөд дамжин явагсдын зоригийг бадруулах гэгээрлийн орон байх нь шаардагдана. Дээр дурдсан зүйл бол шинэ цэргийг хүлээн авах ажлын анхдугаар хэсэг нь юм.

Үүнээс цаашлан тэднийг цэргийн жинхэнэ анги, салбарт, дайчдын эгнээнд оруулан, цэргийн аж байдалтай танилцуу-

лах хариуцлагатай үүрэг манай түрүүч, офицер нарт тулгарна. Энэ үе нь ардын хувьсгалт цэргийн ба улсын түүхт 25 жилийн их ойг ёслол өнгөрүүлж байгаа хариуцлагатай үесээр тохиолдохыг манай офицер, түрүүч нар санаж ажиллах хэрэгтэй.

Манай шинэ цэргүүдийн зарим хэсэг нь цэргийн ба улсын 25 жилийн ойн их ёслолын парад жагсаалын бүрэлдүүнд оролцохын учир тэднийг цэргийн аж байдалд тасгаж дадуулах хэрэг яаралтайгаар шаардагдана.

Энэ жилийн цэрэг датлагын ажлыг маш бэлтгэлтэй сайнаар зохиож өнгөрүүлэхийг бүх зэвсэгт хүчний жанжин, манай их удирдагч, маршал Чойбалсангаас онцлон шаардаж байна. Энэ тухайн бэлтгэл ажлыг хэрхэн гүйцэтгэхийг зааварлаж шаардсан тушаалдаа, аймаг хотын цэргийн хэлтсийн дарга нар ба бусад хариуцлагатны өмнө тодорхой үүргийг тавиад, шинээр татагдан ирж байгаа цэргүүдийг хүлээн авч зөвөөр сурган хүмүүжүүлэхийн тулд бэлтгэл ажлыг урьдаас сайнаар хангахыг анги, нэгтгэлийн дарга нарт анхааруулан тушаажээ. Бүх цэргийн жанжны тушаал ба Сайд нарын Зөвлөлийн тогтоолыг ширхэг дараалан биелүүлэхийн тулд захиргаа, аж ахуй, улс төрийн талаар гүйцэтгэх ажлыг одооноос төлөвлөх хэрэгтэй.

Шинэ цэргийг хүлээн авах явдал бол, цэргийн аж байдалд хөдөлмөрийг шаардах нөлөөтэй учраас, цэргийн албан хаагч бүрд шинэ үүрэг тулгарна. Жишээлбэл: Нэг-хоёрдох жилийн хуучин цэрэг ба ялангуяа халагдах нөхөд, шинэ хүмүүсэд сайн жишээг үзүүлэн, тэднийг сахилгатай хичээнгүй болгох үүрэг дайчны хувьд оногдоно.

Манай цэргийн дайчин байлдагч, түрүүч, офицер нараа! Ардын Хувьсгалт Цэргийн ба улсын 25 жилийн алдарт их ойн бэлтгэл ажлын дотор «шинэ цэргийг хүлээн авах бэлтгэлийг сайн хангая!» гэсэн шинэ сэдвийг оруулан, үүнийг чанартай сайн гүйцэтгэхийн учир бүхий л хүчээр чармайн оролдоцгооё.

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН САЙД
НАРЫН ЗӨВЛӨЛИЙН 1946 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 26-НЫ
ӨДРИЙН 27 ДУГААР ХУРЛЫН ТОГТООЛ**

**Утга нь: 1946 оны ээлжийн хугацаат цэрэг татлагыг
явуулах тухай**

Сайд нарын Зөвлөлөөс тогтоох нь:

1. 1946 онд шинээр 20 насанд хүрэгсэд ба үүний урьдахь жилүүдээр цэргийн албыг хаах явдлаас элдэв нэгэн шалтгаанаар чөлөөлөгдөж байсан бөгөөд 21-ээс 28-ыг дуустлах насны цэргийн албыг хаагаагүй эрчүүдийг дайчлан татаж, цэргийн ба дотоодын хийгээд хязгаарын цэргийн ангиудад цэргийн хугацаат албыг хаалгасугай.

2. Энэ оны жинхэнэ цэрэг татлагыг 6 дугаар сарын 15-наас эхлэн 7 дугаар сарын 15-ны дотор багтаан явуулахыг Цэргийн Явдлын Яаманд даалгасугай.

3. Татагдаж байгаа, ээлжийн хугацааны цэргүүдийг өөрийн орон нутгаас татлагын комиссын газар хүртэл, хувьсын уналагыг хэрэглүүлж гүйцэтгэх ба аймгийн захиргаадаас тогтоосон төлөвлөгөөний ёсоор татлагыг явуулж, хоол хүнсийг хангавал зохино.

4. Шинээр татагдан байгаа цэргүүдийн явах замын дагуу ба аймгуудын төвд байгуулах хоолны базууд болон шинэ цэргүүдэд хэрэглэгдэх ариун цэврийн ба өдөр тутмын хэрэглэгдэх төрөл бүрийн бараагаар 1946 оны 6 дугаар сарын нэгний наана хангах явдлыг Хоршоодын төв холбооны дарга ба Худалдаа хийгээд Хүнсний Үйлдвэрийн Яамны сайдуудад үүрэг болгосугай.

5. Энэ онд шинээр татагдан байгаа цэргүүдийг аймгийн төвөөс хүрэлцэн очих ангийг хүртэл, хавсралт төлөвлөгөөний ёсоор морин өртөө ба авто машинаар тээвэрлэх явдлыг аймгуудын захиргаадын дарга нар ба Тээврийн Яамны сайдад үүрэг болгон даалгасугай.

6. Шинээр татагдах цэргүүдийг нийт аймгууд ба хотын хэмжээн дээр эрүүл мэндийн талаар комислох эмч нарыг Цэргийн Яамны төлөвлөгөөний ёсоор хангах явдлыг, Эрүүлийг Хамгаалах Яамны сайд нөхөр Шинэнд даалгасугай.

7. Үндсэн цэрэг татлагын тухай, улс төрийн ухуулан таниулах ажил ба бусад бэлтгэлүүдийг сайтар хангаж, цэрэг татлагыг зохион байгуулалттай ба алдаа дутагдалгүйгээр явуулахыг аймаг хотын захиргаадын дарга нарт анхааруулсугай.

8. Манай тусгаар тогтносон Дүгд Найрамдах Монгол Ард Улсын зэвсэгт хүчний зохион байгуулалтыг бататгах явдлын

гол үндэс болох цэрэг татлагын ажилд захиргаа ба аж үйлдвэрийн хийгээд олон нийтийн байгууллагуудаас идэвхтэйгээр оролцож туслалцах явдлыг уриалан шаардсугай.

Ерөнхий сайд, улсын шалгарсан хошой баатар маршал
ЧОЙБАЛСАН

Хэрэг эрхлэх газрын дарга БАТ-ОЧИР

ХУВЬСГАЛТ ЦЭРГИЙН БАЯРЫН ӨДРИЙГ ТОГТООЖЭЭ

Манай энэ өдрийн дугаарт Монгол Ардын Хувьсгалт Цэргийн баярын өдрийг тогтоох тухай, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 32 дугаар хурлын тогтоолыг нийтлэв.

Энэ тогтоолоор Монгол Ардын Хувьсгалт Цэргийн баярын өдрийг жил бүр, 3 дугаар сарын 18-ны өдөр явуулж улс нийтээр ёслон өнгөрүүлж байхаар тогтоожээ.

Монгол Ардын Хувьсгалт Цэргийн баярын өдрийг ийнхүү 3 дугаар сарын 18-ны өдрөөр тогтоосон явдал нь түүхийн ба улс төрийн их ач холбогдолтой юм. Учир нь, манай цэрэг 1921 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Хиагтад байсан гадаадын эзэрхэг түрэмхий нарын цэрэгт цохилтыг өгч, Хиагт (одоогийн Алтанбулаг) хотыг чөлөөлөн, анхидугаар ялалтаа байгуулсан бөгөөд энэ ялалтаар манай цэргийн анхны дайчин отрядууд төрөн гарчээ.

Иймд манай цэргийн энэхүү анхны ялалтыг тэмдэглэхийн учир, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдээс 3 дугаар сарын 18-ныг хувьсгалт цэргийн бардын өдөр болгон тогтоосон байна.

Манай цэрэг өөрийн анхдугаар ялалтыг байгуулснаас хойш одоо 25 жилийн ой болж байна. Энэ 25 жилийн дотор, манай ардын хувьсгалт цэрэг нь Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолыг хамгаалах явдалд онцгой гавьяаг байгуулан, байлдах эрдэм, зэвсэглэлээрээ хүчирхэг цэрэг болон хөгжжээ. Манай цэрэг өнгөрсөн 25 жилийн дотор Японы эзэрхэг түрэмхий нарын зэвсэгт довтолгоонуудыг удаа дараа буг цохисноороо өөрийн анхны дайчин түүхээ улам баяжуулж, дэлхий дээр нэр алдраа мандуулжээ. Ялангуяа 1945 онд дорно зүгийн түрэмхийллийн голомт болсон Японыг дарах хэрэгт

манай цэрэг идэвхтэй оролцож өөрийн үүргийг гарамгай биелүүлснээр их Сталины өндөр үнэлэлтийг хүлээж, Японы халдан довтлох аюулаас эх орныхоо дорно хилийг үүрд ангижруулжээ.

Манай цэргийн энэхүү алдарт гайхамшигт 25 жилийн ойн баяр нь одоо удахгүй болох гэж байна.

Энэ тухай Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 32 дугаар хурлын тогтоолд тэмдэглэсэн нь: «... Монгол Ардын Хувьсгалт Цэргийн 25 жилийн ойг 1946 оны 7 дугаар сарын 11-нд хувьсгалын ойн баярын өдөртэй хамтатган явуулж 1947 оноос эхлэн дараачийн жилүүдэд цэргийн ойн баярыг энэ тогтоолоор заасан тусгай өдөр нь ёслол өнгөрүүлж байсугай» гэжээ. Үүнд Монгол Ардын Хувьсгалт Цэргийнхээ баатарлаг ялалтын 25 жилийн ойг улс төр, байлдааны бэлтгэлийн өндөр амжилтаар угтаж, түүнд шаргуу бэлтгэх үүрэг одоо шаардагдаж байна.

Хувьсгалт цэргийн анги, салбар бүхэн, 25 жилийнхээ ойд өргөнөөр бэлтгэхийн тул одоогоос эхлэн ажлыг зохинох ёстой. Үүнд, бух клуб, Сүхбаатарын тасалгаа, казармуудыг Монгол Ардын Хувьсгал ба Хувьсгалт Цэргийн 25 жилийн хөгжилтийн баримтууд ба Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны бүгд хурлын шийдвэрийн үндэснүүдээр чимэглэж, эл шийдвэрийг биелүүлэхэд бүх хүмүүсийн анхаарлыг дайчлан дуудсан уриа, лозун, ханын ухуулгуудыг дэлгэрүүлэх ёстой.

Бас манай алдарт ялалтын 25 жилийн хөгжлийг суртал ухуулгын бүх аргаар мэдрүүлэхийн тул, чадвартай хүмүүсээр дарга, цэргүүдийн дотор лекц, яриа, сонин уншлагуудыг тасралтгүй зохиолгохын хамт ялангуяа дорд ухуулагчдыг зориут семнарлан бэлтэгж байлдагч нарын дотор цаг үргэлж ажиллуулах ёстой

Монгол Ардын Хувьсгалт Цэргийн бүх албан хаагчид нь өөрийн 25 жилийн ойг өндөр амжилтаар угтахын тул бүх цэргийн жанжнаас гаргасан зун цагийн сургуулийн программыг шаргуугаар судалж улс төр, байлдааны бэлтгэлийн хувьд шинэ алхмыг хийх хэрэгтэй.

Хүн, бүхэн 25 жилийн ойн баярын наана заавал Монголын шинэ үсэгт тайлагдан сурахын хамт, анги салбаруудын дотор явагдан байгаа, өвлийн бэлтгэл ажил ба улсын төлөвлөгөөний ажлыг амжилттай биелүүлэхэд хүн бүр идэвхтэй оролцогтун!

Хувьсгалт цэргийн анги салбар бүхэн шинэ цэрэг хүлээн авах ба хуучин цэргийг халагдуулах ажлыг сайн зохион байгуулалттайгаар явуулж, өөрийн улсдаа шилдэт шинэ хүчнийг шилжүүлэх ба армидаа шинэ зузаатгалыг хүлээн авахад бүхий л талаар бэлтгэх хэрэгтэй.

Цэргийн биеийн тамирчид, урлагийн ажилтан бүхэн гавшгай бэлтэгж өөрсдийн бүтээж бий болгосон зүйлийг манай

улсын ба хувьсгалт цэргийн 25 жилийн их ойд шалгаруулахын учир цуцалтгүй тэмцэх хэрэгтэй.

Энэ үүргийг биелүүлж, Монгол Ардын Хувьсгалт ба Хувьсгалт Цэргийн 25 жилийн ойг өндөр амжилттайгаар угтах нь манай өнөөдрийн чухал үүрэг болж байна.

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
БАГА ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
32 ДУГААР ХУРЛЫН ТОГТООЛ
МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ ЦЭРГИЙН БАЯРЫН
ӨДРИЙГ ТОГТООХ ТУХАЙ**

Цэргийн Яамны сайд, бүх цэргийн жанжин нөхөр Чойбалсангаас Монгол Ардын Хувьсгалт Цэргийн ойн баярын өдрийг тусгай тогтоон явуулахыг хүсэж ирсэнийг хэлэлцээд, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдээс тогтоох нь:

1. 1921 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Монгол Ардын Хувьсгалт Цэрэг нь Монгол ардын хувьсгалын голомт Хиагт (одоогийн Алтанбулаг) Хотыг чөлөөлж, анхдугаар ялалтаа байгуулсан учир, энэ өдрийг Хувьсгалт Цэргийн баярын өдөр болгож, жил бүр улс нийтээр ёслол өнгөрүүлж байсугай.

2. Жил бүрийн 3 дугаар сарын 18-ны өдрийг цэргийн бүх албан хаагчдын амралтын өдөр болгосугай.

3. Монгол Ардын Хувьсгалт Цэргийн 25 жилийн ойг 1946 оны 7 дугаар сарын 11-нд болох хувьсгалын 25 жилийн ойн баярын өдөртэй хамтатган явуулж, 1947 оноос эхлэн дараагийн жилүүдэд цэргийн ойн баярыг энэ тогтоолоор заасан тусгай өдөр нь ёслол өнгөрүүлж байсугай.

**Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн дарга БУМЦЭНД
Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн
дарга БАЯР**

1946 оны 5 дугаар сарын 28.

УЛААН ТУГ БОЛ ЦЭРГИЙН АЛДРЫН БЭЛЭГ ТЭМДЭГ МӨН

Ноднин жилийн 8 дугаар сарын 3-ны өдөр Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдээс Хувьсгалт Цэргийн анги, нэгтгэлүүдэд түүний тугийг хүлээлгэн өх дүрмийг баталсан билээ. Туг хүлээлгэн өх тухай гаргасан энэхүү шийдвэр нь манай Ардын Хувьсгалт Цэргийн түүхэнд үүрд тэмдэглэлтэй зүйл мөн.

Туг бол цэргийн алдар нэрийн бэлэг тэмдэг юм. Иймээс тугийг хүлээн авах явдал нь энгийн нэг асуудал биш, харин энэ бол ангийн түүхэнд онц холбогдолтойгоор барахгүй, цэргийн хүмүүст хүмүүжлийн их ач тустай асуудал юм.

Энэ учраас манай улсын дээд эрхийг барих Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдээс Монгол Ардын Хувьсгалт Цэргийн анги нэгтгэлүүдэд түүний тугийг хүлээлгэн өх тухай дүрмийг маш нарийнар боловсруулан тогтоож өгсөн байна.

Энэ тогтоолын үтгэ ба байлдааны тугийн ач холбогдлыг лекц, яриа, сонин уншлага, бодит ухуулга зэрэг бүх хэлбэрүүдээр байлдагч, дарга цэргүүдэд тайлбарлан таниулж, хүн бүхнийг өөрийн байлдааны тугаа хүндэтгэж түүнийг ямар ч бэрхшээлийн дундуур өндрөөр өргөж явах, тийм хатуужилтай дайчин нар болгох нь, цэргийн доторхи нам, улс төрийн байгууллагуудын үүрэг юм.

Гэтэл манай нилээд хэдэн анги салбаруудад энэ чухал асуудлыг анхаарахгүй байгаа явдал одоо хүртэл үргэлжилсээр байна. Энэ учраас офицер, түрүүч, байлдагч нарын дотор, тугийнхаа утгыг сайн мэдэхгүй явдал зарим хүмүүс дээр оршиж байна.

Энэ бол анги, салбарын сахилга батыг бэхжүүлэх, хүмүүсийг цэргийн тангарагдаа чин шудрага байлгах явдлыг улам өндөржүүлэхэд ихээхэн дутагдал мөн.

Улаан армийн дотор, анги нэгтгэл бүхэн өөрийн байлдааны тугийг хамгийн эрхэмсэгээр хүндэтгэдэг юм. Энэ учраас Улаан армийн дайчин эрс нь фашистын Герман ба Японы империалистийг эсэргүүцсэн хатуу ширүүн дайны өдрүүдэд, өөрийн тугийг бэрхшээл дотор өндрөөр өргөж, түүний дайчин түүхийг өөрсдийн гайхамшигт явдлаар улам улам бэхжүүлсээр байсан билээ.

Зөвлөлт Улсад, дайны домогт их үйлсийг бүтээсэн эрлэхэг эх оронч хүмүүс нь ангийнхаа тугийн дэргэд, өөрийн зургийг авхуулж үүрд дурсгал болгон хадгалуулдаг журамтай байна.

Үүнээс үзвэл анги, нэгтгэлийн байлдааны туг гэдэг бол, цэргийн алдар нэрийн хамгийн эрхэмсэг зүйлийн нэг болох нь илэрхий байна.

Цэргийн хүн, байлдааны тугийнхаа утга, түүний ач холбогдлыг хэдийчинээ сайн мэдэх тутам тэр нь байлдаан тулалдааны ямар нэгэн хатуу бэрх явдал дундуур, тугийнхаа алдрыг улам бадруулахын төлөө ямагт шудрага үйлсийг бүтээж чаддаг юм.

Хэрэв байлдааны цагт өөрийн тугаа алдаж осолдох юм уу, эсхүл дайсанд олзлогдвол тэрхүү хороо ангийн нэр алдарт түүнээс илүү гутамшигтай зүйл байдаггүй юм. Энэ учраас тугаа алдсан анги нь, татагдан бууж, түүний дарга нь хуулийн хариуцлага хүлээдэг журамтай байна.

Иймд тугаа хамгийн нандин хадгалж байх нь цэргийн хүний эрхэм үүрэг мөн. Манай байлдагч түрүүч нараас байлдааны тугийнхаа ариун алдрыг хүндэтгэдэг болгохын тул нам, улс төрийн байгууллагуудаас хийх ажил их байна.

Нам, улс төрийн байгууллагын хамгийн тэргүүн зорилго нь байлдааны тугийн утга учир ба түүнийг хэрхэн хадгалж явах журмын тухай нийт хүмүүст тасралтгүй мэдрүүлэх явдал мөн.

Бас ангийнхаа түүхийг хүн бүрд сайнаар мэдрүүлж, тэрхүү түүхийг бүтээх явдалд нийтийн зоригийг бадруулагч болж явдаг тугаа хүндэтгэх явдалд байлдагч, түрүүч нарыг хүмүүжүүлэн сургах ёстой.

Энэ зорилгоор байлдааны тугийг хүлээн авах ба хадгалах журмыг таниулах, туг бол цэргийн алдрын бэлэг тэмдэг мөн гэх мэтчилэн бусад сэдвүүдээр лекц, улс төрийн сонголыг зохиох, өөрийн анги нэгтгэлийн түүхээр бүх хүмүүстэй яриа хийх, клуб, Сүхбаатарын тасалгаануудад байлдааны тугт зориулсан самбар, лозунгуудыг бичиж гаргах ёстой.

Эдгээр ажлуудыг зохиож, анги, нэгтгэлийн улс төр, байлдааны бэлтгэлийг өндөржүүлэн, сахилга батыг бэхжүүлэхэд байлдааны тугийн улс төрийн утгыг бүрэн мэдрүүлэх ёстой.

Энэ нь манай хүмүүсээс өөрийн нам, засаг, ард түмнийхээ өмнө хүлээсэн үүргээ чин шудрагаар биелүүлж, цэргийн тангаргаа үнэнчээр гүйцэтгэхэд нь туслана.

Энэ нь манай ефицер, түрүүч, байлдагч нарыг байлдааны эрэлхэг хатуужилд сургаж дайчин их ялалтын зүг улам улам удирдан жолоодно.

Монгол Ардын Хувьсгалт Цэргийн бүх албан хаагчдаа! өөрийн ариун алдрын бэлэг тэмдэг болсон байлдааны тугаа хамгийн эрхэмээр хүндэтгэн үзэж түүнийг өндрөөр өргөж явагтун!

Үүнд цэргийн хүний хийморь, сүр жавхлан оршдог юм.

БИБЛИОТЕ

Инт Востоков

АН СССР

БИБЛИОТЕКА

ХАРУУЛЫН АЛБЫГ УЛАМ. ЧАНГАТГАЯ

Манай армийн анги, салбаруудад өдөр бүр олон зуун байлдагч, түрүүч нар, харуулын албанд гарч ард нийтийн ариун өмч, хувьсгалт улсын үнэт их хөрөнгийг хамгаалах онцын хариуцлагатай хүндэт үүргийг гүйцэтгэж байна.

Энэ бол Монгол Ардын Хувьсгалт Армийн дайчин нар, энх цагийн эрхэм чухал хамгийн хариуцлагатай албанд томилогдож, байлдааны үүргийг гүйцэтгэж байгаа юм.

Өөрт өногдсон постыг хамгаалж байгаа манаач бол их эрхийг эдэлдэг бөгөөд жаруулд байх үед өөрийн шадар дарга нарын шууд захиргаанаас гарч халдашгүй байдалд ордог байна. Харуулд гарсан байлдагч, пост дээр өөрийн үүрэг буюу түүнд даалгагдсан байлдааны үүргийг алдартай гүйцэтгэхэд хэн ч, юу ч саад болохгүй.

Манай армид манаачийн үүргийг гүйцэтгэхээр томилогдож байгаа байлдагчийн хамгийн гол эрхэм чанар бол хувьсгалт сэрэмж байх ёстой. Дайсагнагч ангийн этгээдүүд бол хувьсгалт улсын хөгжилд хэзээд өшөөтэй бөгөөд түүний ололтуудыг занаж байдаг тул манай эдийн засгийг хорлох, ард түмний амгалан тайван байдлыг алдагдуулах, цэргийн хүчнийг бууруулах, түүний бүх байдлыг тагнах талаар хамгийн ичгүүргүй элдэв аргыг хэрэглэдэг гэгчийг бид үргэлж санах хэрэгтэй.

Манаач-байлдагч бол өөрийн хариуцсан постыг сэрэмжтэй хамгаалж байснаар, дайсны далдын санаа, ил оролдлогыг няцааж чадах юм.

Байлдагч нар, харуулын албыг сайн гүйцэтгэхийн тул дүрмийн ёсоор өөрийн үүргийг онц мэдэх ёстой юм. Манаач-байлдагч нөхөр Ядамхүү, Дүйнхаржав, Дамбажамц нарын зэрэг олон хүмүүс, харуулын албыг бүх пост дээр хэзээд сэрэмжтэй гүйцэтгэж байна. Тэд Гарнизоны албаны дүрмийн ёсоор оногдсон бүх шаардлагыг сайн мэдэж, тодорхой биелүүлж байна. Бас харуулд гарахын өмнө тэд, дүрмийн үүргүүдээ анхааралтай судалж, зэвсэг ба хувцсыг нарийвчлан бэлтгэдэг байна. Энэ бол санамсаргүй хэрэг биш. Эх орны их итгэмжийг алдартай гүйцэтгэхийн тул манай байлдагч нарын дотор зүй ёсны бахдал төрж байлдааны үүрэг болсон харуулын албыг гүйцэтгэхэд бүх талаар бэлтгэж хариуцлагаа мэдэрч байгааг харуулж байна.

Харуулын албыг бэлтгэх, гүйцэтгэх тухай асуудал бол байлдагч дарга хоёрын анхаарлын төвд орших ёстой. Үүнд, Зөвхөн дүрмийн ерөнхий зүйлүүдийг онол болгон судлах төдийгөөр хязгаарлаж болохүй. Харуулд гарсан хүмүүс, дүрмийн зүйл бүрийг практик ёсоор хэрэглэж чадах нь чухал

байна. Дүрмийг судлах үед байлдагч, түрүүч нарт харуулын албыг гүйцэтгэх дадлагатай болгохыг голчлох хэрэгтэй.

Харуулын захирал ба манааг халагч нар бол постын албанд байгаа байлдагч нар, өөрийн шууд ба тусгай гүйцэтгэх үүргүүдийг зүйлчлэн тодорхой мэдэж байгаа эсэхийг шалгаж илэрсэн дутагдлыг засаж байвал зохино.

Үүнд постод гарахын өмнөх цаг ба амарч байгаа ээлжийн үеийг ашиглаж болно. Мөн үед харуулын албаны хөлбогдол ба цэргийн тангаргийн шаардлага, манаачийн өндөр хариуцлагын тухай утга төгс говч тодорхой яриаг улс төрийн ба цэргийн хүмүүжлийн сэдвээр хийж байх нь хүмүүст нөлөөг үзүүлэх, тэдний идэвхийг дайчлах талаар их тустай байна. Гэтэл зарим ахлах дарга нарын зүгээс үүний тул бололцоог олгохгүй, үүний төлөө санаагаа тавихгүй байдаг нь буруу байна.

Харуулд манаач-байлдагчийн гарах үед үүд, хаалга, цонх, ломб бүрийг нарийвчлан үзэж, шалгаж байх нь хүмүүжлийн ба практикийн их холбогдолтой байдаг юм. Хүлээлцэх үед манаач нар, постын бүх онцлог дээр юу нэмэгдсэн ба ямар нэг сэжигтэй зүйлүүд байсан эссэн тухай харилцан мэдэгдэж байвал зохино.

Харуулын албыг сэрэмжтэй гүйцэтгэхэд ахлах дарга нарын зүгээс хяналтыг тогтмол болгох хэрэгтэй. Тэд, харуулын албаны гүйцэтгэлийг хүн бүр дээр хянах төдийгүй, илэрсэн дутагдлуудыг цагт нь анхаарч, тэдгээрийг түргэн арилгахын тул зохистой аргыг даруй сүвэгчлэх үүрэгтэй байна.

Үүнд зөвхөн дутагдлууд арилаад зогсох биш, тэдгээрийг төрүүлсэн шалтгаануудыг бас устгах нь чухал юм.

Харуулын алба бол, жагсаалын дарга, улс төрийн ажилтан, нам, эвлэлийн байгууллагуудын анхаарлын төвд байнга орших ёстой. Үүнээс гадна нам, эвлэлийн гишүүн бүхэн, харуулын албыг сэрэмжтэй гүйцэтгэх талаар жишээг харуулж, Гарнизоны албаны дүрмийн шаардлага, мөн чанарыг байлдагч, түрүүч нарт өдөр тутам тайлбарлан, яриаг байн байн хийж, анги, салбарын аж байдлаас сургамжтай жишээг өргөн ашиглаж байх ёстой. Харуулын албаны онцчуудын туршлагыг алдаршуулан, өндөр сэрэмжтэй ба эрэлхэг зүтгэлтэй манаач-байлдагч нарын жишээг харуулж байх хэрэгтэй. Харуулын албыг онц гүйцэтгэх нь, хувьсгалч дайчны ариун үүрэг мөн. Эх орны энэ эрхэм их итгэмжийг алдартай гүйцэтгэж хувьсгалт сэрэмжийг улам дээшлүүлье!

ДАВШИХ ҮЕИЙН НАМ, УЛС ТӨРИЙН АЖИЛ

Давших байлдаан бол байлдагчдын санал сэтгэлийн ба биеийн хүчин чадлын хамгийн том шалгалт юм.

Давших байлдааны үеийн нам, улс төрийн ажлын гол зорилго нь байлдагчын дайчин зоригийг өрнүүлэхэд чиглэгдэх бөгөөд анги, салбарын давшилтын явцыг тасралтгүй үргэлжлүүлэхээр зохиогдсон байвал зохино. Зөвлөлтийн ард түмэн, түүний армиас Германы фашистын эсрэг байлдсан агуу их эх орны дайны туршлагаас үзэхэд 'одоогийн дайн нь зөвхөн цэрэг дайны ба тактикийн бэлтгэлээр барахгүй, түүний зэрэгцээгээр нам, улс төр, үзэл санааны бэлтгэлийг онц ихээр шаардахыг үзүүлжээ. Урьдаас сайн бэлтгэж, чадамгай зохион байгуулалттай явуулсан нам, улс төрийн ажил нь дайны үед үр дүнгээ ихээр өгдөг байна. Давшилтад бэлтгэх уед намын байгууллага, улс төрийн аппаратын өмнө тавигдах үүргүүд нь нэгтгэн захирах даргад тусалж анги, салбарыг тулалдаанд бэлхэн болгох явдлыг хангах, нам, эвлэлийн гишүүдийн авангардчилах ролийг өндөр хэмжээнд хүргэх явдал мөн юм. Тайван цагт намын байгууллага, улс төрийн аппарат нь улс төр, байлдааны бэлтгэлийг дээшлүүлэхэд дайны үеийн нэгэн адил чухал ач холбогдолтой. Жишээ нь: тактикийн сургуулийн амжилт бол сургуулийг хангах талаар нам, улс төрийн байгууллагаас хэрхэн чадварлагаар бэлтгэсэн ба улс төрийн ажилтнуудаас тактикийн сургуулийн зорилго ба ажиллагааг аль хир сайн мэдсэнээс үндэслэнэ.

Сургуулийг штабаас төлөвлөсөн өдрөөс эхлэн нам, улс төрийн байгууллагуудаас уг сургуулийг хангах нам, улс төрийн ажлын бэлтгэлийг хийж эхлэх ёстой. Үүнд, юуны урьд нам, улс төрийн ажилтнуудад сургуулийн ерөнхий төлөвлөгөөг судлуулан мэдүүлэх хэрэгтэй. Ингэхдээ штабаас бэлтгэл бүхий офицерыг томилон тактикийн сургуулийг хэрхэн зохион байгуулах, сургуулийн үе шатуудад ямар зүйл дээр онц анхарлыг тавихыг тодорхойгоор мэдүүлэхийн хамтаар суман, батарей, ротын дотор их ажлыг зохиох ёстой. Нам, эвлэлийн гишүүдтэй ажиллах, ухуулагч нарт заавар семинарыг өх зэргээр тэднийг бэлтгэх ба дараагаар давших байлдаанд хэрхэн ажиллах тухай байлдагч, түрүүч нартай яриаг явуулах, давших байлдаанд байлдагчдын үүрэг, түрүүч нар нь салаадын дарга нарын шууд туслагч нь мөн болох тухай мэдүүлэх ба түрүүч нарын туршлагыг солилцуулах, зөвлөлгөөн, яриануудыг явуулах хэуэгхэй. Түүнчлэн офицеруудыг бэлтгэх ажилд туслах ажлыг зохиох, дүрэм ба бусад материалуудаас ярианы ба лекцийн сэдвийг сонгон авч бэлтгэн яриа, лекцийг хийх хэрэгтэй байдаг. Түүнчлэн тусгай мэрэгжлийн салбаруудын

холбоочин артиллерчин, саперчин, танкчин нарт байлдааны ажиллагаа, тэдний үүргийг тодорхой мэдрүүлэх хэрэгтэй.

Одоо зун цагийн сургууль, явагдаж байгаа үед нам, улс төрийн ажлыг зохиохдоо байлдааны төрөл бүрийн ажиллагануудыг хангахад тохируулж ажиллах дадлагыг цуцалтгүй нэмэгдүүлэх ёстой. Давших байлдааны үеийн нам, улс төрийн ажлыг: хүч хуралдуулахаар маршлах үеийн хүч хуралдуулах ба давшиж эхлэх рубежид байгаа үеийн; атакийн ба хориглолтын гүнд байлдах үеийн гэж 3 шатанд хуваана.

1. ХҮЧ НЭМЭГДҮҮЛСЭН МОРЬТ ХОРОО ЗААГДСАН РАЙОНД ӨӨРТӨӨ ХАВСАРГАГДСАН ХҮЧ ХЭРЭГСЛИЙН ХАМТААР ХҮЧ ХУРАЛДУУЛАХААР МАРШЛАХ ҮЕИЙН УЛС ТӨРИЙН АЖИЛ.

Энэ үед нам, улс төрийн аппарат нь өөрийн ажилтнуудыг суман батарейнуудад хувиарлан явуулах бөгөөд тэдгээр нь маршийн үүрэг зорилгуудыг хүн нэгбүрт таниулах үүрэгтэй. Дарга, улс төрийн ажилтан ба ухуулагчид нь амралт ба зогсолтын үед бага дарга цэргүүдэд маршийн үед гарсан ололт дутагдлуудыг хэлж таниулаж маршийн дундуур морьд ба зэвсэг техникийг хайрлан хамгаалах арга ажиллагааны тухай, хажуугийн ба арын хийгээд тэргүүний хамгаалахад гарсан салбаруудад үүргээ сайн гүйцэтгэх ба сонор сэрэмжтэй явж гол хүчтэй холбоог тасралтгүй барих. Морьдод эмээл тоног хэрэглэлийг ба хүмүүст зэвсгийн оосор зэргийг хэрхэн тохируулсныг шалган зааж сургах зэргээр ажиллана.

2. ХҮЧ ХУРАЛДУУЛАХ БА ДАВШИЖ ЭХЛЭХ РУБЕЖИД ЗОХИОХ НАМ, УЛС ТӨРИЙН АЖИЛ.

Нам, улс төрийн байгууллагууд нь байлдааны байдлыг харгалзан ажлыг зохиох бөгөөд хүч хуралдуулах районд хүрэлцэн ирэхийн хамтаар өнгөлөн далдлах арга хэмжээний тухай ба маршийн дүнг гаргах ажлуудаас эхлэнэ. Тэргүүний жишээнүүдийг дэлгэрүүлэн түүгээр нийт хүмүүсийн ажиллагааг жигдрүүлэхийг ихэд эрмэлзэн ажиллах хэрэгтэй. Давших байлдаанд түрүүч, байлдагч нарын үүргийн тухай дахин дахин таниулах ёстой. Сэлэмт сумангууд нь их буу, миномёт, тусгай мэрэгжлийн салбаруудтай хэрхэн харилцан ажиллах тухай яриануудыг хийх эхлэх рубежийг зөвөөр эзлэх тухай бүх хүмүүсийн санаачлагыг дайчлах. Мөн бүх төрлийн зэвсгүүдийг байлдаанд бэлхэн болгох талаар ажлыг зохиох, хүмүүс ба галын хэрэглэлүүдийг окоплох, өнгөлөн далдлах талаар үргэлж туслах, салбаруудад богино хугацааны дотор багтаан нам, эвлэлийн хурал буюу митинг зөвлөлгөөнийг зохиож, даргын тушаалыг биелүүлэхэд гишүүдээс хэрхэн ажиллах тухай хэлэлцүүлэх.

Нам, эвлэлийн үүрийн дарга нар нь өөрсдийн гишүүдэд үүргээ сайнаар биелүүлэх тухай үүргийг тавих, гишүүн бусч-

уудыг өөрсдийн үлгэр жишээгээр дагуулахыг гишүүдэд дүүрэн ойлгуулах, 1 ба 2 дугаар үед үүргээ хэн амжилтгай биелүүлсэн тухай дүнг тодорхойлсон байлдааны хуудсыг гаргах, нам эвлэлийн гишүүд ба ухуулагчид нь галт байр, байлдааны талбар дээр ухуулгын ажлыг тасралтгүй зохиох бөгөөд байлдаанд амжилт олох явдал бол их хүч хөдөлмөр санаачлагаар бүтнэ гэдгийг таниулах, Зөвлөлтийн эх орны их дайны туршлагаас ярих. Үүнд: эх орны дайнд Зөвлөлтийн цэргийн дайчид нь ямар хүнд бэрхийг даван туулж чадсанаас ялалтыг бүтээснийг баримттайгаар ярих. Тасаг, салааны дотор хэн богино хугацааны дотор окоп, галт байраа бэлтгэж чадсаныг судлан, олны өмнө түүний арга туршлагауудыг дэлгэрүүлэх. Ухуулагчид нь сайн үлгэр жишээтэй явдлуудыг өөрийн ухуулгын гол баримт болгох нь чухал юм.

3. АТАК БА ХОРИГЛОЛТЫН ГҮНД БАЙЛДАХ ҮЕИЙН НАМ, УЛС ТӨРИЙН АЖИЛ.

Энэ үед бүх хүмүүст байлдааны үүрэг зорилгыг атакад орохын өмнө таниулах бөгөөд анги, салбарын даргаас тавьсан үүргийг мэдрүүлэх. Түрүүч, байлдагчид нь галын ямар точийг атаклах ба ямар галын тусламжтайгаар хэрхэн давших хэнд хэрхэн туслахыг тодорхойгоор таниулан ойлгуулах. Атакад орох журмыг мэдрүүлэх, Атаклах үед нам, эвлэлийн гишүүд нь биеэр үлгэр үзүүлэн байлдагч түрүүч нарыг дагуулах болно.

Энэ үед цахилгаан хуудсыг сумангийн дотор гаргаж түүнд тэргүүний ажиллагаатай хүмүүсийг бичиж хүмүүсээр дамжуулан үзүүлэх.

Ухуулагчид нь тэргүүний ажиллагаатай хүмүүсүүдийг нийтэд түргэнээр нэвтрүүлэн алдаршуулах, мөн онц анхаарах зүйл нь тусгай мэрэгжлийн салбаруудын ажиллагааг тасралтгүй өрнүүлэхэд нь их туслах ёстой. Ялангуяа холбоочид нь байлдааны бүх удирдлагыг хангах амин судас болохыг онц анхаарах хэрэгтэй. Их буучид нь давшиж байгаа анги, салбаруудад тасралтгүй тусалж, дайсны галын хүчийг дарах ба устгахад хүмүүсийн идэвх хүчийг гаргуулах. Түүнчлэн пулемётчин, миномётчин нарын ажиллагааг давшилттай нягтаар холбох хэрэгтэй юм. Тактикийн сургуулийн дараагаар дүнг тодорхойгоор гаргаж хэн, хэн хэрхэн ажилласан ба ямар ололт дутагдал гарч байсныг хэлж өгвөл зохино. Урьдахь сургууль дээр гарсан дутагдлыг давтахгүйн тулд сургуулийн дараа чухал асуултуудаар семинарыг өх, зөвлөлгөөнийг байгуулах, дүрмүүдийг судлуулах зэрэг ажлыг хийх хэрэгтэй. Намын байгууллага, улс төрийн аппаратуудаас тактикийн бэлтгэлийг амжилттай болгохын тулд юуны урьд даргаас гаргасан шийдвэрийг амжилттай биелүүлэхэд бүх хүмүүсийг дайчилж идэв-

хжүүлэн хөгжүүлэх явдал юм. Хээрийн сургуулийн үед нам, улс төрийн ажил нь салбарууд, хүн нэг бүрт бүрэн хүрэлцэхээр зохиогдох нь гол зүйл мөн.

ГУРВАН ЛИНИЙ ОРОС ВИНТОВ

Өнгөрөгч 4 дүгээр сарын 28-ны өдөр манай үндсэн бөгөөд хүчирхэг зэвсэг болох гурван линийн орос винтовын 55 жилийн ой гүйцсэн юм. Энэ өдрийг Зөвлөлтийн Улаан Арми нь ихэд хүндэтгэн өнгөрүүлэв.

Улаан Армийн олон сонинууд «Гурван линийн винтовын яруу алдар мандтугай» гэж тэмдэглэж байв.

Энэ гурван линийн орос винтов бол Ардын Хувсгалт Цэрэг ба манай мах цусны холбоот ах болсон Улаан Армийн үндсэн зэвсэг нь мөн болно. Гурван линийн орос винтовыг 1891 оны дөрөвдүгээр сарын 28-ны өдөр Тула хотын зэвсгийн заводын үйлдвэрчин Сергей Иванович Мосина гэдэг хүн зохиож гаргав.

Тэр үеэс эхлэн одоо 55 жил болов. Энэ завсар винтов бол өөрийн үүргийг гавьяатайгаар гүйцэтгэж Улаан Армийн зэвсгийн хүчний алдрыг дэлгэрүүлсээр ирлээ. Өнгөрсөн хагас зуун жилийн дотор 4 удаагийн том тулалдааныг туулж ирэв.

Үүнд Порт-Артурийн хамгаалагчид винтовын гал ба жадаар Японы шийдсэн атакнуудыг няцааж байлаа. Дэлхийн нэгдүгээр дайнд Оросын цэргүүд мөн л энэ гурван линийн винтовоор Германы цэргүүдийг бут ниргэж байв. Хувьсгалт Улаан гвардын цэргүүд Зөвлөлт байгууллыг хамгаалан цагааны дээрэмчид ба гадаадын 14 хөрөнгөтний довтолгоог няцааж гавьяаг байгуулсан. Винтовын гал ба жадны хүчийг цагаан Финүүд Карелын хүзүүвчинд ба Япончууд Хасануур, Ханхын голд амсаж үзэв. Зөвлөлт эх орны агуу их дайны баатарчууд энэхүү Тулийн заводын үйлдвэрлэсэн энгийн винтовын бүх хүчийг ашиглан чадаж Германы улангассан цэргүүдийг хяар цохисон билээ.

Монгол Ардын Хувьсгалт цэрэг энэ винтовоор зэвсэглэж, өөрийн бүх түүхэндээ алдраа мандуулан, мөнхийн дурсгалыг байгуулсан юм. 1921 онд Монгол оронд үүрлэн бугшиж байсан гадаадын зэвсэгт дээрэмчдийг бутцохиж, хөөн гаргахад

манай винтовын гал ба жадны хүчийг Хятад, Барон Унгерн-ийн цэргүүд өөрийн арьсан дээр амсаж үзэв.

1939 онд Халхын голын дайнд ба 1945 онд чөлөөлөх ариун дайнд манай винтов нь өөрийн чадал хүчээ Японы эзэрхэг түрэмгий нарт үзүүлэв.

Винтов бий болсноос хойш одоо 55 жил өнгөрөхөд, энэ завсар байлдааны техникууд завсар чөлөөгүй өсөж байсан боловч, тэд олонхи талаараа их буунуудтай төстэй юм. Одоо цагийн цэргийн зэвсэглэлд нэмэгдсэн мивомет, танк, нисэх онгоц, автомат зэрэг бий болов.

Эдгээр шинэ нарийн техникууд нь цэргийн зэвсэглэлд чухал холбогдолтой ба дайны хүчин чадал ихтэй боловч, 1891 оны винтов нь дайны хүчирхэг ач холбогдлоо алдаагүй юм. Тэр ч байтгай өнгөрсөн байлдаануудын туршлага нь, их бага ямар ч тулалдааны амжилт бол үндсэн төрлийн цэрэг болох морин ба явган цэргүүдийн зэвсэглэсэн винтовын гал ба жадаар шийдвэрлэгддэг болохыг нотлон харуулж өглөө.

Винтов бол эдлэхэд энгийн бөгөөд байлдаанд саатдаггүй тул үүргээ шаргуу сайнаар биелүүлж, цэргийн алдрыг ихэд мандуулав. Агуу их тулалдаануудад винтовын бүтээсэн ялалт товойн үзэгдэж бүх дэлхийд цууриатан сонсогдов. Түүний зэрэгцээгээр винтовын мэргэн галаар дайсныг магадтай сөнөөн чадагч мянга мянган мастерууд төржээ.

Одесс, Севастополийн босгон дээр гурван зуу илүү Германыг сөнөөсөн Зөвлөлт Холбоот Улсын баатар Людмила Павличенког мэдэхгүй хүн ховор. Бас Украйнын хоёрдугаар фронтын алдартай онц буудагч ахлагч Шубина 350 Германыг устгасан байна. Бас байлдагч Федосеев бол өөр бусад калибр бууг хэрэглэсэнгүй, ганцхан винтовын хүчээр Квказын ууланд дайны түрүүн үеийн 18 хоногт Германы 96 солдатыг устгасан зүйл бий. Дайсантай тулалдах хэрэгт винтовын байлдааны хүчин чадлыг дархч ёсоор эзэмшин чадсан байлдагчийн яруу алдар нь дэлхий дээр цууриатаж байна.

Чухамхүү энэ учраас манай байлдагчдаас өөрийн гурван линийн орос винтовыг нүдний цөцгий мэт хайрлан хамгаалдаг ба үнэн сэтгэлээс дурлаж дуулалдаа аялж, зохиолдоо уншиж байдаг юм.

Винтов болбол өөрийн насалсан энэ 55 жилийн ойг өнгөрүүлэн, 56 дахь жилдээ давшиж байхдаа байлдагчийн үндсэн зэвсэг болох чадвараа хэрэг дээр үзүүлээд, цаашид гайхамшигт явдлуудыг бий болгосоор байна. Винтовын онц мэргэн буюу, онц хурдан буудагчдын дархч нар төрж шинэ шинэ алдарт үйлсийг бүтээлээ.

Үүгээр манай цэргийн зэвсгийн хүчний чадлыг нэмэгдүүлэн, байлдагч бүрийг өөрийн зэвсэгтээ хайртай, дуртай бол-

гон, түүний бүхий чадлыг дүүрэн ашиглахын хөдөлгөөнд дур хүслийг оргилуулан татаж байна. Улаан Армийн бага дарга Копейкин болбол тав сумалдаг гурван линийн орос винтовоор нэгэн минутад 32 сум буудахад байд 31 сум нь мэргэнээр туссан байлаа.

Энэ болбол винтовын бий болсноос хойш одоо 55 жил болж байхад шинээр гарч байгаа зүйл юм. Үүгээр үзэхэд винтовын байлдааны чадлыг үнэлж баршгүй нь илэрхий. Одоо болбол винтовын гүйцэтгэх үүрэг нь урьд дахь өнгөрсөн үеийн дайны цагийн үүргээс өөр хүнд хэцүүболсон нь мэдээжийн хэрэг.

Одоо цагийн дайнд, дайны талбарт олон янзын шинэ шинэ үүргийг гүйцэтгэх явдал шаардагдана. Жишээлбэл: дайсны бэхэлсэн далдалсан галын цэг точгуудын үл үзэгдэм өчүүхэн (а м б р а з у р) шагайх цонхыг онож буудах үүрэг, бас танк ба хуягт машинын шагайх цонх болох өчүүхэн завсрыг онож буудах, дайны талбар дээр түргэн хөдлөж, хурдан явж байгаа дайсныг сөнөөхөөс гадна, дор орж ирсэн нисэх онгоцыг буудах зэргийн хүнд хэцүү үүрэг тулгардаг болжээ. Эдгээр шинэ үүргийг гүйцэтгэх хэрэгт винтов бол ямар нэгэн өөрчлөлт засварыг шаардсангүй. Харин үүнийгээ алдартай сайхан биелүүлсэн болно.

Винтовын бие ангид энэ 55 жилийн дотор засварлагдаж өөрчлөгдсөн зүйл гэвэл овоо, хараа жадны зэрэг мэргэн тусгалд уялдсан жижиг зүйлүүд өөрчлөгджээ. 7,62 миллиметрийн калибартай винтов бол одоо 1891 оны ба 1930 оны винтов гэж нэрлэгдэнэ.

Цэргийн хүчин чадал нь түүний зэвсэгт байдаг. Цэргийн зэвсэг, винтовын хүч нь түүний галд ба жаданд бий. Тимийн түл өөрийн зэвсэг болох винтовын гал ба жадыг дархч ёсоор эзэмшихийн түл мэрийж, байдаг хүчээ шавхан гаргах зорилго манай дайчин бүрээс шаардагдана.

Манай дайчин бүр өөрийн винтовын жадыг дүүрэн ашиглаж, түүний хүчээр дайсныг сөнөөн цохиж чадахын тул гардан байлдааны олон төрлийн арга зарчмыг судлан мэдвэл зохино. Ялангуяа өөрийн винтовын галыг чухамхүү дархч ёсоор эзэмших хэрэгтэй. Үүндээ Зөвлөлтийн ард түмний эх орны их дайны талбар дээр Улаан Армийн байгуулсан алдарт их туршлагыг судлах ёстой.

Винтовын мэргэн буудлагыг эзэмшихэд юуны өмнө буудлагын дүрэмд заасан үүргүүдийг гүйцэтгэх нь чухал. Харин сум зарцуулан, буудлагын талбар дээр буудахыг чухалчлах, бус бэлтгэл оролдлогыг цаг үргэлж шамдан гүйцэтгэж зохих шатнуудыг дамжиж сургуулилаа судалбал зохино.

Үүний гадна буудагч хүн бол өөрөө биеэ дааж газрыг сонгон олох, дайсныг хянан илрүүлж чадах, түүнийгээ шалгаруулан чадах, санаачлагатай ба шийдвэртэй байх, ийм үнэг

сайхан чанарыг хадгалсан байх учиртай. Тэргүйгээр винтовын мэргэн галыг оновчтой ашиглаж чадахгүй.

Байлдагч нь буудлагын онолын чухал зүйлүүдийг судлан мэдэх нь мэргэн буудлагыг эзэмшихэд их холбогдолтой тул, траектори ба салхины хазайлт зэргийг бардаагаар гаргаж чадах мэрэгжлийг олох хэрэгтэй.

Бид өөрийн цэргийн үндсэн зэвсэг болох винтовоо дархач ёсоор эзэмших ба үүний гайхамшигт чадлыг дүүрэн ашиглан сурахын тул бүх хүчээ дайчлана. Дарга нараас өөрийн захиргааны байлдагч бүрийг винтовын мэргэн буудагч, чадвартай гардан тулалдагч нар болгохын тул их хүчин гаргаж, ажлуудыг зохиогтун!

Мэргэн буудагч нарыг өдрөөс өдөрт нэмэгдүүлэн төрүүлснээр Монгол Ардын Хувьсгалт Цэргийн байлдааны чадварыг өндөржүүлэх ба бүх цэргийн жанжны тушаалыг биелүүлэн чадна.

Винтовын мэргэн буудагч нарыг олноор төрүүлэх эрхэм чухал зорилго нь манай нам, эвлэлийн байгууллагуудын анхааралд байх ёстой.

Нам эвлэлийн гишүүд нь тэргүүний манлайлах хүчин нь болж, гишүүн бус олон түмнийг дагуулан давшуулж, тэдгээрийг мэргэн буудагчийн байранд татан гаргах үүрэгтэй.

Манай хайртай сайхан, хүчирхэг чадалтай винтов бол байлдагчийн итгэлтэй бөгөөд үнэнч нөхөр мөн. Үүнийхээ бүх байлдааны чадал хүчнийг дүүрэн ашиглаж сурцгааяа.

МЭРГЭН БУУДАХАД ТУСЛАМЖ

Онц сайн буудах явдлыг алдагдуулах үндсэн гурван шалтгаан байна.

1. Буудагч хүн өөрийн биеэс гарах шалтгааныг гүйцэд арилгаагүйгээс.

2. Буудах үед зэвсгээ шалган үзэж сайнаар бэлтэгж чадаагүйгээс.

3. Буудах үед, цаг уурын тохиромжгүй байсан зэргээс нөлөөлнө. Үүнийг урьдаас мэдэж тухай бүр засварыг өгч чадвал, онц сайн буудагч болох нь дамжиггүй юм.

БУУДАГЧИЙН БИЕЭСГАРАХ ШАЛТГААН НЬ

1. Тулгуурыг өөрчлөх тутам дундын тусгал тэр ёсоор өөрчлөгдөнө. Винтовоор 100 метр газар хараа гурваас, тулгуур дээрээс буудахад 18 сантиметр хөөрөх ёстой. Харин босоо буудвал 15 сантиметр хөөрөх буюу, оновол зохих тоочкоос 3 сантиметр дор тусна. Өвдөгөөс буудахад 22 сантиметрт хөөрөх ба оновол зохих тоочкоос 5 сантиметр дээр тусна. Ямар ч байдлаас буудахад хэрэв тулгуур дээр тавьж буудах хэрэг тохиолдвол доод бүсний дороос тулгууралбал зохино.

2. Мөрлөгчийн дээд ирэмгээр мөрөлбөр сум нь 100 метр газарт 3 сантиметр дор тусна. Харин доод ирэмгээр мөрөлбөл 4 сантиметр дээр тусна. Хажуу тийш өөрчлөлт үл гарна.

3. Буудагч нь нүдийг харааны ониос хол буюу ойр болгож шагайснаас бас алдана. Үүнийг мэдье гэвэл гинтов бууг хэвтээ тавиур дээр бэхлээд жинхэнэ журмаар шагайгаад дараа нь 25 сантиметр гэдрэг ухруулан шагайвал 5 сантиметр дор шагайсан мэт үзэгдэнэ.

4. Гохыг долоовор хурууны урд үеэр зөөлөн дарж, амьсгалыг дотогш нь татаж хураах хэрэгтэй.

5. Бууны мөрлөгчийг тэгш бөгөөд хөдөлгөөгүй биедээ сайн шахаж тохируулах хэрэгтэй. Гохыг угзарч үл болох ба буудсаны дараа овоо, хаашаа хөдлөгснийг мэдэж байвал зохино. Үүнд овооны хөдөлгөөн тийш сум нь онох болно гэдгийг анхаарах хэрэгтэй.

БУУНААС НӨЛӨӨЛӨХ ШАЛТГААН НЬ

Гол төмрийг сайн арчиж цэвэрлэсэнгүй, сүүл, тулгуур эргүүдийг жигд биш чангалснаас алдана. Жишээлбэл тулгуур эргийг хэтэрхий чангалбал дор тусах, сүүл эргийг хэтэрхий чангалбал дээр тусна. Мөн гол төмрийн ам цохигдсон бол цохигдосны нөгөө чигт хазайна.

Ам задарсан буюу сунаснаас тусгал нь цацралттай болно. Энэ нь бууг арчихдаа хамгаалагчгүйгээр арчсанаас болно. Үүнийг шалгахдаа 7.607 мм-ийн лекол гол төмрийн дотор садгүй гарч байвал зохино. 7,654 мм гийн лекол нь багтахгүй байвал зохино. Мөн гол төмөр нь хуй модны урд үзүүрийн аль нэгэн талд нягт суусан бол тэрхүү нягт суусны нөгөө чигт хазайна.

Жад хөдөлгөөнтэй болсон бол цацралт ихтэй болж алдана. Харин жад гулзайсан бол нөгөө чигт хазайна.

Овоо баталгаа дээрээс хөдөлсөн бол хөдөлгөөний нөгөө тийш хазайна. Харин харааны шат хөдөлсөн бол тэрхүү хөдөлсөн чигт хазайна. Үүнийг шалгахдаа 12-ын тоо дээр тавиад

хоёр тийш аяархан ганхуулж үзнэ. Энэ нь бага хөдөлгөөнтэй байх боловч гарыг чөлөөлөн тавихад уул байрна тогтож байвал зохино.

Сүм удаж, муудсан, гарсан он нь харилцан адилгүйгээс алдаа гардаг байна. Иймд сумыг хүлээн авахдаа сайнаар шалгах хэрэгтэй.

Цаг уурын байдлаас нөлөөлөх шалтгаан нь

1. Хүйтэн, бороотой болох тутам сумны анхны хурд хасагдана. Дулаан болох тутам сумны анхны хурд нэмэгдэх буюу давна. Үүнийг дадлагын хувьд хэрэглэх хялбарчилсан арга нь 1 тоог газрын хэмжээнд тохируулсан хараанаас хасаад санааны 3-аар үржүүлээд, халуун хүйтний градусын хичнээн 10 байвч 10 тутмаас 1-гийг авч үржүүлэх хэрэгтэй. Тэр гарсан тоо хэдэн метр буюу сантиметр дутах, давахыг үзүүлнэ.

Жишээ нь: газрын хэмжээ 600 метр. хасах 30 градусад буудахад, $6-1=5$, $5 \times 3=15$, $15 \times 5=75$ см. тутна.

2. Салхинаас нөлөөх шалтгаан нь хамгийн их байна. 45 градусын буланд 1 секундэд метр үлээх, салхи нь дунд зэргийн хүчтэй салхи юм. Үүнийг дадлагын хувьд ашиглах хялбарчилсан арга нь газрын хэмжээнд тохируулсан харааны 100 тутамд 2, 2-оор бодож үржүүлэн гарсан нь, хэдэн см. тутах ба хазайлгахыг үзүүлнэ.

Жишээ нь $1 \times 2=2$, $2 \times 4=8$, $3 \times 6=18$, $4 \times 8=32$, $5 \times 10=50$, $6 \times 12=72$, $7 \times 14=98$, $8 \times 16=128$. Хэрэв 90 градусын буланд буудвал дээрхийг нэг дахин нэмэгдүүлэх хэрэгтэй.

3. Нарны хурц гэрэл туяанаас нөлөөлөх шалтгаан нь буудагч хүний нүд хуурагдаж муу үзсэнээс алддаг байна. Жишээ нь: 100 метр газар нарны туяа овоо дээр баруун гар тал аас тусаж байвал сүм нь зүүн гар тийш 7 сантиметр хазайна. Мөн эгц тусвал 10 сантиметр дор онох болно.

Харин харааны онийн аль талаас нар тусвал тэрхүү тусан чигт нь сүм хазайна.

Буудах үед эдгээрийг санаж ажиллавал онц сайн буудахад ихээхэн тусыг хүргэнэ.

МОРЬТ ЦЭРГИЙН БАЙЛДААНЫ БЭЛТГЭЛ

Танкийн ба галын хийгээд морин бэлтгэл бол морьт цэргийн байлдааны сургуульд голлох зүйлүүд юм.

Сэлэмт тасаг гэх мэтийн салбарласан жижиг ангийн байлдааны алба, маш олон янз байдаг шүү дээ. Тасаг бол салааны дотор байтугай, хэсүүл, байлдааны хамгаалал, явган хайгуулын групп, хээрийн харуулд явж дангаараа байлдах болдгийг дайны туршлага харуулав. Морьт цэрэг, тэр үүргийг өдөр, шөнө, агаарын аль ч цагт биелүүлэх болдог. Энэ бүгд нийлж морьт цэргийн тактикийн сургуулийг одоогийн байлдаанд олширсон бэрх байдалд хийхийг их шаардаж байна. Морьт цэргийн тэргүүний ангиуд, чухам ийм төлөвлөгөөгөөр сургуулилж байна.

Гэтэл газар бүхэнд ийм байгаа биш, зарим салбарын тактикийн бэлтгэлд маш ноцтой дутагдлууд одоо болтол арилаагүй, бас ч сургуулийг хялбарчлах буюу хааяа нэг офицер, хээрийн сургуулийг хэрэгсэхгүй болж байна.

Жишээлбэл, саяхан ахмад Мельниковын командалсан суманд «хайгуулд гарсан тасаг» гэдэг тактикийн сэдэв боловсруулагдах ёстой байжээ. Сумангийн дарга, түрүүч нартай заах аргын сургуулийг урьдчилан хийсэн боловч, тасгийн дарга нарыг хээр гаргахын оронд элстэй авдар дээр тэдэнтэй хичээллэж тэр дороо, авдрын дэргэд зохиогдсон санамсаргүй хэдэн зүйлийг боловсруулах төдийгөөр хязгаарласан байна. Үүний харгаагаар түрүүч нар, тасгийн байлдааныг удирдах зохистой дадлагыг олсонгүй, салаадын дарга нар ч, бас тийм байдалд оржээ. Тэдэнтэй хийсэн офицерын хичээлүүд ихэнчлэн танхимын дотор, зураг дээр явагдсан учраас тийм хэрэг болжээ. Хорооны дарга ба түүний орлогч нарын группүүд, хээр гарах нь маш ховор байна.

Хээрийн сургуульд дарга дурлахгүй байснаас түүний захирагдагч нарыг сургахад ч зайлшгүй нөлөөлж байна. Ийм дарга нар сургуулийн үүргийг боловсруулахад тохирох газрыг олохоор биеэ чилээдэггүй, харин сургуулийг аль нэг ижил дасал болсон «Алгын чинээ газарт» буюу хуарангийн хавьд хийдэг байх юм. Энэ хоёр удаагийн алинд нь ч тактикийн бэлтгэлийн үүрэг, дүүрэн биш, мөн л өнөөх үхширмэл аргаар шийдвэрлэгдэх болно.

Газрын байдлыг бага хэрэг гэж басамжлах нь, тактикийн үүргийг боловсруулахад хичнээн хортойгоор нөлөөлж болохыг ахлах дэслэгч Матвечукийн салбарын сургуулийн практикаас гарсан жишээ тодорхой харуулж байна. Тэнд ээлжийн ёсоор хээр гарах бүх бэлтгэл, албаны өрөөний дотор явагджээ. Дарга, зураг дээр сургуулийн газрыг бага офицер нарт зааж өгчээ. Салбар, газартаа ирсэн хойно, харин энэ хавьд сургуулийн төлөвлөгдсөн үүргийн ихэнхийг боловсруулж болохгүй байжээ.

Ахмад Смыков, барагцаабал мөн үед, мөн сэдвээр өөрийн сумангийн дотор сургуулийг хийсэн байна. Энэ дарга, ажлыг

өөр янзаар хийж, салбарыг хээр гаргахаас урьдаар сумангийн бусад офицерын хамт мөд болох сургуулийн газрыг эрэхээр гарч, дайсны нисэх онгоцны дайралтын үеээр салбарыг тараахад дадлагыг өх-ба сэргийлэгч нарын алба зэрэг сургуулийн хэдэн үүргийг боловсруулахад боломжтой газрыг олжээ.

Ахмад Смыков тэгж эрж явахдаа «дайсан» болгох төлөвлөгөөг хийв. Сумангийн дарга, сургуульд оролцогч нарын дайны туршлагаас гарсан хамгийн илүү онцгой жишээг хэрэглэж «дайсан» болгожээ. Сайтар бэлтгэснээр сургуулиа их чанартай болгох нь мэдэгджээ. Хээр гараад сургуулийн бүх үүрэг бүүрэн багтаамжаар бүрэн боловсрогджээ. Одоогийн байлдаанд морьт цэрэг, морин ба явган жагсаалаар ажиллах болдгийг эх орны дайны туршлага харуулав. Морьт цэргийг явган жагсаал дотор ажиллуулахаар бэлтгэхэд тун их анхаарах хэрэгтэй. Гэтэл зарим дарга, үүнийг гүйцэд гүнзгий мэдээгүй нь харамсалтай байна. Офицер нар, тактикийн бэлтгэлийн программ бүхнийг шахам зөвхөн морьт цэргийн ажиллахад тохируулахаар хичээх явдал хааяа тохиолдож байна. Ингэж «тохируулах» нь, морьт цэргийн одоогийн байлдааны уг чанарт үндсээр харшилахын дээр дарга нар ба тэдний салбарын бэлтгэлд муугаар нөлөөлөх нь, мэдээжийн хэрэг юм.

Салбар, морин жагсаалаар ажиллаж, сургууль дээр морьт цэргийн жинхэнэ хурд, тактикийн үүргийг биелүүлэхэд гавшгай сайн болохоо харуулсныг бид үзэж байв. Гэтэл удирдагч, тэр суманг явгалж үзэхэд, цэргүүд байлдааны дээд чанарыг тэр дороо алдаж байсан. Давшилтад тэдний ахилтын хурд, маш буурай болж цэргүүд, нэг галт заагаас нөгөөд шилжин ахих, зэвсэг, бага хүрзийг хэрэглэх чадвар огт байхгүй болохоо харуулж билээ. Энэ бүхэн бол байлдааны туршлагыг дутуу үнэлсэн ба морьт цэргийн ганц талаар буруу сургасны шууд харгаа мөн.


Сэлэмт ба пулеметийн салбарыг морин ба явган жагсаалаар ажиллахад адил шаардлагатай сургаж, офицер, түрүүч нарыг, дотогш нь түргэн маневрлаж, байлдааны аль ч эрэмбийн дотор цохиж, дайсны нисэх онгоц, танктай тэмцэж чадахаар бэлтгэж, дадлагатай болгох нь чухал.

Дайны туршлагаас иш татан жижиг салбарыг бэлтгэх үед дайсны ар хударгаар, өөрийн цэргээс тасархай байлдааныг хийхэд морьт цэргийн сургах нь маш чухал. Одоогийн байлдаанд амжилтыг төрөл бүрийн цэргийн нийлсэн чармайлтаар олдог гэгчийг мартаж болохгүй. Энэ учраас сэлэмт салбарыг тактикийн сургууль бүхэн дээр артиллери, танктай харилцан ажиллахад сургах хэрэгтэй. Харилцан ажиллагааг хэрэг дээр, шат дараалан, ялангуяа давшилтад, атаклах ба дайсны хориглолтын дотогш нь байлдах үед боловсруулах хэрэгтэй.

Бас морьт цэргийн байлдагчийн галын соёлыг бүх аргаар дээшлүүлэх нь чухал. Тэргүүний салбарын жишээг авч, бэлтгэх дасгалыг боловсруулахыг голлож бууч, пулеметч нарыг газрын ба агаарын аль ч үесэд дайсныг биеэ дааж мэргэн сөнөөж чадах болгон шаардаж хүмүүжүүлэх хэрэгтэй. Сэлэмт ба пулеметийн салбарын галын сурлага, хэрэв буудлагын ажлыг тактикийн бэлтгэлтэй нягт холбож, хээрийн сургууль бүхэн дээр цэргүүд зэвсгийг хэрэглэх дадлагаа боловсруулж байвал, зайлшгүй дээшлэх болно. Морьт цэргийн хүний байлдааны алба бол морьтой салшгүй холбоотой байдаг юм. Энэ учраас салбаруудын морин бэлтгэлийг тасралтгүй дээшлүүлэх нь морьт цэргийн офицер нарын хамгийн гол үүргийг нэг мөн. Үүн дээр тактикийн ба галын бэлтгэлийн адил ажлын амжилт бол сургуулийг заах аргын талаар зохиож хийх, түүнийг зохих хэрэглэхүүний сууриар хангах офицер нарын чадвартай холбогдох болно.

Өнгөрсөн өвөл олонхи сэлэмт салбар, морийг эдлэх, арчлах талаар үлэмж амжилтыг олсон байна. Манай морьт цэргийн байлдагч нар, унаандаа эрмэг хүмүүс юм. Практикаас үзвэл, морьтойгоор сургуулилахад бэлтгэгдсэн сайн тоноглогдсон тусгай байр, саад, цавчихад зориулагдсан хэрэглэлтэй сумангууд, морин бэлтгэлд хамгийн их амжилтыг олж байгаа боловч, зөвхөн морьтойгоор сургуулилах нь, байлдаанд морьт цэргийн хүнд чухал хэрэглэгдэх дадлагыг өхгүй нь дамжиггүй. Морьт цэргийн хүн, морьтойгоор сургуулилахад чухамдаа зөвхөн анхны сургалтын үеийг үзнэ. Морийг жолоодох, байгалийн саадыг туулах жинхэнэ дадлага бол аяны явдалд олдоно. Зуны сургуулийн ирэх саруудад аяны явдал бол морин бэлтгэлийн үндэс болно.

Одоогийн дайнд морьт цэргийн салбар ба ангиуд, өдөр, шөнө, агаарын аль ч үесэд нүсэр урт аянд явах, хэмжээтэй цагт үсрэлтийг хийх хэрэг болдог. Эдгээр үүргийг амжилттай биелүүлэх нь, агтын бэлтгэл ба аль хир өөдтэй, сургуультай болсныг шүтэх болно. Тактикийн ба морин бэлтгэлийг нягт холбох нь, энэ удаа рольтой байх ёстой. Өнгөрсөн өвөл морьт цэргийн салбарууд, шөнийн аяныг хийж сурав. Агтыг арчлах бүх дүрмийг тодорхой биелүүлэхийг шаардаж, явгалах үед байлдагч нараар дөрөөг тааруулж, эмээл тахыг шалгаж байхыг хатуу хянаж байсан офицеруудтай сумангуудад маршийн сахилга, хэзээд маш сайн байсныг хэлүүштэй. Энэ бол жижиг зүйл ер биш юм. Морьт цэргийн хүн, өөрөө байлдаанд бэлэн байхыг төлөө санаагаа тавихын хамт, өөрийн агтыг байлдаанд бэлэн байлгахыг хэзээд санаж, түүнийг аль болохоор арчлах үүрэгтэй.



ДАВШХАД АРТИЛЛЕРИТЭЙ ХАРИЛЦАН АЖИЛЛАГААГ ЗОХИОХ НЬ

Морьт цэргийн давшилт бол, артиллерийн галын тусламжаар амжилт олдог юм.

Артиллери бол өөрийн гал ба дугуйгаар морьт ангийн давшилтыг дагаж хангадаг юм. Иймийн тул морьт ангийн даргад артиллерийг байлдаанд удирдах, артиллеритэй харилцан ажиллах ажиллагааг тасралтгүй сайн зохиох хариуцлага оногдно.

Морьт цэргийн дарга нь давшин байлдах тушаалыг авсан үеэсээ эхлэн, өөртөө хавсаргагдсан ба туслах артиллеритэй харилцан ажиллах ажиллагааг давших байлдааныг удирдах бэлтгэлийг хийж байхдаа нарийн сайн зохиох ёстой.

Дарга бол, цагийн байдлыг судлаад урьдчилсан шийдвэрийг гаргахдаа артиллерийг байлдах талбар дээр удирдах бэлтгэлийг дүүрэн бодолцдог юм.

Хавсаргагдсан ба туслах артиллерийн галын тусламжаар давшилтын эхлэх байрыг эзлэх явдал, давшилтыг галаар хангах журам, дайсны тор саадыг эвдэж, зам гаргах ажил, танкийг эсэргүүцэх арга хэмжээг, өөрийн урьдчилах шийдвэрийг гаргахдаа хамт шийдвэрлэх нь зүйтэй.

Давших байлдааныг удирдах бэлтгэлийг хийхэд өөртөө хавсаргагдсан галт зэвсэгтэй харилцан ажиллагааг зохион байгуулах тусгай биеэ даасан асуудал заавал ордог. Энэ бол байлдааныг удирдах даргын ихэд анхаарч, тун сайн зохион байгуулбал зохих гол асуудлын нэг мөн.

Даргаас хувийн тагнуулыг хийж, харилцан ажиллагааг зохион байгуулхад ба байлдааны тушаалыг өхөд хавсаргагдсан, туслах артиллерийн дарга нар заавал байлцвал зохино. Тэд, бас өөрсдөө цагийн байдлыг үнэлж, дайсны тухай, газар орны байдлыг судлах үүрэгтэй.

Морьт цэргийн дарга нь хавсаргагдсан, туслах артиллерийн дарга нартай харилцан ажиллагааг зохиохдоо юуны өмнө тэдний илтгэлийг авах хэрэгтэй. Илтгэл, ямар асуудлаар өгөгдөх ёстой вээ? гэвэл:

— Орон тоо, галт хэрэглээийн хангалт.

— Галт ба хянах байр хаа байгаа.

— Ахлах даргаасаа авсан үүрэг.

— Артиллерийн бэлтгэлд оролцох эсэх.

— Морьт цэргийн даргын үүргийг биелүүлэх бэлтгэл цаг.

— Морьт цэргийн даргын мэдэлд шилжих журам, цаг хугацаа.

Хавсаргагдсан, туслах артиллерийн дарга нар ийм асуудлаар морьт цэргийн даргад илтгэлийг өх ёстой. Хэрэв ийм асуудал цөм оролцож, илтгэл өгөгдвөл, морьт цэргийн даргаас байлданы талбар дээр артиллерийн галыг удирдаж, түүнд үүрэг тавихад дүүрэн хангалттай тусламжийг өгч чадна.

Илтгэлийг авсныхаа дараа морьт цэргийн даргаас артиллерийн дарга нарт үүрэг тавина. Үүнд, оролцох зүйл нь:

- Зүг чигийг зааж, газрыг нэрэлж өх. Тэмдэгтээ хэлэх.
- Дайсны тухай.
- Өөрийн үүрэг.
- Давшилтын эхлэх байрыг эзлэх явдлыг артиллерийн галаар яаж хангах.
- Галын заагуудыг эзлэх явдал.
- Атакад орох, гүнд байлдааныг хангах журам.
- Галт байр, түүнийг солих журам.
- Хүч хуралдуулсан гал, хөдөлгөөнгүй хаалт галыг өх зааг.

— Ерөнхий удирдах холбоо.

Галыг нээх, шилжүүлэх, зогсоох.

— Дуудах дохио.

— Дайсны шинээр илэрсэн галын цэргийг заах журам.

— Танкад туслах арга хэмжээг тус тус зааж өх ёстой. Ийм маягаар артиллеритэй харилцан ажиллагааг зохион байгуулна.

Артиллерит үүргийг тавихдаа түүний хүч, галт хэрэглэлийн хангалтыг онц анхаарах нь чухал. Артиллери бол өөрөө давшилтын төрөлтэй, төрөл бүрдээ ондоо ондоо үүргийг гүйцэтгэдэг юм. Жишээлбэл: Давшилтыг хангах үе, атакад бэлтгэх үе, атакад туслах үе, гүнд байлдах үе гэж дөрвөн анги хуваагаад, морьт цэргийн давшилтын үе шаттай дохирч галаараа дэмждэг юм. Иймийн тул морьт цэргийн даргаас артиллерит үүрэг тавихдаа морьт цэргийн давшилтын үе шат, артиллерийн өөрийн давшилтын үе хоёрыг хооронд нь нийцүүлэн бодож, үүргийг зөв тавих хэрэгтэй.

Артиллерит үүрэг тавихад, дарах устгах хоёрыг ялгаж мэдэхгүй, артиллериас устгаж чадахгүй, зөвхөн дарж чадах галын цэгийг, «устга» гэж үүрэг тавих зэрэг дутагдлыг цэргийн техникийг гүйцэд судлаагүй зарим офицерүүд гаргадаг.

Дарах, устгах гэдэг 2 үг бол, хоёр ондоо утгатай үг юм. Хорооны 76 мм ийм бууд, дайсны мод шороогоор хучигдсан, удаан цагийн галын суурийг устга! гэж үүрэг тавивал хэзээ ч биелэхгүй. Харин амбарзураар нь буудаад тоотууды нь жагсаалаас гаргаж чадна. Иймийн тул хорооны 76 мм-ийн буу бол дээрх галын сууринуудыг дарж чадна.

Үүнээс гадна артиллерийн галыг тактикийн талаар дарах устгах, зовоож ядраах, хорих, сохордуулах (утаат сумаар буудах) эвдэж нураах гал гэж 6 төрөл болгож хуваадаг.

Артиллерийн галын энэ төрлүүд бол тус тусдаа өөр өөр үүргийг гүйцэтгэдэг тул байлдааныг удирдаж байгаа дарга нь артиллерийн галыг тактикийн талаар үнэлэн үзэж өөрийн

гаргасан тактикийн шийдвэртэй тохируулан артиллерит үүрэг тавих хэрэгтэй.

«ТАНК ЭСЭРГҮҮЦЭХ ДАВШИЛТЫН» ГРУППИЙГ ЗОХИОЖ СУРЪЯ!

Газрын дээрх ямар ч төрлийн цэрэг ямар нэгэн үүргийг гүйцэтгэж байвч дайсны танкийн дайралтаас хамгаалах найдвартай, халхлалттай байх ёстой гэж байлдааны туршлага сургаж байна. Манай цэргийн ажиллагаанд ямар ч цэргийн анги салбарын даргад танк эсэргүүцэх хориглолтыг зохиох явдал шаардагдаж болзошгүй байдаг. Зөвлөлт-Монголын цэргийн Японыг эсэргүүцсэн дайнд манай механикжуулсан анги, нэгтгэлүүд ширүүн тулалдаанд орж байсан удаа олонтой билээ. Үүнд, дайсны танкийн догшин дайралтыг няцаах, өөрийн танкийн ажиллагааг цагийн байдалд тохируулан мэргэнээр зохиож удирдах зэрэг ажиллагаа ихээр тохиолдож байсныг бид мэднэ. Жишээ дурьдвал: Жан-хиа-хүү (хаалган) хотын төлөө буюу ялангуяа Жан хиа-хүүгийн давааны дэргэд болсон тулалдаан бол хуягт — танкийн шийдвэрлэх дайталт болсон юм.

Тэнд эртнээс батаар хориглон шигдсэн дайсныг ичээнээс нь хөөн гаргаж бут цохих явдалд манай хуягт-танкийнхан онцгой ролийг гүйцэтгэсэн билээ.

Жан-хиа-хүү хотын наадах давааны ба жинхэнэ хотын төлөө байлдаанд Японы дээрэмчид техникийн хүчийг ихээр жигдрүүлсэн хүчтэй сүрхий хориглолтыг хийснийхээ үрээр Зөвлөлт-Монголын цэргийн өөдөөс шаргуу эсэргүүцлийг тавьж байсан юм.

Гэвч, Зөвлөлт-Монголын цэргийн механикжуулсан анги-нэгтгэлүүдийн байлдааны талбай дээр гавшгай маневрлах, дайсны сиймхий талыг сонгон олж гол цохилтыг хийх, галын харилцан ажиллагааг чадамгай удирдсаны үрээр дайсан, бүрэн бут цохигдсон юм.

Ер нь одогийн дайн бол моторын дайн, одоо ямар нэгэн гүрнүүд дайтахдаа хэнд моторын хүч, хүний бэлтгэл их бол тэр нөгөөгөө ялна гэдгийг дайны туршилга батлаж байна. Иймд манай цэргийнн механикжуулсан анги нэгтгэлүүдийн бүх хүмүүсийн мэдрэл мэрэгжлийг улам дээшлүүлэх нь манай байлдааны бэлтгэл сургуулийн түрүүн сууринд орох ёстой.

Ийм учраас «танк эсэргүүцэх давшилтын группүүдийг хэрхэн зохиох ба түүнийг хэрхэн ажиллуулах вээ?» гэдэгтэй товч танилцъяа.

Танк эсэргүүцэх давшилтын» групп бол Зөвлөлт-Германы дайны фронт дээр зохиогдон ашиглагдсан бөгөөд чухал үүрэг гүйцэтгэх ашигтай болхоо байлдааны талбай дээр тодорхой харуулжээ. Анхны үед явган цэрэг дайсны танкийн дайралтыг эсэргүүцэхийн тул гавштай хүч болгож танк эсэргүүцэх их буу, заримдаа хорооны их бууг ашиглаж байсан байна. Эдгээр буу нь давшилтын эхээр буудлагын салбаруудтай явж байдаг ба хориглолтод шилжих үед танк эсэргүүцэх районд орж байрладаг байв. Өөрийн гол хүч хуваагдан хэсэгчлэх үед дайсны танкийн дайралтаас хамгаалах явдлыг хангах, эзлэн авсан газар заагийг өөртөө бататгах, өөрийн танкийн явуулгыг халхлан дэмжих зэрэгт танк эсэргүүцэх хөдөлгөөнт резервийг тусгай бий болгодог байсан.

Гэтэл, байлдааны явцын дундуур зогсолтгүй давшилтыг үргэлжилж байх цагт дайсны танктай дээрхээс өөр аргаар тэмцэх явдал шаардагдаж ирэв. Тэр арга нь ямар арга вээ? гэвэл, дорнод Пруссийн нутагт болсон тулалдаанд гарсан, цэргийг танк эсэргүүцэх давшилтын групптэйгээр хориглолтыг зохиох арга юм. Энэ групп бол дивизийн даргын гарт байдаг галын хүчээр их лут байдаг байна. Тэр группүүд бол өөрийн цэргийн дайсны, танк өөрөө явах их буунуудын дайралтаас халхлан, хамгаалхаар зогсохгүй, харин дайсны эсрэг атак хийхээр байгаа танк, өөрөө явах их буунуудтай учрахыг зорьж байдаг юм. Танк эсэргүүцэн давших группүүд бол буудлагын дивизид анхдугаар эшелонд нь явдаг ба дивизоны өөрөө явах их буу, танк эсэргүүцэх хэдэн батрей, 122 мм-ийн их буу зэргээс бүрдэл болж дивизионы даргын ерөнхий командын дор явдаг юм. Энэ группуудын галын хүч нь явган цэргийн шуурхай давшилтыг хангах ба түүнтэй харилцан ажилладаг байв.

Танк эсэргүүцэн давших группийн ажиллагааны үр дүнтэй байсны нэг жишээг авч үзье.

Зөвлөлтийн буудлагын нэг дивиз, гол цохилтын чигт ажиллаж байв. Дивизийн танк эсэргүүцэх давшилтын групп нь дивизоны өөрөө явах их буу, танк эсэргүүцэх артиллерийн батарей 2. 122 мм-ийн Гаубицийн батарей 2-оос бүрэлдэн ажиллав. Дивиз ба артиллерийн командлагч нар танк эсэргүүцэх давшилтын группийн даргад ерөнхий үүргийг өгч хороодын давших зурвас, дайсны танктай учирч болзошгүй зааг, явган цэргийн давшилтыг дэмжих журам зэргийг тодорхойлон заасан ба явган цэргийн эзлэн авсан заагийг бататган эзэмшихэд гүйцэтгэх үүргийг тодорхой дурьдав.

Дивизийн ёрөнхий давшилт эхэлсний дараахан нэг салбар руу дайсны батальон хүч, дайралтыг хийв.

Дайсны энэ батальон хүч нь 15 танктай байлаа. Тиймд танк эсэргүүцэх давшилтын группийн өөрөө явах их буугийн нэг батарей бүрэлдүүнээсээ гарч байлдааны журамд ороод дайсны танкуудтай тулалдаж 3 танкийг жагсаалаас гаргав. Мөн танк эсэргүүцэх артиллерийн галд дайрагдан бас нэг танк нь эвдрэв. Тэхийн хамт танкийнхаа хойноос давшиж явсан дайсны явган цэрэг бас их хохирлыг хүлээжээ. Дайсны анхдугаар эсрэг давшилт ингэж бутцохигдов. Гэтэл 2 цагийн дараа Германы хоёрдугаар удаагийн сөрөх давшилт 25 танктайгаар эхлэв. Танк эсэргүүцэн давших группийн их буугийн галд, дайсны 4 танк бутцохигдож бусад нь дахин ухрав.

Нэг өдөр дайсан 5 удаа сөрөх давшилтыг хийж Зөвлөлтийн танк эсэргүүцэн давших группийн ба артиллерийн хоороны цохилтод 16 танкаа алдаад цөм тухай бүр няцаагджээ.

Өөр нэг тулалдаанд танк эсэргүүцэн давших гуупүүд нь дайсны сөрөх атакиыг няцаахад оролцоогүй боловч явган цэргийн давшилт ба эзэлсэн газраа бататгаж авхад нь тусалж байв. Давших байлдааны хэдэн өдрийн дотор энэ группүүд, дайсны 3 танкийг устгаж амьд хүчийг ихээр хохируулав.

Дээр гарч байгаа жишээнүүдээс үзэхэд, танк эсэргүүцэн давших группийг зохиож ашиглах явдал өөрийн анги, нэгтгэлийн давшилтыг хангах, дайсны техник ангийн гэнтийн дайралтыг няцаахад эрхэм тустай болох нь илэрхий байна. Иймд манай цэргийн механикжуулсан анги нэгтгэлийн хүмүүс их тулалдааны галын дотор үнэтэй сайн гэж батлагдсан энэ туршлагыг судлан хэрэглэх нь чухал юм.

Их тулалдаанд шалгарсан сайн туршлага бол бидний ялхын уран аргыг баялагжуулдаг юм. Байлдаанд дайсныг аль болох түргэнээр, өөртөө хохирол багатайгаар цохиж устгадаг болохын энэ их туршлагыг сайн судалж түүний дагуу ажиллаж сурахыг чармайх хэрэгтэй.

Монгол ардын хувьсгалт цэргийн зэвсэг техник улам шинэчлэгдэн хүчирхэгжиж байгаа үед түүнийг эзэмшин дайтагч хүмүүсийн чадвар мэрэгжил нь түүнээс хоцрогдож болохгүй. Иймд дайны дундуур гарсан энэ шинэ арга ажиллагааг дүүрэн эзэмшье!

ТАНК, ХУЯГТЫН АНГИУДЫН ГАЛЫН БЭЛТГЭЛ

Танк, хуягтын ангиудын галын бэлтгэлийн программыг хангахад сургуулийг заах арга дадлагын хамтаар, үзүүлэн та-

ниулах хэрэглэл чухал шаардагдана. Гадын бэлтгэлийн сургууль, сургуулийн ба байлдааны машин, бусад үзүүлэх хэрэглэл, буудлагын сургуулийн зохимжтой газар, танкийн полигон, танкийн буудлагын галын талбаруудаар бүрэн хангагдсан байх ёстой.

Үзүүлэн таниулах хэрэглэлийг төрөл бүрийн буу зэвсэгт нь тохируулан хэрэглэнэ. Мөн буудлагын товч мэдэгдүүн ба буудлагын зөв журам, жинхэнэ буудлага ба оролдлогоонд бэлтгэх хэрэгтэй. Жишээлбэл; сургуулийн их буу, пулемет, их буугийн буудлагын хэрэглэл, хараа гэх зэрэг бусад зүйлнийг төрөл бүр дээр нь хэрэглэнэ. Тэхдээ бүх хэрэглэлүүд нь бүтэн ажиллагаатай суралцаж байгаа хүмүүсийн нүдэнд ил үзэгдэхээр зүсмэл талтай байвал зохино.

Их бууны бие анги, ялангуяа замаг, мөн ухралтыг эсэргүүцэх хэрэглэл, замгийн буулгах хэрэглэл, мөн их буугийн буудлагын оньсон анги ба хараа зэргийг зөв тодорхой хийж үзүүлэх хэрэгтэй. Сургуулийн элдэв зураг, буу зэвсгийн бие анги, сүм хараа зэрэг хэрэглэлийн зургийг авлага болох ном, дүрмээс хуулбарлан авч ашиглах нь чухал. Буудлагын зөв дүрэм, товч мэдэгдүүнд суралцахдаа янз бүрийн сургуулийн хэрэглэлийг ашиглах хэрэгтэй. Үүнд их буугийн сумын цацралт (тректори)-ыг үзүүлсэн хэрэглэл сургуулийн хараа, (дуран хараа) харааны зоох суурь, дуран харааны хувиарын зурмал маяг, хайрцагтай элс зэргийг хийвэл зохино. Дуран харааны хувиарын маяг нь суралцан бий хүн бүрт тус бүрт нь байвал сайн. Учир нь сургуулийн удирдагч нь сурагч бүрд янз бүрийн үүрэг өгч буудлагын шийдвэр гаргуулахад туйлын ашигтай.

Буудлагын үүргүүдийг байрнаас, түр зогсолт, явдал дээрээс, сургуулийн байлдааны машинаар бэлтгэхдээ төмөр ба модон байшин, олон хөдлөх, явах, ганхах байшингуудыг хийх хэрэгтэй. Эргэх дугараг конерти, дуран харааны суурь сургуулийн хараа, ил далд ордог бай, нэг точкоос нөгөө точкт шилжүүлэн шахаж тохируулах хэрэглэл, мөн гараар заагч хэрэглэл, сургуулийн буудах хэрэглэл, янз бүрийн байнуудыг ангиуд, өөрийн хүчээр бэлтгэх нөхцөлтэй юм.

Галын бэлтгэлийн онцлог зүйль нь их бууг түргэн цэнэглэх ба буудах ажиллагаа юм. Үүнд сургахдаа сургуулийн хиймэл сумаар сумлаж буудах дадлагыг биеэр хийлгэх нь чухал. Галын бэлтгэлийн сургуулийг удирдахад голлож анхаарах зүйл бол, буу зэвсгийн дэргэд нь тус бүрийн оногдох үүргүүдийг алдаа дутагдалгүй гүйцэтгүүлэхэд чиглэгдэх хэрэгтэй. Галын бэлтгэлд шалгах хэрэглэл ба янз бүрийн тэмдэглэх хэрэглэл их чухал. Энэ нь сургуулийн ба байлдааны машин алин дээр ч бэлтгэл оролдлого хийхэд их ашиг тусыг өгнө.

Бэлтгэл оролдлогыг явуулалхдаа буудлагын талбар дээр

сургуулийн байлдааны машинаар ихэнх хувийг хийх нь хамгийн ашигтай. Харин хааяа танхимд хийхдээ төрөл бүрийн буу зэвсгийн бие анги, сургуулин их буу, дуран харааны хамтаар, бас пулемет эргэх ба буулгах механизм, янз бүрийн тавиур дээр зоогдсон байх ёстой. Бас сургуулийн замаг, ухралтын эсэргүү хэрэглэл, төрөл бүрийн сум, элдэв зургууд их бууны төрөл бүрийн задгай хэрэглэл, галт хэрэглэлийн зүйлүүд байх хэрэгтэй.

Галын бэлтгэлийн талбар бол буудлагын бэлтгэл дадлагыг зөв журмаар суралцахад онц холбогдоно. Мөн танк хуягт машинуудын буу зэвсгээр буудах ба буудаж байгаа зүйлийг хянах болон, газрын хэмжээ ба таних тэмдгийг олход их холбоотой. Цаашид буудлагын талбар дээр агаарын онгоцны бай болон танк хуягтын тусгал ба буудлагын талбарын газар орны ба өөрийн ангийн хир хэмжээнд тохируулан хэдэн хэсэг болгон хувиарлах хэрэгтэй. Газар орны байдалд тохируулан янз бүрийн ил гарч далд ордог ба хөдлөх, төрөл бүрийн байнуудыг зохион байгуулах хэрэгтэй. Хамгийн холын хэмжээ нь 3 км байвал зохино.

Буудлагын талбарын ар талд нь буудлагын төрөл бүрийн бэлтгэлийг суралцах байрыг зохион байгуулна. Тэр байрнуудад бүүгийн бие анги, буудлагын арга маяг болон, бэлтгэл оролдлого ба чиг зүгийг олох, хянах бүх бэлтгэлийг давтан боловсруулах ажиллагааг гүйцэтгэнэ.

Танкийн буудлагын талбар дээр танк хуягтын байлдааны нэг бүрийн ба танк хуягтын буудлаганы газрын хэмжээ, маяг нь тэр ангийн буу зэвсгийн төрөлд тохирсон байх ёстой. Буудлагын талбар бүр нь 1-ээс 2 хэсэгт хуваагдах хэрэгтэй. Нэг бүрийн байлдааны бэлтгэлийн оролдлого, тусгалыг заагч, мөн хамгаалын далдлах байр, янз бүрийн байнууд, төрөл бүрийн тэмдгүүдэд тохируулан байгуулж, танк хуягтуудын пулеметийн хараануудыг тохируулан тусгалыг шалгах байр агаарын дайсныг эсэргүүцэх пулеметийн буудлагын байрыг бэлтгэнэ. Үүнээс гадна буудлагын тайлбарын дунд буудлагын тусгай команд тохио өх ба удирдах өндөрлөг болон галт хэрэглэлээр хангах байрыг байгуулна. Бас буудлага хийгээгүй сүл байгаа хүмүүсийн сургуулийн байр байвал зохино. Аливаа материалаар хангах байр нь бүхий л талаар сурах явдлыг хангасан байвал зохино. Ер нь одоо хүртэл зарим ангийн сургуулилах талбарыг үзэхэд бүх сургуулийн хэрэглэл нь складад хэвтэж байхад сургуулийг ямар ч хэрэглэлгүйгээр ор нэр болгон явуулдаг. Энэ зүйлийг гаргахгүйн тул хатуу тэмцэлийг тавих хэрэгтэй байна. Галын бэлтгэлийг төлөвлөгөө ба материал-аар хангахад ангиудын штаб ба салбар ангиудын дарга нар гол анхаарлыг хандуулах ёстой. Ангиудаас галын бэлтгэлийн төлөвлөгөөг хийхдээ ганцхан сургуулийн байлдааны машин-

ууд биш бүх эд хэрэглэл ба сургуулийн газар болон бүх зүйлүүдийг төлөвлөгөөндөө оруулах хэрэгтэй юм.

Дээр дурдсаныг зөв гүйцэтгэж чадвал манай хуягт танкийн ангиуд нь сургуулийн талаар цэргийн дээд командаас тавьсан үүргийг биелүүлж чадна.

ТАНКИЙН ТЭРГҮҮНИЙ АНГИЙН АЖИЛЛАГАА

Танкийн нэгтгэл, нэг замаар явахдаа тусгай анги хүртэл хүчээр тэргүүний ангийг гаргадаг ёстой юм. Тэргүүний анги бол цагийн байдалтай уялдуулан, гол хүчнээс бүтэн хагасаас хоёр цаг хүртэл зайтайгаар холдож яван тасардаг байна. Энэ юунд чухал болох юм? гэвэл нэгтгэлийн цуваа, нэг замаар явахдаа их дотогшлон сунадаг. Энэ бол хажуу тийш хүчээ задлахын тулд л зөвхөн тохиромжтой байх юм. Фронтын зүгт хүчээ задлах нь, туйлын төвөгтэй болно. Үүнд барагцаалбал, бүтэн хагас буюу хоёр цаг хэрэглэгдэнэ. Тэргүүний ангид томилогдсон анги, тэр бүтэн хагас буюу хоёр цагийн дотор дайсны давуу хүчтэй биеэ дааж байлдахын тулд хүрэлцэх хүчтэй байна. Тэргүүний анги ба гол хүчний хоорондын зай бол хүчээ задлах ба байлдаанд цагтаа ороход нь бололцоог өгдөг.

Хэрэв нэгтгэл, хэдэн замаар явж байгаа бол, цувааны дарга нар, аяны хамгаалахыг томилно. Танкийн ангид 5-аас 8 километр холдож явдаг аяны толгойн хаалт томилогддог юм. Механикжсан ангид бол, тэргүүний ангийн үүргийг гол хүчнээс 5-аас 8 километр зайтай явах толгойн цуваа гүйцэтгэнэ. Тэр цуваанаас аяны толгойн хаалт бас гарна. Механикжсан нэгтгэл, нэг замаар явах үед танкийн нэгтгэлийн адил, мөн зарчмаар ажиллах тэргүүний ангийг гаргана.

Тэргүүний анги, цувааны дотор багасгасан зайтайгаар явна. Танкин тэргүүний ангийн цувааг, чухал хэрэг тохиолдоход, биеэ дааж тус тусдаа байлдаж чадахаар зохиож цувруулан явуулах нь зохистой юм. Ерөөс цуваачилсан байгуулалт бол дайсны атакиыг няцаахад ангийг бүрэн бэлэн байлгаж, тэргүүний ангийн гол хүчийг улам замбараатай задлах бололцоог өгнө.

Тэргүүний анги, тулгарах байлдааныг хэзээд, толгойн хаалтаар хийдэг. Түүнээр халхлуулан тэргүүний анги, гол хүчээ задлана. Хаалт бол нэг чигт сүрхий цохиж, төвөгтэй ма-

неврлах ба сэлгэхээс зайлж ажиллана.

Дайсан ч, бас хажуу ба ар хударгаар гэнэдүүлэн цохихыг эрмэлзэх нь мэдээжийн хэрэг. Энэ учраас тэргүүний ангийн дарга, байлдахдаа хажуудаа хайгуул хийхийг санаж, түүнийг танк — эсэргүүцэх хэрэглэлээр ханган, заавал бэлтгэлтэй байх ёстой.

Толгойн хаалтаар байлдах үед тэргүүний ангийн дарга, хайгуулыг биечлэн хийж, түүний явц дунд байлдах шийдвэрийг гаргана. Тэргүүний анги, дараагийн цувааг тэргүүний цуваатай зэрэгцүүлэн, улмаар фронтын зүгт хүчээ түргэн задлах, түүнчлэн тэргүүний ангийн гол хүчийг байлдаанд цувралдахгүй нэг зэрэг оруулахын тулд ажлыг хийнэ.

Хаалтаас тэргүүний анги хүртэл 5-аас 8 километр зайтай байх нь, түүний гол хүчийг бутархай жагсаалд цагт нь шилжиж, тэднээс явуут хүчээ түргэн задлах болгоно. Хэрэв цагийн байдал, явуут хүчээ задлах бололцоогүй байх юм бол, гол хүчийг гарах газарт бөөгнүүлэх нь зохистой байдаг. Цагийн байдлаар дарга, тэргүүний ангийг байлдаанд цувааны ирэхийн хирээр, дараалан оруулж болох юм. Гэвч тэргүүний ангийн гол хүчийг нэг зэрэг хэрэглэх нь, илүү ашигтай байдаг гэгчийг давтаж хэлье.

Тэргүүний ангийн байлдааны хэлбэрүүд олон янз бөгөөд байлдаан, ямар үесэд үүсч байгаагаас болно. Үндсэндээ барагцаалбал хойно гарах хэдэн тулалдааныг хэлж болно.

Нэгдүгээрт — дайсан цуваагаар явж, харин өөрийн тэргүүний анги, хүчээ задлаж амжаагүй үеэр марш дээр түүнтэй тулгарах болно. Тэргүүний анги, дайсны цувааг явуутаар бутаргаж бутарсан ангийг бие биеэс нь салангад болгохын тулд түүнийг явуутаар шийдэмгий атаклахыг эрмэлзэнэ. Тэргүүний ангийн дарга, тэдгээр ангийн заримыг эсэргүүцэн ихэнх хүчийг бөөгнүүлэн, бусад ангийг эсэргүүцэн хаалтын туслах ажиллагааг хийнэ.

Хоёрдугаарт — дайсан, хүчээ урьдаар задалсан байхад, сонгомол газарт галт хэрэглэл, танкийн олонхийг байлдаанд цочмог оруулах нь, даруй онцгой холбогдолтой болно.

Гуравдугаарт — дайсан, хүлээж байж ажиллахаар болж, хориглолтод шилжсэн байвал, байлдаан, хурдавчлагдсан бэлтгэлтэйгээр давших шинжийг олно.

Дөрөвдүгээрт — дайсан байлдахгүй, ухрах энэ удаад тэргүүний анги, шийдэмгий давших ба мөрдөхөд даруй шилжинэ.

Тэргүүний ангийн даргын мэрэгжил бол тулгарах байлдааны болзошгүй хэлбэрүүд ба тэдгээрийн магадгүй өөрчлөлтийг мэдэхэд бас оршино.

Тэргүүний анги, хэзээ ч дайсныг цохиж, түүний гол хүчинд хүрэхийг эрмэлздэг ба дайсны тоогоор илэрхий давуу байхад зөвхөн хориглолтод шилжиж, энэ тухай ахлах даргад

даруй мэдэгдэнэ. Нэгтгэлийн дарга, тэргүүний ангийн байлдааныг артиллери, танкаар дэмжихийн тулд арга бүхнийг хэрэглэнэ гэгчийг хэзээд анхаарах хэрэгтэй.

Танкийн буюу механикжсан тэргүүний ангийн ажиллагаатай холбогдох ерөнхий зүйлүүд ийм байна.

ТАНКИЙН ШӨНИЙН АЖИЛЛАГАА

Өнгөрсөн дайны туршлагаас үзэхэд танкууд бусад төрлийн цэргүүдийн нэгэн адил шөнийн цагт ажиллах нь ерийн үзэгдэл болжээ. Төрөл бүрийн зэвсгүүдийн бөөн галыг дагалдуулсан, танкийн сайн бэлтгэлтэй шөнийн атак нь дайсан этгээдэд хүчтэй нөлөөг үзүүлдэг байв. Шөнийн цагт ажиллагааг нуун далдлах, гэнэт сочмог болгоход хялбархан байдаг байна. Гэвч үүний улмаас танкийн шөнийн ажиллагааг өдрийн ажиллагаанаас илүүтэй дээр юм гэдэг дүгнэлтийг гаргаж болохгүй. Энэ асуудлыг шийдвэрлэх бүрд цаг үеийн тодорхой байдлыг харгалзах хэрэгтэй.

Танкын шөнийн байлдааны амжилт нь их төлөв хүмүүсийн дадлага, тулалдааны зохион байгуулалт, танкыг ашиглахад уул газар орны байдал аль хир хүнд бэрэхтэй болох эдгээрээс нөлөөлөгдөх болно. Шөнийн ажиллагаанд томилогдсон анги-салбаруудын нийт хүмүүсийг бэлтгэхдээ гол төлөв уул тулалдааныг хийх гэж байгаа газар орны байдалтай адил өөр нэгэн газар дээр тэднийг бусад төрлийн цэргүүдийн хамт сургуулилуулах замаар гүйцэтгэнэ.

Жишээлбэл: . . . дугаар гвардийн танкын ангийн туршлагаас авч үзэхэд энэ анги нь Ново-Михайловскийн районд нэгэн давшилтыг хийхээр бэлтгэхдээ моторжуулсан явган цэргийн хамтаар дөрвөн удаа сургууль хийсэн бөгөөд түүний хоёрыг шөнийн цагаар хийжээ. Эдгээр сургуулийг хийхдээ явдал дундаас буудах, түргэн атаклах ба саадыг түргэн давах, түүнчлэн танкуудыг моторжуулсан явган цэргийн дисанттай харилцан ажиллах, эдгээр асуудал дээр онц анхаарлыг тавив.

Уул атакын бэлтгэл ажлын явцаар эхлэх байраас дайсны хориглолтын өмнөт захыг хүргэл явах замыг нарийвчлан судалжээ. Шөнийн харанхуйг ашиглан танкын бүх номерууд нь эдгээр явах замуудыг очиж үзэв. Ангийн офицерын бүрэлдэхүүн нь нийт цэргийн нэгтгэлүүдийн ба бууч ангиудын дарга

нарын хянах байр дээрээс тасралтгүй хяналтыг хийх замаар дайсны хориглолтын галын системийг нарийвчлан судалжээ. Танк, явган цэрэг, их буугийн дарга нараас хамтран газар орны байдлыг судлах үеэр харилцан ажиллах асуудлыг тодорхой боловсруулсан байв. Тийнхүү газар орныг судлах үедээ ангиудын үүргийг тодорхойлон нэгтгэсэн томиолол, галын цэргүүдийн схемийг тогтоосон билээ. Явган цэрэгтэй харилцан ажиллах төлөвлөгөөний дотор цэг заах ба харилцан туслалцах тохиог тогтоож танкуудаас өөрийнхөө явган цэргүүдийн байлдааны журмын дундуур өнгөрөн гарах газруудыг тодорхой тэмдэглэсэн байв. Дайсны хориглолтын урьд зах ба гүнд байгаа танк эсэргүүцэх хэрэгслийг устгах үүрэг их буучин нарт оногдов. Бэлтгэл ажлыг нарийн нямбай хийсний дунд... дугаар гвардийн танкын анги нь дайсны нилээд шаргуу эсэргүүцлийг давж, өөртөө тавигдсан үүргийг амжилттай биелүүлэв.

Хүчийг далд хуралдуулах ба гэнэт сочмог цохих явдал бол шөнийн цагт танкыг олон дахин атакт оруулбал гэнэт сочмог байдлаа алдаж, дайсны зүгээс сөрөх арга хэмжээг авахад өргөн бололцоотой болгодог байна. Ажиллах газар, атаклах чиглэлтийн хувьд дайсныг төөрөгдөлд оруулахын тулд бид нар танкыг өөр районд аваачиж хүч хуралдуулж байв. Энэ нь бидний хүссэн хэргийг бүтээж өгсөн бөгөөд дайсан этгээд, өөрийнхөө танкууд ба танк эсэргүүцэх хэрэгслийг тэрхүү районуудад хуралдуулав.

Өнгөрсөн дайнд гэрэлтүүлэх хэрэгслийг өргөнөөр хэрэглэж байсан явдал, танк нь өмнөт захын ойролцоо нууц хуралдуулах ажиллагааг бэршээлтэй болгож байсан ба заримдаа тулалдааныг эхлэхийн өмнө дайсан этгээдээс танкийг илрүүлэх учир дарга нар ба штабууд нь атакын гэнэт сочмог цохилтыг хангахын тулд, бэлтгэл ажлын үед ба тулалдааныг явуулах үед өнгөлөн далдлах арга хэмжээг онц анхааралтайгаар боловсруулан биелүүлдэг байв.

Шөнийн байлдаанд танкууд нь хууль мэтээр явган цэрэгтэй хамтран ажилладаг байв. Гэвч танкууд нь явган цэрэггүйгээр ажиллах бололцоотойг дайны туршлага батлан үзүүлсэн бөгөөд харин танк сөнөөгч нар ба танк эсэргүүцэх бууны номеруудтай тэмцэх үүргийг гүйцэтгэхээр тусгай сургуулилсан дисанттай заавал хамт явахыг шаарддаг байна. Танкыг ийм аргаар ашиглах явдал нь танкын ангиудыг дайсны хориглолтын байлдааны гүнд ажиллах ба дайсныг мөрдөн хөөх үед зохимжтой байдаг юм.

Шөнийн цагт танкыг явган цэрэгтэй хамтран ажиллахад нь (Салла, рот) зэрэг жижиг хэсгээр нь тасдан бууч салбаруудад хавсаргаж өгнө. Танкын хуяг дээр харанхуйн дотор тод харагдах томиолсон таних тэмдгийг тавина.

Явган цэрэг нь танкуудын хооронд түүний хойноос давшна. Танкуудын газрыг баримжаалах хөнгөтгөхийн тул гэрэлт тохиог ашиглан атаклах чигийг явган цэрэг вааж өгнө. Аргагүй цагт танкчин нарын баримжааг заахад фарын гэрлийг богино хугацаанд ашиглаж болно.

Танкийн атаклах чигийн баримжаа тодорхой хадагдах зүйл байвал зохино. Шөнийн маневр их хүнд байдаг тул түүнээс зайласхийх хэрэгтэй. Хэрэв цагийн байдал ийм маневрыг шаардах ахул үүнийг гүйцэтгэхдээ туршлагатай офицер, сайн бэлтгэгдсэн экипаж (Салбар)-ыг ашиглавал зохино.

Танк бол шөнийн цагт гол төлөв аль болох ойролцоо зайг барьж богино замыг эрмэлзэнэ. Танкаар атаклахын өмнө дайсны танк эсэргүүцэх их буугийн ажиллагааг бууруулах арга хэмжээг авах нь чухал. Шөнийн атакийн амжилт нь проектораар гэрэлтүүлсэн чиг уруу ажиллахад ихээхэн нэмэгддгийг туршлага үзүүлэв. Ер гэрэлтүүлэх хэрэгслийг чадвартайгаар ашиглавал дайсны санал сэтгэлд ихээхэн нөлөө хүргэдэг байна.

Танкийн ба механикчилсэн ангийн үргэлжилсэн шөнийн байлдааныг биеэ даасан хориглолтод ба дайсны хориглолтын гүнд идэвхтэйгээр ажиллах мөрдөн хөөх зэргэд голдуу явуулж байлаа.

Жишээлбэл: Танкийн нэгэн нэгдэл германыг 12 хоногийн дотор өдөр шөнөгүй мөрдөн хөөв.

Танкийг шөнийн хориглолтын байлдаанд явган цэрэгтэй хавсран сөрөх атакад ашиглаж байсны хамт сөрөх атакад ороход танкийн салбар хамгийн тэргүүнд байрнаас дайсныг галаар гарздуулж өгдөг байна. Ер хориглох байлдааны танкийн ашигтай гол бол байрнаас гэгээтэй байхад бэлтгэсэн хэмжээнд галлах явдал мөнийг тэмдэглэх хэрэгтэй. Энэхүү хэмжээт газар нь тэнгэрийн хаяанд ялгаран харагдах баримжаагаар тэмдэглэгдэх хэрэгтэй.

Гэрэлтүүлэх хэрэгслийг танкийн хориглох байлдаанд ашиглахдаа гэрэлтүүлэх журмыг урьдаас боловсруулсан байвал зохино.

Хориглох байлдаанд танкийг чадвартайгаар ашиглахад урьдаас гүйцэтгэсэн хэд хэдэн арга хэмжээ шаардагдана. Үүнд хүлээх байрнаас эхлэх байранд очих замыг тагнах, буудах хэмжээт газрыг бэлтгэх, сөрж атаклах чигийг мэдэх зэрэг болно. Явах замыг нарийнаар төлөвлөсөн байвал зохино. Шөнө ба өдрийн цагт харилцан ажиллах ажиллагааны асуудлыг газрын байдал дээр боловсруулна. Ангийн бүх хүмүүс өөрийн явган цэрэг, их буу, танкын саад хаа байгааг сайн мэдвэл зохино.

Танкийн ба механикжуулсан ангийн шөнийн марш бол цаашдын гэнэтийн ажиллагааг урьдаас илрүүлснээр хангагдана.

Түүнээс гадна одоогийн гэрэлтүүлэх хэрэгсэл ба хяналт нь шөнийн цагт нисэх онгоцны тагнуулыг хийх бололцоог дайсанд өгдөг байна. Иймийн тул шөнийн маршийг зохиоходоо өнгөлөн далдлах арга хэмжээнүүдийг сайтар боловсруулах нь чухал болно.

Хөдөлгөөнийг маршийн сахилгад хатуу захируулана. Танк ба салбарууд маршид ойрхон зайтай давшина. Мөргөлдөх явдлаас зайлалхийж өмнө яваа танкийн ард шөнө 20—30 метр газар үзэгдэх тэмдэг хийнэ.

Шөнийн маршийг зохиоходоо дайсантай тулгарч болзошгүй учир бид голдуу цувааны толгойд механикжуулсан явган цэргийн салбарыг танк эсэргүүцэх бугаар хүч хавсарган гаргадаг. Механикжуулсан салбарын дарга өөрөө явах их буу ба танкийн салбарыг явуулана. Ийм журам бол зөвхөн механикжуулсан явган цэрэг шөнийн цагт сайн баримжааллаг, хардаг төдийд биш юм. Дайсны цуваанд похилтыг учруулахаар өөрийн давших байгаа танкийг замаар нэвт атаклуулан ашиглана.

Шөнийн ажиллагааг зохиож байгаа штабаас удирдалгыг тасалдуулахгүй байлгахын тул хэд хэдэн арга хэмжээг боловсруулбал зохино. Штабын офицеруудын захиргааны анги, салбаруудтай амьд холбоотой байх асуудал ажил дээр өргөн хэрэглэгдэв. Штабын офицерууд анги, салбарууд дээр байж тэдний ажиллагааг шалган тухай бүр өөрийн штабт мэдээлж байлаа. Пуужинг удирдлагын хэрэгсэл болгон ашиглахдаа хатуу дүрмийг тогтоох хэрэгтэй. Тэхгүй бол будлианд учруулж харилцан ажиллах ажиллагааг гажуудуулна.

ТАНК ЭСЭРГҮҮЦЭХ ХОРИГЛОЛТЫН СИСТЕМД ИХ БУУГИЙН АЖИЛЛАХ НЬ

Танк эсэргүүцэх хориглолт бол одоогийн бүх хориглолтын үндэс мөн.

Түүнийг хангахын тул олон янзын системийн ба 45 м.м-ээс эхлэн дээш калибрын артиллерийн ихбуунууд хэрэглэгдэнэ.

Танк эсэргүүцэх районы буюу зангилгааны бүрэлдэхүүнд багтах ихбуу бүр, галт байранд тавигдахдаа тэр ихбуу ба зэргэлдээ их буунуудын хооронд харилцан ажиллах галт холбоо, 100-гаас 800 метр зайтай байвал зохино.

Буугийн дарга нь салааны даргаас байлдааны үүргийг авна. Үүнд: Их буугийн галт байрын газар танкийн аюултай чиг их буугийн хариуцах галт сектор, нэмэгдэл галт сектор, галыг нээлгэх дохио, дайсны үзэгдэхэд их буу, биеэ дааж галыг нээх зааг, зэргэлдээ их буунуудыг галаар халхлах ба галт байруудыг солих журмууд заагдсан байна.

Салааны даргаас үүргийг авмагц, буугийн дарга нь, өөрийн тоот нарын хамт шөнийн цагт галт байрыг засаж эхлэнэ.

Танк эсэргүүцэх их буугийн галт байр бол «өвөртэй» өөр-өөр хэлбэл галлахгүй үед их бууг далдлах ба их буугийн сам ба хэлтэрхийд оногдохоос сэргийлэх зорилгоор их бууг хамгаалалтын хамт байлгах гүнзгий окоп бүхий малтмал хэсэг талбараас бүрдэнэ.

Их буугийн окоп бол хажуудаа тоот нарыг далдлахын тул 1 м. 70 с. м-ээс доошгүй гүнзгий нүх, байлдааны хэрэглэлийг хадгалах, агуулахын тул зойруудтай байвал зохино.

Галт байр бол газрын ба агаарын дайснаас газрын ерөнхий байдалд зохилдон маш сайн далдлагдсан байх ёстой.

Хэрэв нэг шөнийн дотор окоп засагдаж эс амжвал, зөвхөн дараахь шөнөөр ажлыг үргэлжлүүлж болох бөгөөд харин засах талаар гүйцээгүй ажил, өдөр далдлагдсан байвал зохино.

— Буугийн дарга, хариуцах ба нэмэгдэл секторууд дээр янз бүрийн заагуудад хэдэн баримжааг олж тэдгээрийг хүртэл холын зайг нарийвчлан хэмжиж дараа нь танк эсэргүүцэх хориглолтын карточкийг зохиох үүрэгтэй.

Олсон баримжаанууд ба тэдгээрийг хүртэл холын зайг их буугийн бүх тоот мэдэж байх ёстой.

Окопыг засаж дуусмагц, их буу шөнөөр галт байранд тавигдаж «өвөрт» нуугдана.

Окопын нүхүүдэд дурантай хянагчийн үүр байна. Хариуцах ба нэмэгдэл галт секторт дайсны танк ба түүний нийт ажиллагаа, бас салааны дарга буюу батареин даргын дохиог ажиглах хяналт өдөржин шөнжин тасралтгүй явагдана.

Бүх тоот нараас хянагч нарт ээлжээр томилогдож ээлжийн хянах үүргийг пост дээр байх цагийн манаач нарын адил шилжүүлж байна.

Их буу бол бэлтгэгдсэн, харааны хэрэглэл ба танк эсэргүүцэх хэрэгслүүд нь шалгагдсан байвал зохино.

Хадгаламж ба зойронд байгаа байлдааны хэрэглэлийг даруй бэлтгэж цэвэрлэж, хонгио зэрэгт хонхорхой цөмөрхий байгаа эсэхийг шалгаж байх ёстой. Учир нь энэ бол буудахад саад учруулж болох юм. Капсюлын хэрэгсэл, дэлбэлэгч зэрэг нь гүйцэд бэлэн эсэхийг бас шалгах хэрэгтэй.

Дайсны танкуудыг атаклахын өмнө танк эсэргүүцэх хориглолтын их буу, ондоо ямар ч галт үүргийг гүйцэтгэхэд оролцохгүй, өөрийг юугаар ч илрүүлэхгүй байна.

Дайсны танкийг атаклах үед танкуудыг ил хараагаар буудах газарт ойртож ирэхэд буюу тэдгээрээс зэргэлдээ их бууг атаклахад, түүнчлэн салаа (батарейн) даргын дохиогоор дарга, өөрийн галт секторт биеэ дааж галыг нээнэ.

Их буу бол танкуудыг урьд галаар устгаагүй байвал, тэдгээрийг галт байран дээр шууд гартал танкуудыг дайруулан, түрш галлана.

Даргын хэрэглэсэн түрүүчийн танк буюу их бууд ойролцоо яваа танкийг дайруулан галалбал зохино.

Их буу, галт байрыг зөвхөн салаа (батарейн) даргын командаар буюу урьдын хийсэн төлөвлөгөө ёсоор сольж болно.

Танк эсэргүүцэх их буугийн бүх хүмүүс, шийдэмгий, зоримог, амиа хайрлахгүй эрэлхэг байж хадах, их буугийн эцсийн сум ба тоот нарын сүүлийн хүнээ дуустал дайсны танкуудтай тэмцэхэд бэлэн байх ёстой байна.

БУУДЛАГЫН БАТАЛЬОН, ТУЛГАРАХ БАЙЛДААНД

Хушууч Жамцын анги, «Хүч нэмэгдүүлсэн буудлагын батальон, марш ба тулгарах байлдаанд» гэрэг сэдвээр тактикийн сургуулийг хээр гарч үйлдэв. Батальон, танк, их буу, сапериин салбаруудаар хүч нэмэгдэж өөрийн ажиллагаанд онгоцны дэмжлэгийг хүлээжээ.

Марш, тулгарах байлдааныг зохион байгуулах ба удирдахад анги, салбарын офицер нарыг дадлагажуулж, зуны улиралд үйлдсэн тактикийн сургуулийг нэгтэгж бэхжүүлэх, ангийн бүрэлдэхүүний дотор жижиг салбар, хүмүүсийн ажиллах чадвар мэрэгжлийг бэхжүүлэх, эдгээр бүх ажиллагаагаар зуны улиралд хэрхэн бэлтгэдсэнээ бүх цэргийн жанжны шалгалтын өмнө үзүүлэхэд, сургуулийн гол зорилго оршиж байв.

Сургуульд оролцсон бүх анги, салбарууд сургуулийн бэлтгэлийг тун давчуу хугацаанд хийсэн боловч офицер, түрүүч, байлдагч нарын өндөр эрмэлзлэлийн үндсэн дээр амжилттай бэлтэгж чадсан учир, тактикийн хээрийн сургууль сайн чанартай болов.

Цэлмэг огторгуйг, битүү үүл бүрхэж ширүүн бороо, тасалдалгүй орж байсан нь цагийн байдлыг нилээд хүндрүүлж байв.

Гэвч өнгөрсөн дайны туршлагыг удирдлага болгож, байл-

дааны бэлтэглийн бүх зарчмаар сургуулилж сурсан манай байлдагч нар, ийм үед маршийг зохиоход хамгийн ашигтайг сайн мэдэж байв.

Үүр дөнгөж хаяарч байхад сургуульд оролцох бүх анги, салбарууд, эхлэх байранд гарч, тэнд офицер нар, маршийн бэлтэглийг техник, зэвсэг, аж ахуйн хангалт, хүмүүсийн хувцас хэрэглэл ба төхөөрөмжийн талаар шалгав. Улс төрийн орлогчид, намын байгууллагын дарга нар, ухуулагчдаас цагийг ашиглан маршийн зорилго, сахилга бат, цагийн байдал, хүмүүсийн үүрэг, сургуулийн ажиллагааны төрөл бүрийн дохиог машин бүрд тайлбарлаж цахилгаан хуудас нэг машинаас нөгөө машиныг дамжигдан уншигдаж байв.

Танк, их буугаар хүч нэмэгдүүлсэн моторчилсон анги, дайсны агаар, танк, газрын дайралтыг няцаах ба хүчээ задлахад бэлнээр цуваана замд орж, маршаар хөдлөв. Маршийн явдал дунд урьд тогтоосон дохиогоор тархалт хийж агаараас хамгаалах, танкийн дайралтыг няцаах, талаар байлдагч нар туйлын чадамгай ажиллаж байв. Түргэн дохиогоор маршийн явдал дундаас байлдааны журамд гэнэт шилжих, машинаас бууж, байр эзэлхэд байлдагч нар сайн сургагджээ.

Моторчилсон ангийн марш, хатуу сахилга, нарийн зохион байгуулалтын үндсэн дээр амжилттай хийгдэж байсан бөгөөд «дайсантай» гэнэт тулгарч, хүчээ түргэн зуур задлахын хамт атакад шилжив.

Явган цэргүүд танкийн хойноос дагаж, түүнээс огт салалгүйгээр газрын байдлыг ашиглаж атакад зоригтой орцгоов. Хүч нэмэгдүүлсэн батальон өөрийн зохион байгуулалттай атакаар «дайсны» толгойн отрядыг бут цохиж, түргэн хориглолтод оров. Тэгснээр эзэлсэн байраа бэхжүүлэн, өөрийн гол хүчнийг хүрэлцэн ирж хүчээ задлах хүртэл «дайсны» давуу хүчийг барьж байх сургуулийн үүргээ амжилттай биелүүлэв.

Хушууч нөхөр Жамц, моторчилсон ангийн маршийг сайн бэлтгэлтэй, нилээд чадамгай удирдаж хавсаргагдсан хүчнүүдтэй харилцан ажиллагааг дадамгай зохиожээ.

Үүнд: Сургуульд оролцсон бүх офицер, түрүүч, байлдагч нар цагийн бэрхшээлтэй байдлын дотор зориг эрмэлзлэлээ дүүрэн гаргаж, сургуулийн бүх ажиллагаа, тавигдсан үүргийг сайн гүйцэтгэж байсныг тэмдэглэх хэрэгтэй байна.

ХОЛБООЧИН НАРЫН СУРГУУЛИЙГ ЧАНАРТАЙ ЗОХИОЕ

Манай холбооны ангиудын телефончин ба утсан холбоочин нар нь өнгөрөгч өвлийн улиралд нэг бүрийн ба тасаг командын бэлтгэлийг үндсэнд нь боловсруулав. Одоо зуны улиралд салбар ангиудын бэлтгэлийг боловсруулж, өнгөрсөн өвлийн сургуулийг улмаар давтан практик дээр судлах ёстой.

Холбооны салбар ангиуд нь үндсэндээ морьт, явган, механикчилсан анги, салбаруудын ба тэдгээрийн харилцан ажиллагаа, удирдах явдалд холбоог тасралтгүй байгуулах үүрэгтэй. Ийм учраас морьт цэргийн байлдааны ажиллагааны байдал дээр өөрийн холбооны төрлийн бэлтгэлийг холбон зохиож, морьт ангийн бэлтгэл сургуультай мөр зэрэгцэн суралцах ёстой.

Морьт цэрэгтэй нягт холбоотой ажиллан тэдний сургуулилах цагийг мэдэж өөрийн сургуулийг холбож явуулах нь чухал байна. Утсан холбооны ажиллагааг сайжруулахын тулд ангиудын холбооны дарга нар, штабуудаас зуны улирлын сургуулиудад, морьт явган цэрэг ба их буу, хуягт, танк, нисэх онгоцны ангиудтай хээр гарч тэдний хоорондын харилцан ажиллах асуудлыг боловсруулахад чиглэгдсэн бат бэх, радио ба утсан холбоог байгуулж чадах тийм бэлтгэлүүдийг хангах ёстой байна.

Телефончин, шугам холбоочин, радиочин нарын сургуулийн амжилтын нэгэн нөхцөл нь төлөвлөгөөг нарийн тодорхой хийх явдал мөн. Сургуулийн ерөнхий программыг баримтлан сэдэв бүрд тохируулан хийсэн төлөвлөгөө бол сургуулийн амжилтад их тусыг хүргэнэ.

Зуны улирал бол радиочин ба утсан холбоочин нарын сургуулийг хээр олон янзаар зохион байгуулахад их бололцоог өгдөг. Бас радиочин нар ба утсан холбоочин нарыг шөнийн цагт газар орны ба цаг уурын олон төрлийн байдал дээр ажиллуулж сургах нь чухал болно.

Зөвлөлтийн ард түмний эх орны их дайны туршлагаас үзвэл, утсан холбоочин нь холбоог ганцхан өдөр зохион байгуулаад зогсох биш, шөнийн цагийг ашигладаг байжээ. Иймийн тул, холбоочин шөнийн сургуульд хангалттай цагийг оногдуулан сургууль дээр бүх хүмүүсээс тус тусын үүргийг сайн гүйцэтгэж чаддаг болгох хэрэгтэй. Зуны улиралд цэргүүдийн сургуулийг хээр зохион байгуулсан дарга нар, командлах удирдах талаар ихээхэн дадлагыг олгодог юм, Ялангуяа холбоо байгуулах систем, зургуудыг бүрэн мэдэж практик дээр сургуулилснаар дайны үед чадвартай ажиллаж чадах болдог юм.

Байлдааны үед дайснаас манай ангиудын холбоны шугамыг таслах, саатуулах аргыг хэрэглэдэг тул хээрийн сургуулийн үед шугамд элдэв саад хэрхэн тохиолдох, түүнээс яаж хамгаалах тухай байлдагч нарыг тасралтгүй сургах нь онц тустай байна.

Утсан холбооны мэрэгжлийн офицеруудын дадлага туршлагыг дээшлүүлэхэд ихээхэн анхаарлыг гаргах хэрэгтэй. Үүнд ямар нэгэн шинэ сэдвийн хичээлийг боловсруулахдаа юуны өмнө үзүүлэх хичээлийг явуулдаг байх нь сайн байдаг. Жишээлбэл: сүүлийн үеийн шинэ телефоны аппаратын тухай боловсруулах бол холбооны салбар ангиудын дарга нараас эрхлэн бусад дарга нарт үзүүлэн таниулах сургуулийг явуулбал зохино.

Утсан холбоочин нарын тактикийн ба техникийн бэлтгэлийг дээшлүүлэхдээ сапёрын ажиллагаануудыг хамтаар зохион сургуулиудыг явуулах хэрэгтэй. Холбооны ба ялангуяа утсан холбоочин офицерууд бол холбооны бүх техникийн хэрэглэлийг сайн мэдэж түүнийг ашиглан чадах, эвдрэл гэмтлийг олох, засаж чаддаг байх, холбоог удирдах чадвар, техникийн бэлтгэлийн онол ба практикийг гүнзгийгээр судалбал зохино.

Холбооны техникийг зөв мэдэж ажиллуулан жолоодох талаар шинэ өндөр амжилтыг олох хэрэгтэй. Өвлийн улиралд техникийн хэрэглэлийг бие дээр нь хичээллэж байсан бол одоо салбар ангийг бүхлээр хээрийн сургуульд гаргаж, бүх номеруудын хамтаар практик дээр ажиллах болно.

Иймийн тул бүх техникийн хэрэглэлийг хээрийн ажиллагаанд бэлтгэн байгуулж чадах дадлагыг олох хэрэгтэй. Зуны улирлын сургуулийн үүргийг амжилттайгаар шийдвэрлэх нь ихэнхдээ түүний бэлтгэлээс шалгагдана. Иймд бүх бэлтгэлийг нарийнаар хангах хэрэгтэй.

Телефончин, утсан холобоочин нэг бүрийн өмнө техникийн бэлтгэл сурлагаа дээшлүүлэн цэргийг байлдаанд холбооны талаар бүрэн хангах мэрэгжлээ улам нэмэгдүүлэх нь шаардагдаж байна.

МОРЬТ СУМАНД ЗОХИОХ ХОЛБОО

Байлдаанд амжилт олохын нэгэн чухал нөхцөл нь салбар ангиуд, байлдааны талбар дээр болж байгаа явдлыг харилцан сайн мэдэлцэж чадах нягт холбоотой байхад оршино.

Сумангийн дарга, өмнө тавигдсан байлдааны үүргийг байлдагч нэг бүрт зөвөөр мэдрүүлэх ба байлдааны ажиллагааг, өөрт оногдсон хэрэглэлийг ашиглах буюу хоолойгоор удирдана. Бас цаг үргэлжийн тогтоосон дохио, бие зарлага зэргээр холбоог барьж болно.

Сумангийн даргын нь зэргэлдээ анги ба хавсаргасан хүчний танк, их буугийн салбаруудыг байлдааны хувиралтын дундуур харж чадах газрыг сонгон олж командын байрыг байгуулах ёстой.

Командын байр бол, агаарын ба их буугийн галаас хамгаалагдсан бөгөөд явган зарлага, холбооны нохой хүрэлцэн ирэхэд ямар ч саадгүй газар байх хэрэгтэй юм.

Салаануудаас ирсэн холбоочдыг тус тусын дохио сигналыг хүлээн авч болох газарт, сумангийн даргаас 15 метрээс холгүй байрлуулах хэрэгтэй. Командлалаас ирсэн телефончин ба агаарын мэдээчин нь 10-аад метр буюу сумангийн даргатай нэгэн окопод ч байрлаж болно.

Хянагч бол сумангийн даргатай хамт байрлаж, дайсны галын цэг, өөрийн байлдааны ажиллагааг хянаж байх ёстой. Сумангийн жагсаалын дарга, сумангийн даргатай ойр байрлаж дохио сигналын ёсоор салаадад галт хэрэглэлийг нийлүүлэн өгч байх болно. Хэрэв суман нь нисэх онгоцтой харилцан ажиллавал, онгоцтой харилцах өдөр шөнийн тусгай дохио тэмдгүүдийг тогтоож түүнийг хэрхэн гүйцэтгэх тухай салааны дарга нарт хэлж өгнө.

Хориглон байлдах суманд зохиох холбоо

Хориглох байлдаанд сумангийн даргаас харьяа дарга нартайгаа холбоог сайнаар зохион байгуулах нь их рольтой. Холбоог зохион байгуулахын тулд командын жинхэнэ ба бэлтгэл байрыг сонгон авч хянагч нарыг томилно. Командын бэлтгэл ба жинхэнэ байр нь дайсныг цаг үргэлж хянаж болох, мөн зэргэлдээ ангиудтайгаа нягт холбоотой байж болох газар байх ёстой. Телефоны буудлыг сумангийн даргатай нэгэн окопод буюу түүний ойролцоо газар байгуулна. Салбарын дарга нартай явган зарлага, нүдэн холбоог ашиглан харилцах ба хүч нэмэгдүүлсэн салбар буюу зэргэлдээ ангитай явган зарлага, дохио сигналаар харилцана.

Давших байлдаанд зохиох холбоо

Давших байлдаанд сумангийн дарга нь бүх чиглэлүүдийг хангаж чадахаар холбоог зохион байгуулах бөгөөд ялангуяа эсрэх атакад орох буюу дайсныг бүслэн цохиход тун чадамгай зохион хангах нь чухал юм.

Давших байлдаанд танк, их буу, пулеметийн салбаруудыг харилцан ажиллахаар буюу хүч нэмэгдүүлэн өгсөн байвал холбоог нь маш нарийн зохион байгуулалттай бөгөөд бүх ангиудтай тасралтгүй харилцаж чадахаар зохиох нь чухал. Давшихын өмнө давших тушаалыг өхдөө салааны дарга нарт заавал мэдэгдвэл зохих зүйлүүд нь:

А. Давшилтыг эхлэх үед командын байр хаана байх ба цааш ямар чигт хаана байрлах.

Б. Галт хэрэглэлийн ба хүн эмнэлэг хаана байрлах.

В. Давшилтыг эхлэх цаг ба өх дохио юу болох.

Г. Агаар, химийн дайралт болоход өх дохио ба явган цэрэг, танк, онгоцтой харилцан ажиллах дохио сигналыг хэлж өгнө.

Хэрэв танк ба их буутай хамтран ажиллаж байгаа бол, тэр ангийн даргатай өөрийн биеэр ярилцаж зохих дохио сигналуудыг тогтооно. Зэргэлдээ ангитай тасралтгүй холбоотой байх ёстой. Дайсанд ойртож байгаа үед миномет, их буу, танкийн салбартай явган зарлага буюу сигналаар харилцана. Урагш гарсан байлдааны хамгаалалт ба тагнуултай явган зарлага дохио сигналаар, зэргэлдээ ангитай явган зарлага, дуу, чимээний хэрэглэлээр холбоог барина.

Давших үед салаануудтай явган зарлага гэрэл дохионы ба дуу чимээний хэрэглэл зэргийг ашиглан харилцана. Шинэ командын байранд шилжихдээ урьдаар дохио, хянагч ба хамгаалалт хийх хүмүүсийг явуулна. Хүч нэмэгдүүлэн өгсөн танктай нүдэн холбоо ба бусад пуужин гэрэлт сум зэрэг хэрэгслийг ашиглан харилцана. Атак эхлэх үед холбоо нь зөвхөн хоолой буюу шүглээр гүйцэтгэгдэнэ. Энэ үед дарга өөрийн биеэр үлгэрлэх ажил хамгийн гол ролийг гүйцэтгэнэ.

Давшиж байгаа дайсныг тодорхой хянаж болох газрыг сонгон авч хяналтыг явуулбал зохино. Дайсан өөрийн байдлыг өөрчлөх буюу шинэ зүйл гарах хийгээд, давшихад саад учруулж байгаа бөгөөд түүнийг өөрийн, хүчээр дарж чадах нөхцөлгүй болбол телефон зэрэг холбооны хэрэглэлээр өөрийн дээд командлалд илтгэнэ.

Шөнийн ажиллагаанд чимээний хэрэглэл буюу ам команд нь ашиггүй болно. Шөнийн цагт явган зарлага гэрэл дохионы хэрэглэлүүдийг ашиглана. Гэвч гэрэл дохионы хэрэглэлийг зөвхөн ар талд хэргэлж болно. Шөнийн давшилт хийхэд газар орны байдалд тохируулан хэсэг хэсэг газруудыг тэмдгэлж тэр газартаа тогтмолоор холбоо барих нь ашигтай.

Автоматын суманд зохиох холбоо

Автоматын суманг бүтнээр буюу заримдаа салаагаар нь ашигладаг. Автоматын суманг хэрхэн ашиглах нь тэр үеийн

үүрэг ба байдал дээрээс болдог. Автоматын суманг удирдах нь, түүний өмнөх зорилгыг тодорхой ойлгуулахад оршино. Үүнд:

А. Дайсны байралсан байрыг газар дээр нь буюу тэмдгүүдийг зааж хэлж өх.

Б. Автоматч нарын ажиллагааг тодорхой мэдүүлэх.

В. Цагийн хувиарыг яг баримтлан ажиллагааг зохион байгуулах.

Г. Автоматчны цугларах байрыг зааж өх.

Д. Тэргүүлэн явах группийг томилох.

Е. Даргын явах байрыг тодорхойлох зэрэг болно.

Автоматын сумангийн аяны байдлаар явахад дарга нь удирдах салааны дэргэд явна. Бүх сумангийн хүмүүс нь удирдах салааны ажиллагааг хянаж явах хэрэгтэй юм. Автоматын суманг байлдаанд удирдах холбоо нь дуу чимээ, өөрийн биеэр үлгэрлэх явдал болно.

Цугларах байр ба холбооны байрыг тэр газар орны ба дайсны байдлаас үндэслэн сонгож авна. Холбооны байранд салааны дарга ба түүний туслах нар байна. Холбооны хэрэглэлийн нэгэнд автоматын богино урт ээлжийн галыг ашиглаж болно. Шөнийн цагт гэрэлт сумыг хэрэглэнэ.

Буудаж дохио өх явдлыг автоматчин нэг бүр онц сайн мэдсэн байх нь чухал болно.

Байлдаанд амжилт олох гол нөхцөл нь сайн зохиогдсон холбоо мөн гэдгийг манай офицер бүр хатуу санаж, тактикийн сургууль бүр дээр холбоог зохион байгуулах дадлагыг үйлдэж байх хэрэгтэй байна.

ИНЖЕНЕРИЙН ХЭРЭГЛЭЛИЙГ ЗӨВ АШИГЛАЯ!

Цэргийн инженерийн ажил, одоогийн дайнд их ач холбогдолтойгоо олон удаа үзүүлэв. Байлдааны үед инженерийн цэргийн гүйцэтгэх үүрэг улам нэмэгдсэний адилаар, бусад төрлийн цэргээс инженерийн бүх арга хэрэглэлийг эзэмшин ашиглах явдал шаардагдаж байна. Зөвлөлтийн эх орны их дайны туршилга ба Японы эзэрхэг түрэмгий нарыг бут ниргэхэд оролцсон манай армийн байлдааны туршилгаас үзэхэд дайсны байгуулсан элдэв саад, газар нутгийн бэрхшээлийг туулахад инженерийн талаар онц дадлага туршилгатай байхыг

манай бүх хүмүүсэд сургасан байна. Манай офицер, түрүүч, байлдагч бүр инженерийн талаар өөрсдөдөө шаардагдах үүргүүдийг сайнаар гүйцэтгэх мэргэжлийг олж чадвал байлдааны үед дайснаас байгуулсан элдэв саад хийгээд газар орон дээр байгаа ямар нэгэн саад бэрхшээлийг түргэн хугацаанд туулан давж чаддаг байна.

Байлдааны үед тохиолдох үүрэг бол ихэнхдээ инженерийн ямар нэгэн асуудалтай холбоотой байна.

Ийм учраас байлдагчаас эхлэн манай бүх хүмүүс инженерийн хэрэгт мэргэжсэн байх ёстой. Инженерийн талаар биелүүлэх үүрэг бол зөвхөн тэр ажлыг хариуцсан хүмүүсийн хэрэг биш, харин армийн дайчин бүрийн эзэмшиж гүйцэтгэх гол үүргийн нэгэн нь болж байна.

Манай олон төрлийн цэрэг инженерийн талаар өөртөө тохиолдож болох ажиллагаа бүхнийг судлах ёстой. Ялангуяа анги салбарт инженерийн талаар олгогдсон бүх багаж хэрэгслийг чадамгай ашиглах, түүнийг зөв эдэлж сургах явдал юуны өмнө чухал шаардалга болж байна. Манай нэгтгэлүүд ба анги салбарууд нь өөр өөрийн гүйцэтгэх үүрэгт тохирсон инженерийн элдэв багаж хэрэгслийг эзэмшиж байна. Байлдааны үед тохиолдох инженерийн үүргийг зөв бөгөөд түргэнээр шийдвэрлэн, түүнийгээ амжилттай биелүүлхэд тайван цагийн сургууль дээр их хүч гаргаж шамдан оролдох нь чухал байна. Манай анги салбаруудад инженерийн арга дадлагыг суралцаж байгаа нь байлдааны цагийн гүйцэтгэх үүргийг ихээр хөнгөлж өх нь эргэлзэлгээгүй, гэвч инженерийн талаар гүйцэтгэх үүрэг, инженерийн ажлыг төрөл ангиар нь судалсан төдийгөөр, байлдааны үед инженерийн хувьд оногдох үүргийг бүрэн биелүүлж чадахгүй. Харин инженерийн бүх төрлийн багаж зэвсгийг нарийн судалж түүнийг зөвөөр ашиглан хэрэглэж сурах нь чухал байна.

Манай ангиудад инженерийн бэлтгэл хичээлийг зохиохдоо байлдааны бусад төрлийн бэлтгэлүүдтэй холбох, өөртөө байгаа инженерийн хэрэглэлийг гүйцэд ашиглдаггүй байна. Бас инженерийн бэлтгэлийн талаар оршиж байгаа гол дутагдал бол түүний элдэв төрлийн багаж зэвсгийг сайнаар ашиглахгүй ба хайрлан хамгаалдаггүйд оршино.

Доржпаламын нэгтгэлийн харьяа анги салбаруудад инженерийн багаж зэвсгийг зөвөөр эзэмших ч байтдугай хайрлан хадгалж байх журмыг сүрхийгээр зөрчсөн явдал олон удаа үзэгдсэн байна. Ялангуяа байлдагч, машинын жолооч нараас өөртөө оногдсон хүрз зэрэг малтах багажийг олноор хаяж үрэгдүүлсэн, эвдэж гэмтээсэн явдал их гарчээ. Энэ бол инженерийн багаж зэвсгийг зөвөөр эдэлж, байлдааны талбайдээр ашиглах аргад хүмүүсийг сайн сургаж, дадлагыг олгоогүйн

улмаас инженерийн хэрэгслийг өөрийн винтов сэлмийн нэгэн адил үзэж хайрлах ажиллагааг хийдэггүйг харуулж байна.

Байлдагч, түрүүч нарыг инженерийн талаар дадлагажуулан сургаж офицер нараас инженерийн асуудалд зохистой анхаарах явдлыг сулруулснаар зарим ангид инженерийн бэлтгэлийг зохих шатнаа хүртэл дээшлүүлж чадаагүй байна.

Бас байлдагч нар байлдааны төрөл бүрийн сургуулийг хийж байхдаа инженерийн талаар өөртөө шаардагдах үүргийг биелүүлхэд хамгийн чухлаар хэрэглэгдэх байлдааны жижиг хүрзийг биедээ авч явах түүнийг зохистойгоор ашиглахын тул анхаарлыг тун багаар гаргах явдал зарим салбарт үзэгдсээр байна. Байлдагч хүн байлдааны талбар дээр хэрэв жижиг хүрзгүй байлдахад хүрвэл өөрийн үүргийг алдартайгаар биелүүлэх ч байтугай дайсны сумаас биеэ хамгаалж чадахгүйд хүрдэг нь дайны олон удаагийн туршилганд тодорхой байна. Байлдагч бол өөрийн жижиг хүрзийг амь шигээ хайралж түүгээр байлдааны талбай дээр ажиллах хэрэгт онц мэргэжлийг олсон байх нь түүний ялалтад их тусыг хүргэдэг байна.

Японы зээрхэг түрэмгий нарыг бут ниргэх байлдаанд манай зарим байлдагч нар жижиг хүрзийг зөв ашиглах, офицерүүд өөрийн анги салбарт байгаа инженерийн багаж хэрэгслийг хэрхэн яаж хайралж эдлэх туршлагыг биерээ олсон. Энэ туршилга бол байлдагч, түрүүч, офицер нарыг олон зүйлд сургасан байна.

Бид байлдаанд олсон туршлагаа санаж инженерийн багаж зэвсгийг хайрлан хамгаалах, ашиглах аргыг гүйцэд судлахын төлөө хамаг хүчээ дайчлах ёстой.

Инженерийн ажиллагааг нарийн судалж багаж зэвсгийг чадвартай ашиглах мэрэгжилд сайн дадлагыг олж, түүнийг байлдааны төрөл бүрийн байдалд тохируулан ашиглаж чадахгүйгээр одоогийн байлдаанд амжилтыг олж чадахгүй! Офицер, түрүүч, байлдагч бүр инженерийн хувьд өөртөө оногдох үүргийг онц сайнаар судалж, түүний багаж хэрэгслийг хайрлан эдлэх мэргэжлээ улам дээшлүүл! Энэ бол манай их амжилтыг улам бэхжүүлэхийн чухал нэгэн хэсэг нь мөн!

ТАЙГА, НАМАГ ДУНДУУР ДАВШСАН НЭГ АНГИЙН САПЁР НАРЫН БАЙЛДААНЫ ЗАМ

Сапёрын мэрэгжлээс өөр цэргийн нэг ч мэрэгжил, тийм олон зүйлийн мэдлэг, чадварыг байлдагчаас шаарддаггүй байна.

Манж газарт болсон байлдаанууд, сапёр-байлдагч бол юм болгонд гартаа дүйтэй мэрэгжилтэй байх ёстой гэдгийг бидэнд мэдрүүлжээ.

Японтой дайтсан эхний өдрүүдэд нэг батальон, командын байруудыг засаж байсан юм. Тэдгээрийг уулархаг газарт байгуулах болж, тэнд барилгын хэрэглэгдүүнийг олоход туйлын хэцүүгийн дээр бас авчирахад улам бэрх байжээ. Байлдагч нар, түүнийг холоос үүрч ирж байлаа. Хэдий тийм боловч, бүтэн хагас хоногийн дотор бид газар дор 12 штабын байрыг хийж амжсан.

Офицерүүд энд том хэмжээний барилгын ажлыг хязгаартай цагт захиох туршлагыг олжээ. Ялангуяа, ротын дарга ахлах дэслэгч Бугаков, Пугачев, салааны дарга дэслэгч Чудинов, Черняев нар үүргээ амжилттай гүйцэтгэв.

Байлдаан өрнөхийн хирээр, сапёруудын өмнө тулгарсан үүргүүд хэцүү болж байлаа. Дэслэгч Чудиновын хайгуулч-сапёруудын салааны нэг тасаг, бууч нэгтгэлийн офицерийн хайгуултай, бас ондоо хоёр тасаг түрүүний хороодтой тус тус хамт явж билээ. Нэг рот хажуугийн хороотой яван, хаах хурдан отрядын албыг гүйцэтгэж байв.

Сапёрууд үнэхээр буйд, зэрлэг газраар явж, давшигч цэргүүдэд замыг олох ёстой байжээ. Тэд зөвхөн компасаар удирдуулж, тайгын шугуй, бамбалзуур намгийг гаталж явжээ.

Гэтэл цэргүүдэд хамгийн тохирох замыг олж тэмдэглэх төдий хэрэг биш байв. Замыг сайжруулж байлдааны техникийн явахад тааруулах хэрэгтэй байжээ. Хүний хөл хүрээгүй газарт сапёруудын тусламжтайгаар артиллерич, автомобильч, ердийн хөсөг ч гарч чадав.

Сапёруудын группүүд дархийг тас хөрөөдөн, хажуу тийш нь зайлуулан түрүүлж явав.

Тэдний хойноос танкууд дагалдан явж, модыг эвдэн унагаж зам гаргаж билээ.

Танкийн хойноос тэр замаар сапёрууд явж, замыг цэвэрлэн байлаа.

Замын ихэнх тун сүрхий бартаатай газраар дайран өнгөрч байсан юм. Түүнийг сайжруулах гэж бид хамгийн эгц өөд ба руу газрыг тэгшилж байв.

Энэ ажил дээр нөхөр Буцановын рот шалгарав. Түрүүч Кочергин, Кудаев, Чесноков, Битюков, жагсаалын цэрэг Ожегин, Кульжебенев нар онц тэсвэртэй, санаачлагат дайчны ёсоор ажиллав.

Засмал замд хүрмэгц сапёр нарын өмнө шинэ үүргүүд тулгарав. Түрүүний ангиуд өнгөрмөгц, бид замыг засаж эхлэв.

Сапёрууд замын километр бүрд хонхорыг битүүлж, хоолой, гүүрийг засаж байлаа.

Энд бид «хийгүй» ажиллах аргыг хэргэлсэн нь: Зам дээр өөрийн оногдолт газрыг засаж дууссан жижиг анги, урагшаа даруй очиж байлаа. Энэ арга бол тодорхой зохиохыг шаардаж бүх офицер, түрүүч нараар ганц ч байлдагчийг нэг ч минутадаж ажилгүй байлгахгүйн төлөө ажиглуулах болгожээ. Батальон, командлалын бүх даалгаврыг амжилттай биелүүлж, бид бас ажлын хугацааг эрс хорогдуулж байв.

Н. гэдэг хотын ойр газрыг түргэн урсгалт өргөн гол хөндлөн гарчээ.

Даргын хайгуул олмыг эрж, голын эх, адгаар явав. Голын гүнзгий 90 см-ээс хэтрэхгүй тийм газрыг их төвөгтэй олж чадсан боловч, урсгалын хурд секундэд 4—5 метр байв. «Дайны өмнөх» хэмжээний ёсоор ийм түргэн урсгалтай голыг олоор гаталж болохгүй. Гэвч энд удаашрах ба давшилтын хурдыг саатуулж бас болохгүй байсан тул, бид энэ хавиар голыг гатлах гэж шийджээ.

Гүүрийн дэргэдээс ган утас олдov. Байлдагч нар түүнийг гол дээр хөндлөн татаж, дараа нь гатлуурын ойрын газрыг хэргэлжүүлэв. Эндхийн газрын хөрс хөвсгөр байжээ. Энэ хавийн газрууд их бууны хүндийг даахгүй, түргэн эвдрэн нурана гэгчийг урьдаас мэдээд, бид нөөц гатлуурыг эртнээс бэлтгэв.

Гатлуурыг аюулгүй болгохын тул, байлдагч нар тун их хянуур, шаламгай байх хэрэгтэй болов. Бид энд бүх их буу, хүнд ачаагаа голоор гаргаж чадсан бөгөөд гатлуур дээр нэг ч осол гараагүй билээ.

Хот хавийн газрыг японууд мина түүлжээ. Сапёрууд үүнийг илрүүлээд, минийн талбар дундуур гарах газрыг цэвэрлэж эхлэв. Энд ефрейтор Лесик, Гнедов, Жалымбеков нар шалгарч өөрийн оногдолт газар дээр давшигч нарын ахилтын хурдыг өчүүхэн ч бууруулаагүй тийм богино хугацаанд бүх минийг арилгажээ.

Минийг арилгах ба цаашид хотоор давших үед сапёрууд Японы отрядуудтай ширүүн тулалдах хэрэг болжээ. Энд манай байлдагч нар эрэлхэг, мэргэн бууч болохоо үзүүлэв. Тэд гардан байлдаж цөөнгүй японыг алав.

Энэ ялсан аянаас байлдагч нар өөрсдөө дүнг гаргасан нь: сапёр бол «юм бүхэн бүрдсэн» мэрэгжлийн дайчин байх ёстой.

Бид уул, тайгатай газарт цувааны замыг давахын их баян туршлагыг олж ямар ч баримжаагүй тайга дунд зүгээ алдалгүй олохыг сураад, замыг түргэн сэргээх ба усан саадыг дамжих гатлуурыг хийх дадлагыг олжээ.

Сапёрууд зам ба суурин газрын минийг сайнаар арилгаж байжээ.

Лян дуусмагц, офицерүүд өөрсдийн жижиг ангиудад то-

дорхой дүнг гаргаж түрүүч, байлдагч тус бүрийн ажиллагааг үнэлэж билээ. Эдгээр дүн бол манай байлдааны туршлагыг цуглуулж нэгтгэхийн үүсвэр мөн.

Одоогийн сургуулийн жилд бид энэ туршлагыг практик сургууль дээр бүрэн хэргэлж, олон янзын бэрх үүргийг биелүүлж чадах манай цэргийн дайчны мэрэгжлийг шингээсэн шинэ боловсон сапёруудыг хүмүүжүүлэхэд ашиглана.

ХИМИЙН БЭЛТГЭЛИЙГ ДЭЭШЛҮҮЛЬЕ

Монгол ардын хувьсгалт арми, одоо үеийн дайнд хэрэглэгдэх төрөл бүрийн цэргийн зэвсэг техникийн бүрэлдүүнтэй болж дэлхийн тэргүүний армитай зэрэгцэж чадав. Монгол ардын хувьсгалт цэрэг химээс хамгаалах хэрэгслээр бүрэн хангагдсан ба офицер байлдагчид нь химээс хамгаалах чадвар мэрэгжилтэй болсноор барахгүй шатаах ба утаа гаргах бодисыг төрөл бүрийн байлдаанд ашиглаж чадах бэлтгэлтэй болсон байна.

Дэлхийн 2 дугаар дайн эхлэхээс аваад дуустал хорыг хэрэглэсэнгүй, харин шатаах бодис, утаа гаргах бодисыг маш өргөн хэмжээгээр хэрэглэж, энэ талаар бага бус туршлага дадлагыг дэлхий нийтийн армиудад үлдээж өгчээ. Зөвлөлтийн Улаан Армиас Сталинград, Берлин зэрэг хотуудад бугшиж байсан дайсныг хөөж зайлуулахад Улаан Армийн огнеметчин, гал хаягч нар ихээхэн үүргийг гүйцэтгэж байлдааны явцад тусыг үзүүлж чадав. Бас дайсны бирүүн талаар бэхлэгдсэн Днепр, Волхов, Нева зэрэг ихээхэн гол мөрнийг гатлахад халхлах утаа нь дайсны оновчтой галын тусгалаас олон хүний амийг авран чадав. Хэдийгээр дэлхийн 2 дугаар дайнд хор хэрэглээгүй боловч өнгөрсөн хэдэн жилийн дотор болж байсан ба одоогийн дэлхийн нийтийн улс төрийн тэмцлийн байдлыг авч ажиглан үзэхэд, ирээдүйн дайны хор хэрэглэхгүй гэсэн батлагаа огтхон ч гарахгүй байна. Жишээ нь: 2 дугаар дайны гал эхлэн шатсан тэр цагт Италиас Абиссинд Японос Хятадад хор хэрэглэж өдий төдий хүн амьтныг сүйтгэж байсныг бид мартаж болоогүй. Мөн Герман фашистаас өөрийн эзэрхийлэн түрэмхийлэх аян дайнд хор хэрэглэхийг бага бусаар бэлтгэж байсан ба Зөвлөлтийн болон баруун Европын өдий төдий энгийн номхон ард түмнийг туршлагын хороор хордуулан алж байсныг мөн мартаж болоогүй. Бүр-

саяхан 2 дугаар дайн дуусаад байхад Энэтхэлийн дели хотонд гарсан ажилчны бослогыг дэгдээхгүйн тул харгис цагдаа нараас хорт утаа хэрэглэн дарж байсан байна. Герман фашистаас Улаан Армитай явуулсан дайндаа хорыг хэрэглэхийг бодсон боловч Зөвлөлтийн Улаан Арми одоо үеийн химээс хамгаалах хэрэглэлээр бүрэн хангагдсанаар барахгүй түүнийг үргэлжлүүлэн хангах бэлтгэлтэй байсан юм. Мөн Улаан Армийн офицер, байлдагчид нь дайн эхлэхийн өмнө хороос хамгаалах сургуулиар бүрэн бэлтгэгдэн чадаад, Зөвлөлт Улс, хэрэгцээтэй цагт армидаа ямар ч химийн бодисыг гарган нийлүүлж чадах бэлтгэлтэй болсон юм.

Герман фашистын арми, хор хэрэглэх нууц төлөвлөгөөгөө дайны эхний үед Зөвлөлтийн Улаан Армид алдаад, энэ талаар урдаа барьж байсан химийн ангиуд нь Улаан Армийн аврага хүчинд дэс дараагаараа бүт цохигджээ. Нэгэнт ийм байдалд орсон Герман, жинхэнэ дайны фронтод хорыг хэрэглэж чадсангүй. Улаан Армийн химээс хамгаалах өндөр бэлтгэл, Зөвлөлтийн химийн үйлдвэрийн агуу их бүтээл нь Герман фашистын хор хэрэглэх гэсэн төлөвлөгөөг бүрэн нураажээ. Хоёрдугаар дайнд хор хэрэглээгүй шалтгаан ийм байсан юм. Түүнээс хим нь армийн зэвсэглэлээс халагдах болоод тэгсэн хэрэг огтгүй. Ирээдүйн дайнд хим нь цэргийн зэвсэглэл хэвээр байна. Гэтэл манай зарим нэгэн хүмүүсээс хоёрдугаар дайнд хор хэрэглээгүй учир хим хэрэггүй гэх үзэр, ярианыг дэлгэрүүлж, үүнээс үндэслэн анги нэгтгэлийн дотор химийн бэлтгэлийг үнэлэн үзэхгүй ор нэр болгон өнгөрүүлэх буюу улсын үнэ бүхий, химээс хамгаалах хэрэглэлийг зөв эдлэхийг анхаарахгүй эвдэх, хаях, сүйтгэх явдал цөөхөнгүй үзэгддэг. Энэ бол, улс орон, тусгаар аар тогтнолоо батлан хамгаалах техникийн хүчирхэг арми болж, улам цааш хөгжин бэхжих явдалд саад тотгор болоход хүрнэ. Одоо бол дайн дуусан, нийтээр энх тайван цагийн хөдөлмөрийг зохиож байна. Гэвч зарим харгис үзэлтний хорт санаа хэвээр хадгалагдан байна, Энэ бүхий байдлыг харгалзан үзэж армийн байлдааны ба улс төрийн бэлтгэлийг урьд урьдаас улам илүү дээшлүүлэх ажил хурцаар шаардагдаж байна. Иймд нам, улс төрийн байгууллагаас офицер, түрүүч, байлдагчдын дунд ухуулан таниулах, сурган хүмүүжүүлэх ажлыг хүчтэй зохиож офицер, байлдагчдын химийн бэлтгэлийг дээшлүүлэх химийн эд хэрэглэлийг хайрлан хамгаалах явдалд онц анхаарлыг тавих нь чухал байна. Химийн талаар командлаас тавьж байгаа зорилгын дотор химээс хамгаалах бэлтгэлийг дээшлүүлэх, төрөл бүрийн байлдаанд халхлах утаа тавих, шатаах бодисыг хэрэглэх, Зөвлөлтийн эх орны их дайны туршлагад байлдагч, түрүүч, офицер нарыг цуцалтгүй сургах, химийн эд хэрэглэлийг хайрлан хамгаалах асуудал шаардагдаж байна. Энэ зорилгыг биелүү-

лэхэд армийн дотрох улс төрийн ажилтан, нам эвлэлийн байгууллагуудаас өөрсдийн ажлын төлөвлөгөөнд оруулж өдөр тутам анги салбаруудын дотор химийн талын асуудлыг сонирхож, нам эвлэлийн хурлууд дээр химийн талын асуудлуудыг авч хэлэлцээд химийн бэлтгэл дээр оршиж байгаа дутагдлыг хайргүй илрүүлэн шүүмжилж дээрх зорилгыг биелүүлэхэд чиглэгдсэн биетэй ажлыг зохиох нь манай байлдааны бэлтгэлийг дээшлүүлэхийн үндсэн асуудлын нэгэн нь болно.

АВТО МАШИНЫГ ДУЛААНЫ УЛИРАЛД БЭЛТГЭХ НЬ

Дулаан улирал ирэхийн хамт бүх машиныг зуны байдалд тохируулан бэлтгэх хэрэгтэй. Цас хайлан эхлэхтэй зэрэг гулгах шигдэхээс хамгаалах ба шавар намгаас татан гаргах хэрэглэл юм уу, хүрз зэргийг машина бүрд бэлтгэх нь чухал.

Моторын хөргөлт, тосолгоо, агаар цэвэрлэгч хэрэглэл, аккумулятор, резинийн зүйлүүдийг зуны улиралд тохируулан хэрхэн хайрлан хамгаалах ажиллагаануудыг жолооч нар онцор мэдэх хэрэгтэй.

Хөргөлтийн хэрэглэлийг хайрлан хамгаалах талаар

Өвлийн ажилласан радиаторын дотор хөг шорооны үлдэгдэл бий болдог учир цэвэр тунгалаг усыг хийж ажиллуулан арилгах ба дараа нь мөн чанарын усыг сайн шүүж цэвэрлэн хийх хэрэгтэй. Моторыг ажиллуулахын өмнө ус дамжин ажиллах залгаануудаар гоожиж байгаа эсэхийг шалган, хэрэв шүүрвэл түүнийг гоожихгүй болгоно.

Моторын ажиллаж байгаа үед ус оргилон буцалбал тэр дор нь хүйтэн усыг хийх болохгүй, ажиллагааг зогсоож хөргөх хэрэгтэй. Халуун моторт хүйтэн ус хийвэл гэмтэл тохиолдно. Ус нь буцалсан радиатарын бөглөөг онгойлгох үед болгоомжлох хэрэгтэй.

Тослолтын хэрэглэлийг арчлан хамгаалах талаар

Үргэлжийн тосыг хугацаанд нь солих, тослогоо зэргүүдээс моторын механизм нь саадгүй сайнаар ажиллана. Маслыг цагт нь солихгүй бол тос муугаар дамжин хавирах ангиудад элэгдэл гарах, поршин гацах, заримдаа подшипник хайлах ч удаа бий. Хэрэв өвлийн масалтай хэвээр ажиллуулбал тослогоо нь зохих зүйлүүдийг бүрэн тосолж чадахгүйгээс эвдрэлд учруулна.

Маслыг хийхдээ, ялангуяа картерийн маслыг шүүж хийх хэрэгтэй. Хог шороотой масал бол подшипник хайлах бусад зүйлийн эвдрэлүүд тохиолдоход хүргэнэ.

Маслыг тохирсон тусгай хэмжээнээс хэтрүүлэн хийж болохгүй бөгөөд жолооч бүр ажил сургуульд явахын өмнө масал хэмжээндээ бий эсэхийг үзэж байх хэрэгтэй. Масал дунд бол падшипник хайлах ба хэтэрхий дүүрэн бол их утаа гарах, свечийг ажилгүй боллох зэрэг саад учирна.

Картерийн маслыг суллан солих үед моторын картерийг керосинаар угаан, хуурай болтол арчиж түүний дараа шинэ-маслыг хийнэ.

Агаар цэвэрлэгчийг арчлан хамгаалах

Дулаан улиралд агаар цэвэрлэгчээр дамжин, нарийн шороо тоос дорогш орж моторын хөдлөгч ангиуд ба хамгийн түрүүнд поршингийн бүс цилиндрт элэгдлийг учруулан, бензинийг ихээр шатаах явдла гардаг. Иймд агаар цэвэрлэгчийг туйлын анхааралтайгаар арчлан хамгаалах хэрэгтэй. Гэтэл манай ихэнх техникийн ажилчид, жолооч нараас үүний учрыг мэдэхгүй, агаар цэвэрлэгчийг хайхрахгүй, зарим нь бүрмөсөн авч хаях явдлууд ч үзэгдэж байна.

Агаар цэвэрлэгч ба моторыг 10 өдөр ажиллах бүрд авч цэвэрлэн маслыг шинээр хийж байх, түүнийг керосинаар угаан, шороо тоосыг цэвэрлэж дараа нь зохих хэмжээгээр маслыг хийнэ.

Аккумуляторыг арчлан хамгаалах талаар

Дулаан улирал болохын хамт бүх аккумуляторуудыг шалган үзэх, засварлах, кислотыг тохируулан найруулж, цэнэгийг хураалгах хэрэгтэй.

5 дугаар сарын 1-нээс бүх ажиллан байгаа аккумуляторуудын кислотааны хүчийг 1280-аар тохируулан ажиллуулана.

Зуны дулаан улиралд аккумуляторын ажиллагаа нь улмаар сайжирдаг болно. Аккумуляторын жижиг нүхийг шалган үзэж, хог шороо орж бөглөрсөн байвал нарийн төмөр утсаар онгойлгохгүй хэвээр явуулах бол дэлбэрэх аюулыг учруулахыг анхаарах хэрэгтэй.

Аккумуляторын кантакт (шонг)ямагт цэвэр байлгах ба, холбосон холбоонуудыг үргэлж цэвэрлэх хэрэгтэй. Зуны халуун улиралд аккумуляторын ус их буцлан халж уур гаргах ба түүний улмаас зохих хэмжээнээс дээш хөөрдөг болно. Иймд дулаан улиралд 10—15 хоног бүрд шалган байх, ялангуяа их халуун улиралд 5 хоногт үзэж байх хэрэгтэй. Кислота нь аккумуляторын пластинкаас дээш 10—15 см. байвал 30-

хих ба түүнээс байж доош үл болно. Аккумулятор хэрэв ус хийх бол нэрмэл буюу цэвэр саванд хураан авсан борооны усыг хийх бөгөөд бусад усыг хийж хэрхэвч болохгүй. Ангийн техникийн туслах дарга бол сар бүрд өөрийн харьяа бүх ангиудын аккумуляторын байдал ба шингэн бодисыг шалган үзэх хэрэгтэй. Шатхуунаар цэнэглэх ба түүнийг хадгалах хийгээд, тээвэрлэх тухай дулаан улирал ирэхийн хамтаар бензин нь халж хөөрөх ба галын аюул гарахад хялбар болдог байна. Үүнд машины бензин дамжих хэрэглэлийг сайн шалгах хэрэгтэй. Бензиний банк, трубка хоолонуудаар бензинийг нэгч тусал боловч гоожихгүйгээр засаж бэхлэх ба ялимгүй жижиг зүйл боловч түүнийг засварлах хэрэгтэй. Бензинээр машиныг цэнэглэхдээ хувин савыг шороо тоосгүй болтол цэвэрлэн тусгай шүүр бүхий воронкоор дамжуулан цэнэглэх хэрэгтэй.

Бензинийг бүтэн саванд сайн бөглөөтэй авч явах, бензин гоожих ахул яндангаас авалцан галын аюул гарч болзошгүй юм.

Бензинийг машина дээр авч явах буюу хээрийн склад зэрэгт хадгалахад заавал агаараас хамгаалсан бүтээлэгтэй байх хэрэгтэй.

Машиныг жолоодох талаар

Дулаан улирал орохын хамтаар цас хайлах, ус гүйж гулгах явдал гардаг. Ийм замд жолооны хувиар тогтворгүй болон гулгана. Ийм замд хурдны хэмжээг багасгахын дээр, гэнт эргэж үл болно. Гэнт тооромслох аваас гулгах буюу онхолдох явдал гарна. Хэрэв машина явж байтал гулгах явдал гарвал гулгасан чигт нь жолоог эргүүл өгнө.

Мөн тэр үед тоормслох үл болох бөгөөд машиныг чиг шугамд орохын хамтаар зөөлөн тогтуун тооромсолбол зохино.

Нойтон замд гулгах явдлаас хамгаалах хэрэглэлүүдийг дугуйдаа хийж ажиллавал сайн болно.

Элстэй газар, замыг сонгон олж явахын дээр хүнд араагаар хурднаар явна. Гүнзгий элсэн дотор явж байгаа үед арааг сольж хэрхэвч үл болно. Арааг соливол элсэнд шигдэнэ. Хэрэв, элс бүхий хөндлөн нарийн газар тохиолдоход гэнт дайран гарах нь ашигтай. Хэрэв элстэй газар машина шигдэн зогсож дугуй хий эрэгэлвэл дор нь зогсож өөр арга хэрэглэн гарахыг бодохоос биш, хэвээр нь хий эргүүлж болохгүй.

Бороотой үед шавар бүхий замаар явахад хүнд болно. Шавар нь пакрышканд наалдан машины хүчийг бууруулна.

Шавар бүхий зам тохиолдох бол түүнийг тойрон гарахыг бодох хэрэгтэй. Хэрэв тойрон гарах газаргүй бол хөрслөг, ургац бүхий газраар нь явбал ашигтай. Урьд машина явсан хуучин замыг дагаж явсны хэрэггүй. Хэрэв, түүгээр явбал урьд

явсан машина нь газрын хөрсийг эвдлэн ухсан учраас дараагийн машина нь гүнээр суух аюул тохиолдоно.

Хэрэв шавартай газар шигдэн суухад хүрбэл нойтон газрыг ухаж болохгүй. Түүний оронд чулуу, банз мод, өвс ба бусад зүйлийг дугуйн дор дэвсэх буюу өөр татан гаргах хэрэглэл зэргийг ашиглах хэрэгтэй. Бороо их орсон үед туйлын анхааралтайгаар явах хэрэгтэй.

Гүнзгий ус гол тохиолдоход түүний гүннийг урьдаар шалгаж үзэх хэрэгтэй. Үүнд ямар машина хэдий хир гүнзгий усыг гатлан гарч чадах хэмжээг үзүүлвэл «Зис 5» ба «Зис 6» нь 0,8 см. бөгөөд усыг гарахдаа сэнсний оосрыг суллан авч свечка ба транбүлүрийг резинийн 3-үйлээр ороох хэрэгтэй. «Газ АА» машиныг аккумуляторыг авч суудлын дотор тавин залгаж гарах бөгөөд усыг гатлан гарах үед хүнд араагаар моторыг их түргэн эргэлтээр ажиллуулан гарах хэрэгтэй.

Машиныг арчлан хамгаалах талаар

Байлдааны ба тээврийн машины жолооч нараас явж байгаа үед машины ажиллагааг шалгах хэрэглэлүүдийг цаг ямагт хянан шалгаж явах, маслын даралтын ба халууны ажиллагаа нь заах хэрэглэлээр ихдэх ахүл нэн даруй зогсоож юуны учраас мотор ихээр халсан тухай шалтгааныг шалган үзэж гүйцэтгэх, сэнсний оосор бол тохирч таарсан байх ёстой. Их чанга буюу сул явуулж үл болно. Хэрэв, сул бол динамыг эргүүлэн ажиллуулж үл чадана.

Явуулагч ангиуд хог шороотой байх буюу зэврэх ахул түргэн цагийн дотор элэгдэл тохиолддог болно. Иймд хэзээ ямагт хог шороо, тоосыг арчин цэвэрлэж явах, хөдлөгч анги ба моторыг цаг үргэлж ариун цэвэр авч явах хэрэгтэй. Халуун наранд зогсох үед резинийн зүйлүүдийг халуунаас халхлан бүтээж байх, явж байгаа үед (ялангуяа хуягт машина) 1 цаг хагас буюу 2 цаг явсны дараа резин дугуйг халсан эссэнийг гараар дарж үзэх ба халсан ахул түр зогсож хөргөх хэрэгтэй. Хөргөхгүй бол хуягтын кусматик дугуйн доторох шингэн зүйл нь шатаж жагсаалаас гарна. Хийлдэг дугуйтай машинууд бол халж хий нь тэлэсний улмаас дэлбэрч ч болно. Иймд түүний хийг гаргаж бага болгох нь тохиромжгүй ба ашиггүй бөгөөд үүнд түр зогсож хөргөх нь ашигтай. Явж байгаа машины дугуйг бага хийтэйгээр явуулж үл болно. Хий багын улмаас резин жагсаалаас гардаг.

Дулаан улиралд машины пакрышикийг цагаан өнгийн буудаг буюу шохойгоор будвал нарны их халуунаас хамгаалдаг.

Дулаан улирал орохын өмнө хуягт ба тээврийн болон ангиудын бүх машинад техникийн үзлэгийг хийж тослох хэрэгтэй.

Маневрлах тактик бол зөвлөлтийн цэрэгт дайсныг түүний санаанд бага орсон газарт гэндүүлэн, шуурхай цохих бололцоог өгч байв. Маневрын нэг зүйл бол тойролт мөн. Тойрох маневр бол түргэн чочмог, зориглон байлдахыг цэргээс шаардана. Энэ талаар Кенигзбергийн баруунтай дайсныг бут ниргэхэд оролцсон N дугаар ангийн буучийн батальоны туршлага сургамжтай болжээ.

Германы сүрхий бэхлэлттэй байрыг сэтэлсний дараа манай цэрэг, баруун чигт хэдэн өдөр ахиж байв. Германууд хориглолтын зааг бүрийг ширүүн эсэргүүцэлд ашиглаж өөрийн гол хүч ба техникийг Пиллад гэдэг портод заавал гаргаж тэнд траншегаар сийчигдсэн ба инженерийн барилгаар бэхлэгдсэн явцуу газарт манай давшилтыг зогсоох гэж эрмэлзэж байв.

Фишгаузен гэдэг хотын ойролцоо . . . дугаар буучийн ангид цагийн байдал ямар байсныг хэлбэл, өдрийн эцэст салбарууд, ноёны өргөөний зүүнтэй байгаа өндөрлөгүүдэд хүрчээ. Тэдгээр салбар, тэнд артиллери, миномет, пулеметийн галаар буудуулж зогсожээ, Ангийн дарга, газрын байдал ба дайсныг хурдан судлаад, өндөрлөгүүдэд батальон хүртэл хүчтэй дайсан хориглож байгааг олжээ.

Хорооны дарга, хажуугийн ангитай холбоо барьж, баруун талын анги бол голыг гатлахын төлөө, зүүн талын анги бол хороотой зэрэгцэн бараг нэг заагт байлдаж байгааг мэджээ. Зүүн талын анги ба хорооны хоорондын саланхай нь, 1,5-аас 2 километр хүрч байжээ. Энэ саланхай бол голын ус эргээс хальж ноёны өргөөний өмнө нам газарт үерэлсний улмаас үүсчээ.

Германууд урьдаас бэлтгэгдсэн байранд хориглож үлэмж тооны галт хэрэглэлтэй байв. Хорооны дарга, дайсныг фронтын зүгээс хоёр батальоноор атаклахад бэлтгэх ба дайсныг зүүнтэйгээс нь тойрохоор нэг батальоныг явуулах шийдвэрийг гаргав.

Хорооны дарга, гуравдугаар батальоны дарга хушууч Ско-робогатьког өөр дээр дуудаж, тойрох маневрыг ой дундуур хийж, дараа нь устай нам газраар явж сөөг бутаар халхлуулан, дараахь өдрийн үүр цайхын үед дайсны ар хударгаар орох үүргийг тавьжээ.

Тойрогч батальон бол ноёны өргөөг нэг ротоор эзэлж, гатлуурыг эзэмшин, хоёр ротоор нэгдүгээр батальоны өмнө дайсныг ар хударгаар цохих ёстой байв. Батальоны даргад мэдэгдсэн нь, хорооны артиллерийн хэрэглэлүүд, голын цаана байгаа Германы артиллери ба амьд хүчийг дарахад ашиглагдана гэжээ.

Иймд хушууч Скоробогатькогийн батальон бол хорооны бусад салбараас тасархай байлдах болжээ. Хүмүүс, устай газрыг туулах байсан нь, үүргийг төвөгтэй болгож байв. Гэвч энэ явдал, бас өөрийн сайн талтай байсан юм. Юу гэвэл, Германууд чухам энэ чигээс манай салбаруудын цохихыг мэдсэн байж чадах уу даа.

Батальоны дарга, байлдахад бэлтгэхийн тул түүнд олгогдсон цагийн ашиглан, газрыг хайгуулаар зүилчлэн мэдэхээр шийджээ. Харанхуй болохын хамт, хайгуулч нарын бүлэг, замдаа хөдөлжээ. Батальоны дарга, ротын дарга нарыг үүрэгтэй танилцуулж салбаруудыг ойн баруун захад гаргах тушаалыг өгөөд, мөн тэнд хэрэгслийг засах, байлдааны хэрэглэлийг бүрэн гүйцэд болтол нь нөхөх тухай зааврыг өгчээ.

Хайгуулаас удалгүй буцаж ирсэн офицер, батальоны даргад мэдэгдсэн нь: ойн баруунтай байгаа бүх нам газарт ус дүүрчээ. Гүнзгий нь 10—15 см-ээс хэтрэхгүй. Зарим газарт 50—60 см. хүртэл гүнзгий сувгууд байна. Сөөг бут нилээд шигүү ба сайн далдлалт болж чадах юм. Батальоны байгаа танк эсэргүүцэх артиллерийг үерлэсэн устай газраар гаргаж чадахгүй. Ойн баруун хойт захаар дайсны жижиг бүлгүүд эргүүл хийж байна. Нэргүй өндөрлөгийн баруун хажууд минометууд зоогджээ. Буудаж байгаа дуугаар нь үзвэл, батальоны минометууд байна. Батальоны салбарууд сөөг бутын хойт зах хүртэл явахад 3-аас доошгүй цаг хэрэглэгдэнэ гэжээ.

Хушууч, энэ бүх мэдээг харгалзан, шийдвэрийг гаргаад, салбарын дарга нарт үүргийг тавьжээ. Уг үүрэг бол: тойрох маршийг шөнө хийж 4,00-д сөөг бутын хойт захад хүрэх, тэндээс 7 дугаар буучийн рот, пулемет, танк-эсэргүүцэх буунууд, саперын нэг тасгаар хүчлэгдэн, ноёны өргөө ба голыг гатлах гүүрийг гэнэт атаклаж, энэ үүргийг гүйцэтгээд танк-эсэргүүцэх буунуудыг ашиглан, голын баруун эрэг дээр гүүрт ойртох газрыг минтүүлэхийн тул саперын тасгийг хэрэглэн, танк-эсэргүүцэх хориглолтыг хийх.

8 ба 9 дүгээр ротууд, нэгдүгээр батальоны фронтын өмнө өндөрлөгт дайсныг ар хударгаар нь атаклаж, үүний дараа 8 дугаар рот, засмал зам дээр «мордоод», хойт зүгт фронтоор хүчээ дэлгэн, хоёрдугаар батальоны өмнө хориглож байгаа германуудад хажуугаас нь өөрийн галыг нээж, хоёрдугаар батальоны өөдөөс эсэргүүцэн зогсож байгаа дайсныг устгахад нь дөхөм болгож түүнийг голын цаана ухруулахгүй байх.

Цочмог байлдахын тулд хушууч Скоробогатько, ус үерлэсэн газраар чимээгүй явах бүх аргыг хэрэглэх тухай салбарын дарга нарт тушааж, хамгийн сайн гулсагч—хайгуулч нарыг шилж сөөг бутын хойт захын дагуу эргүүл хийж байгаа дайсны цэргүүдийг чимээгүй сөнөөх үүргийг тэдэнд өхийг баталь-

оны ахлах адъютантад даалгажээ. Бас батальоны минометүүд ба хүнд пулеметүүдийг задалж, үүрэх болжээ. Салбаруудын явахыг далд байлгах зорилгоор хушууч Скоробогатько, нэгдүгээр батальоны даргаас 24-өөс 4 цаг хүртэл дайсныг пулемет, автоматаар буудаж байхаар түүнтэй хэлэлцэн тохирчээ. Батальоны дарга, хэрэв батальон германуудтай тохиолдож, үүр цайх болтол тэдэнтэй байлдахад хүрвэл хүмүүсийн зүүн гар дээр цагаан боолттой байхыг тушаажээ.

23 цаг 30 минутад батальон хайгуулаар мэдэгдсэн замаар явж эхлэв. 4 цагийн хирд салбарууд, сөөг бутын хойт захад хүрээд, эргүүлүүдийг устгахаар гарсан бүлэг, өөрийн үүргийг сайн гүйцэтгэж, германуудыг устган, нэг цэргийг олзолжээ. Ноёны өргөөнд Германы батальоны штаб бий ба голын зүүнтэй байгаа өндөрлөгүүдэд хүчлэгдсэн хоёр рот хориглож, харин нэг рот, голын баруунтай өндөрлөгт байралсныг хушууч, тэр олзлогдогчоос мэдэв.

Үүр цайхын өмнө сүүмэн гэгээ тусч байхад, 8 ба 9 дүгээр ротууд, гинжин эгнээ болж задран, нэргүй өндөрлөгийг чиглэн зүүн хойт зүгт ахиж байв. Байлдааны ийм эрэмбэ бол Германы тохиолдох ганц хоёр цэрэг буюу бүлгүүдийг хориглолтын урьд захаас ар талд хүрэх, мөн буцаж явж чадахгүй болгох учиртай байсан юм.

Батальоны дарга дайсныг нэг зэрэг цохих ба баруун чигт ухрах бололцоог түүнд өхгүйн тулд байлдааны ийм журмыг зохиохыг чухал болгов. 7 дугаар рот, ноёны өргөөг хажуугаас нь тойрохын тулд «гэдрэг өнцөгөөр» явж байв.

7 дугаар рот, ноёны өргөөнд ойртмогц, тэр үед түүнийг ноёны өргөөний баруунтай байрласан дайсан илрүүлжээ. Германууд ахиж яваа ротын хажуугаас пулеметээр галалжээ. Ротын дарга, галт байрыг түргэн эзлэх ба дайсны галт байрыг дарах тухай пулеметийн салаанд тушаав.

Ноёны өргөөний хавьд дайсан, буудуулж сандрав. Удалгүй 9 дүгээр ротын өмнө ар талда очиж явсан салаа хүртэл хүчтэй германууд үзэгдэв. Тэд 8 ба 9 дүгээр ротуудын гинжин эгнээг илрүүлээд, атаклагч нарыг дайруулан ил сүрхий галыг нээжээ. Манай байлдагч нарын ойртож очсон газарт дайсны минометийн батаренууд, бас байлдаанд оров. Давшигч нарт цагийн байдал түгшүүртэй болов. Гэвч тэд өчүүхэн төдий саатал бол байдлыг дордуулахыг мэдэж байв. Учир нь дайсан байлдааны газарт өөрийн бэлтгэл хүчийг ирүүлж болох байв.

Хушууч Скоробогатько, байлдаан үүсэхийн хамт урьд болзсон ёсоор хорооны даргатай радиогоор холбоо барьж түүнд цагийн байдлыг мэдэгдэв. Хорооны дарга, нэгдүгээр ба хоёрдугаар батальонууд, атакдад орохыг мэдэгдээд, ноёны өргөө ба гүүрийг даруй эзэлж, түүнчлэн өндөрлөгийн баруун хажууд

дайсны минометийн батареиг эзлэх тухай хушууч Скоробогатькод тушаав.

Атакад орсон нэгдүгээр батальон, Германы анхаарлыг тагтажээ, 9 дүгээр рот, үүнийг ашиглан дайсны минометийн тоот нарыг бүрыг бүрэн устгаад, түүний галт байрыг эзлэн Германы траншед хүрэв.

Наймдугаар рот, бас дайсны минометийн ротыг эзлээд, хоёр салаагаар дайсныг ар хударгаар нь атаклажээ. Дарга, буучийн ба пулеметийн салаадыг засмал замын хавьд байрлуулсан, хоёрдугаар батальоны атакад хажуугийн талаар туслалц гэж тэдэнд тушаажээ.

Германууд сөрөх атакиг хэд дахин хийжээ. Гэвч тэдгээр атак цөм няцаагджээ. Эцэст нэгдүгээр батальоны өмнө байсан дайсны зарим нь устгагдаж, ихэнх нь олзлогджээ.

Долдугаар ротод цагийн байдал нилээд ондоо болов.

Голын баруун талаас пулеметээр галласан ба ноёны өргөөнөөс галласан нь, тасгуудыг газарт хэвтүүлжээ. Үнэндээ, батальоны дарга, ротын хүнд байдлын тухай мэдээд, дайсны траншеиг дайруулан минометээр галлах тухай минометч нарт тушаажээ. Мөн тэнд ротын пулеметч ба минометч нар бас буудаж байжээ. Гэвч тэдгээрийн гал, бага амжилттай байсан. Энэ бол минометч ба пулеметч нар, галт байрыг зохистойгоор тоноглож амжаагүйгээс болжээ. Тийм боловч рот, удалгүй ноёны өргөөг эзэлж чадав.

Хоёрдугаар салаа, гүүрт хүрмэгц түүний дарга, тэр зүгт дайсны бүлэг яаравчилж явааг үзэв. Зөвлөлтийн офицер, гүүрт үсрэлтээр хүрч хориглож байхыг тасгуудад тушаажээ. Түргэн, шийдмэг байлдсан нь, манай байлдагч нар, германуудаас урьтаж гүүрийн дэргэд тэнд дайсны ирэхээс өмнө хориглоход дөхөм болгож байжээ. Тэд германуудыг нөхөрлөг талаар хэвтүүлэв. Өндөрлөг дээрээс ухарч яваа дайсны жижиг бүлгүүд удалгүй гүүрт ойртож ирж байв. Тэд өөрийн салбаруудын ухралтыг хангахын тул манай салааг үмгэх гэж оролдож байв. 7 дугаар ротын дарга, ийм байдлыг үзээд, эдгээр бүлгийг хажуугаас нь атаклан устгах тухай нэгдүгээр салаанд тушаажээ. Германууд, атакаас зайлж хойт чигт голын дагуу ухарч, дараа нь жижиг бүлгүүдээр голыг гатлах болов.

Иймд тойрох маневр батальоны хүчээр гүйцэд амжилттай дуусчээ. Гуравдугаар батальон, хорооны бусад хүчээр дайсныг гэнэт цохих явдлыг өөрийн байлдаанаар хангаж, дайсны холбоо ба удирдлагыг сарниулсан юм. Манай салбаруудын шийдмэг зоримог байлдсан нь, сайн биелэгдсэн маневрын үрээр Германыг бүсэлсэн цагригаас тэдний гарах гэсэн бүх оролдолгыг тасалж байжээ. Энэ талаар офицер нарын хувийн санаачлага, онцын холбогдолтой байсан юм. Дайсны ар хударгаар байлдах үед ахлах дарга, бүх явдлыг ажиглаж, салбар-

уудын чармайлыг онц чухал чигт нь зүглүүлж чадахгүй байдаг. Ийм дээрээс энэ үест офицер бүрийн ухаалаг санаачлага онцын холбогдолтой болно.

ДАЙСНЫГ УУЛТАЙ ГАЗАРТ ОРООХ БА БҮСЛЭХ НЬ

Японы эзэрхэг түрэмгийчүүдтэй явуулсан байлдаан нь дайсны хориглолтын үзүүрүүдийг ороох ба бүслэх явдал бол уултай газар давшихад маневрлах гол хэлбэр мөн гэж манай цэргийн байлдааны дүрэмд заасан үндэслэлүүдийг баталсан бага бус жишээнүүдийг өгөв.

Ороож байгаа буюу тойрч байгаа салбарууд нь гэнт цочмог, шийдвэрлэг ажиллаж, биеэ дааж үүргээ гүйцэтгэх чадвартай байх ёстой гэгчийг практик үзүүлэв. Жишээ болгож ахлах дэслэгч Светловын рот, Япончуудтай явуулсан тулалдаанд яаж ажиллагсныг үзье.

Энэ рот аяны толгойн хаалтын үүргийг гүйцэтгэж байв. «Нэргүй» өндөрлөгийн дэргэд Япончууд хаалтын тагнуулыг буудаж эхлэв. Дайсан илэрсэн боловч ротын өмнөөс ямар хүч хориглож байгаа, галын цэгүүд нь хаа байрласан, хориглолтын систем нь ямар болох гэдэг нь манай тагнуулчдад илэрхий бус байв.

Офицер Светлов, цэргүүддээ өнгөлөн далдлах тушаалыг өгөөд хянах явдлаар тагнуулыг зохиов. Энэ үед тагнуул нь дайсантай анх тулгарахад үүссэн тулалдааны галыг үргэлжлүүлсээр байлаа. Тагнуулууд нь тулгууртай бөгөөд ширүүнээр ажиллаж, зүг бүрээс нь богино цохилтыг хийгээр, ихээхэн хүчний ажиллагааг илэрүүлэх бололцоог байгуулан, Япончуудыг бүх галын цэгүүдээ тулалдаанд оруулахад хүргэв. Ротын дарга нь өөрийнхөө хянах байрнаас тэдгээрийг тэмдэглэн авч чадав. Тэгээд Япончуудын хориглолтыг илэрүүлэн мэдэв. Тэр нь даваа дундуур гарсан замыг халхалтан, уултай газарт тохирох тулгуур байр байжээ. Түүнчлэн энэ байр нь нийт нурууны хориглолтын системд багтсан болох нь мэдэгдэв. Япончууд үүнийгээ ихээхэн чухалд үзэж байсан бололтой. Энд траншонуудыг ухаж, пулемет ба гранатометуудад зориулсан талбайг чимэглэсэн байв. Тулгуур байр нь их буу, пулеметын тэрээ галыг нээх бололцоотой байжээ.

Ротын дарга цагийн байдлыг үнэлмэгц, гол хүчний ойртохыг ч хүлээсэнгүй, даруйхан давааг эзлэж авахаар шийтэв. Тэр зоримог шийдвэрийг гаргахдаа, ороох маневрыг хэрэглэж дайсныг гэнт атаклан улмаар амжилтыг олох бололцоо байна гэж үзэв.

Тулалдааныг дор дурдсан байдлаар явуулах гэж шийдэв. Үүнд бартаатай далд газрыг ашиглан, атаклаж болохоор хэмжээний газар тулгуур байранд ойртон очих байв. Даргын бодлын ёсоор, хоёр салаа нь үзүүрүүдийг ороож аль болохоор дайсны ар талаас атаклахаар нэвтрэх байв. Тулалдааныг явуулсаар байгаа тагнуулчдын хоёр тасаг нь ротыг маневрлаж байх үед дайсны анхаарлыг нүүр (фронт) талаас нь өөр дээрээ татсаар байх ёстой байв. Офицер, галын бүлэгт пулеметын салааг хавсаргаж, түүний хүчийг нэмэгдүүлэв.

Түүний үүрэг нь өтгөн галыг нээж, Япончуудад оновчтой гал нээх ба хяналтыг хийх бололцоог өхгүй байхад оршижээ. Минометчин нар нь дайсны транше ба бэхлэлт рүү галлаж байв.

Нүүр талаасаа хүчтэй галаар халдахад төөрөлдсөн Япончууд, жижигхэн бүлэг тагнуулчин нар дээр хамаг анхаарлаа тавив. Тэр үесээр нь бутнуудаар халхлагдсан ротын гол хүчнүүд тулгуур байрны үзүүрүүдийг ороов.

Гэвч иймэрхүү байдлаар толгойг атаклах нь аюултай байв. Зэргэлдээ байгаа өндөрлөгөөс, япончууд түүнд галаар гусалж чадах байв. Офицер Светлов, дайсны энэхүү харилцан ажиллагааг бололцоогүй болгохын тулд пулеметчин, минометчин нарт уул өндөрлөг рүү галаа шилжүүлэх тушаал өгөв. Энэ нь атакад шилжин орохын дохио болов.

Япончуудын толгой руу гранатууд нисэлдэв. Манай байлдагч нар тэдэнд сэхээ өгөлгүйгээр транше руу нь цөмрөн орж, жадлан цохив. Үзүүрүүдээсээ гэнт довтлоход сандран тэвдсэн дайсан тулгууртай эсэргүүцлийг үзүүлж чадсангүй. Светловын рот, япончуудын ихэнхийг устгаад, өндөрлөг дээв түргэн бэхжиж, уулын нуруугаар гатлах давааг өөрийнхөө хяналтын дор авав.

Дээр дурдаснаас үзэхэд рот нь бүслэлт ба гэндүүлэлийн ачаар, бага хүчээр их амжилтыг олж чадсан байна. Бас дэслэгч Голубовын салаа алсаар нь ороохын жишээг үзүүлэв.

Энэ салаанд оролцож явсан баталионы дарга өөрийнхөө өмнө өндөрлөгийг эзэлэхээс арай илүү шийдэмгий зорилтыг тавьж дайсныг бүрмөсөн устгахыг зорьжээ. Баталионы хүч нь дайсныг атаклаж, түүний эзлэж байгаа байрнаас нь түрж зайлуулахад хүрэлцэхүйц байв. Дайсныг лавтай устгахын тулд баталионы дарга, япончуудын ухрах замыг хааж тэдний ар тал руу автоматчны салааг явуулахаар шийдэв. Үүнд хамгийн

зоригтой, шаламгай, санаачлагатай офицер Голубовыг томил-
лов. Түүнд тулгуур байрыг гүн ой дундуур тойрч, ар талд нь
нууц отолтыг байгуулж, япончуудыг ухрах үесээр өндөрлө-
гийн зүгээс галлаж, устгах ажиллагааг эхлэх үүргийг тавив.

Дэслэгч Голубов, салаагаа цуглуулж, үүргийг тайлбарлан
таниулаад, хатуу сахилга баттай байхыг цэргүүдээсээ шаар-
дав. Шөнө болсон хойно салаагаа авч явав. Тэд өтгөн ойтой,
хамгийн аглаг газраар замнав. Гэрэл чимээ гаргахгүй явсаар,
саад бартааг туулж, үүр цайхын орчим дайсны ар талд гар-
аад, үл мэдэгдэх нэгэн өндөрлөг дээр дугараг хориглолтыг
байгуулж, баталионы хүчинд түрэгдэж, япончуудын зайлш-
гүй ухрах ганц зам руу хамаг галын хүчээ чиглүүлсэн байв.

Гэтэл хоёр морин тэрэг гарч ирэв. Голубовын байлдагч нар
түүний хүмүүсийг чимээ гаргалгүй барьж аваад, тэрэгнүүдийг
ойн гүнд далдлав. Нэгжин үзэхэд, түүнд байлдааны хэрэгсэл
ба ялангуяа сум зэргийг их ачсан байжээ.

Бууны дуу ширүүдэж байгаа байдлаас үзэхэд тулалдаан
эхэлсэн бололтой гэж автоматчин нар мэдэв. Баталионы ам-
жилт гаргаж байгааг тааварлан мэдэхэд бэрх бус байлаа.
Зам дагуу анхандаа япончуудын жижиг бүлгүүд үзэгдээд, да-
раагаар нь улам улам том бүлгүүд үзэгдэх болов. Дайсан
эмх журамгүй ухрав. Дэслэгч Голубов түрүүчийн япончуу-
дыг тултал ойртуулж, гэнт галлаж устгасны дараа, сүүлчийн
бүлгүүд дээр галаа шилжүүлж, дайсны ухарч байгаа зам
дээр нэг ч самурай нэвтрэн гарч чадахгүй болтол нь хаасан
тугалган хөшгийг босгов.

Япончууд уриханд орсноо мэдмэгц, уул ба ойн дотор нуу-
гдахыг оролдов. Дэслэгч Голубов үүнийг мэдээд, өөрийнхөө
тактикийг өөрчлөв. Салаагаа гурван хэсэг хувааж, хэсэг бү-
хэнд үүргийг тавиад, биеэ дааж ажилла гэж тушаав. Авто-
матчин нар цуцалтгүй маневрлаж, дайсны амиа аврах гэж
тэмүүлж байгаа газар бүхэнд түүнийг мэргэн сумаар угтаж
байв. Энэ үед баталионы шаламгай давшилт улам өрнөж
байв. Бүслэлтийн гогцоо улам явцуудаж байлаа. Япончууд
гаргах газаргүй болж, бууж өгөв.

Иймэрхүү явдлууд дээр, байлдааны үүргийг тодорхой мэд-
дэх, офицеруудаас зохион санаачлах, тэдний шийдэмгий ажил-
лагаа эд бүгд нь нам газрын амжилтыг уулархаг-ойтой газар-
авчирдаг байна. Уултай газрын байлдааны амин гол нь ороох
ба бүслэх маневр мөн. Ямар ч цагт, дайсны эгц урдаас нь
тулах явдал онц ашигтай бус, харин ороох ба бүслэх, нүүр
ба ар тал, мөн үзүүрүүдээс нь гэнт атаклах, өөрөөр хэлбэл,
дайсны хориглолтын аль эмзэг сул талаас нь атаклахыг эрм-
элзэх хэрэгтэй.

Тэхдээ офицер хүн уултай газар тэмдэгт авахыг нарийн судлах нь чухал. Ороох маневрин амжилт нь гол төлөв даргын энэхүү урлалаас нөлөөлөгдөнө.

Харилцан ажиллах асуудал дээр ихээхэн анхаарлыг тавих хэрэгтэй. Ууланд тойрох маневрыг хийж байхад гэрлийн ба чимээний дохиог хэрэглэж болохгүй явдал ихэд тохиолдож, утсан холбоог ашиглах бололцоогүй болдог. Ийм дээрээс харилцан ажиллагааг биелүүлэх холбооны үндсэн хэрэгсэл нь радио бөгөөд бага жижиг ангиуд дээр цаг тогтоон харилцана. Дарга, газар орны тухай өөрийнөө гарт байгаа мэдээ дээр үндэслүүлэн ороох маневрыг хийж байгаа салбарт дайсны үзүүр ба ар талд байлдааны эхлэх байраа эзлэхийн тулд хичнээн цаг шаардагдахыг тодорхойлох болно. Түүний дараагаар атаклах цагийг тогтоож, улмаар цаашдын ажиллагааны тооцоог гарган, тулалдааныг дуусах хүртэл харилцан ажиллах явдлыг хангана.

ГУДАМЖИНД БАЙЛДАХ НЬ

Суурин газарт байлдах нь одоогийн байлдааны хамгийн хэцүү хэлбэрийн нэг мөн. Энд байлдагч нар, зоорь, балгас зэрэг газарт бүгсэн «үзэгдэшгүй» гэдэг дайсантай байлдах болно.

Гудамжны байлдаан бол удааширдгийн дээр тэмцлийн тусгай голомт болон салж, хүчийг жижиглэх ба хүмүүсээс их тэсвэр, тэвчээрийг шаардана. Жижиг бүлэг байлдагч нар, огт дангаар биеэ дааж ажиллах болдог юм.

Туршлагаас үзвэл, гудамжны байлдаанд хүнд хөнгөн пулеметууд, дагалдах нэг хоёр их буутай хүч хавсарсан 12-оос 15 автоматчнаар бүрэлдсэн дайрах жижиг бүлгүүдийг ашиглах нь зүйтэй. Бас дайрах бүлгийн бүрэлдэхүүнд сапер 3—5, галаар буудагч 2—3, (утаат хөшгийг тавихын тул) химич 1—2, танк 1—2-ыг оруулах нь зүйтэй. Дайрах бүлгийн байлдагч нарыг автомат хутга, гар буу, хүн бүрд танк эсэргүүцэх ба гар гранат 5-аар 8-аар зэвсэглэх хэрэгтэй.

Дайрах бүлгийн ажиллагаа бол удаа бүрд дайсны хориглолтын шинж ба тавигдсан үүргээр тодорхойлогдоно. Фронт дээр дайрах бүлэг, хоёр гурван хэсэг, тасгууд болон салбарлаж байв. Нэгдүгээр (Боогч) хэсэг, пулеметч, артиллерич, автоматч нараар бүрэлдэж, түүний үүрэг бол тэмдэгт газрыг

дайрах, дайсны анхаарал ба галыг өөртөө татах, түүний бэлтгэл хүчийг ойртуулахгүй ийм байжээ.

Хоёрдугаар дайрагч хэсэг, бууч, (Гранаттай) автоматч, сапер, гар пулеметч нараар бүрэлдэж, түүний үүрэг бол барилгын өмнө боогч хэсгээр халхлуулан, саад дунд гарцыг туулах байжээ. Гуравдугаар хэсэг, атакийн газрыг тойрох буюу барилгын дотор дайрагч бүлгийн амжилтыг өрнүүлэхийн тул бэлтгэл хүч болон ашиглагдаж байв.

Заримдаа заагдсан хэсгүүд биеэ дааж ажиллаж, бас 2—3 хүнтэй улам жижиг болон салбарлаж ч байсан юм. Гудамжны байлдааныг зохиож хийхэд үхширмэл арга байж үл болохыг туршлага хэлж өгч байна. Юу гэвэл тасаг, салааны дарга нар, тавигдсан үүргийг цагийн ба газрын байдалтай уялдуулан бүтээлтэй шийдвэрлэх ёстой.

Үүнтэй холбогдож Лабиау хотод дэслэгч Антиповын бууч салааны хийсэн байлдаан сургамжтай байна.

Атаклагч нар дайсанд эзлэгдсэн газрыг үзэж, буудаж байхын тулд хамгийн өндөр байруудыг эзлэхийг эрмэлзэх ёстой. Барилгын төлөө байлдах нь хамгийн урдаар дээд давхрын төлөө байлдахыг хэлнэ.

Нөхөр Антипов, энэ бүхнийг харгалзан эзлээд дайсны бэхжисэн тэртээ талын барилгын цонх үүдийг дайруулан галалжээ. Энэ үед гранат шидэгч, байлдагч нар, танк эсэргүүцэх гранатыг цонх, үүдээр шидэж даргаа нь шуурхайлан үсэрч барилгад дайран оржээ. Гэвч байлдагч нар байшинг байлдан булааж чадаагүй байтал дайсан бэлтгэл хүчээ татжээ.

Дэслэгч Антипов, цагийн байдлын өөрчлөлтийг харгалзан, байдаг хаалга бүхнийг байшингийн хогшилоор таглаж тэр бөглөөсийн цаана гар пулеметийг гарга гэж тушаажээ. Тасгууд 2—3 байлдагчтай бүлэг болон салжээ. Ефрейтор Елисеенко, өөрийн бүлгийн хамт дээд давхар дээр гарч танк эсэргүүцэх хоёр гранатыг утааны яндангаар оруулан хаяж, тэдгээрийн дэлбэрэлтээс болж дайсны бүгсэн өрөөнд утаа хөө, үүл мэт босчээ. Тэр өрөөний өөдөөс харж үлдсэн автоматч нар, дайсанд сэхээ авхуулалгүй, овоолсныг түргэн зайлуулж, үүдээр хэдэн гранатыг урдчилж хаяад өнөө өрөөнд дайран оров.

Бусад өрөө, бас ийм аргаар эзлэгджээ. Жижиг бүлгүүд, Германы бүгж байсан сууцыг тойрч, дотоод цонх буюу нүхээр гранатыг шидэж өрөөний хоорондын хөндлөн нимгэн туургыг цөмлөн байлдсаар давхруудыг дараалан дайсны гараас ариутгажээ.

Суурин газарт ингэж тэмцэх аргыг Японы түрэмгийлэгчидтэй байлдахад ч дайрах бүлгүүд, өргөн хэрэглэж байсан юм. Ийм нэг жишээг гаргаж болно. Офицер Колесниченкогийн салаа, нэг хотын захад байрласан хоёр давхар чулуун байшинг эзлэх ёстой байв. Салааны дарга, их нөөц сумтай автомат,

гранатаар зэвсэглэсэн дайрах хоёр бүлгийг бий болгов. Зам байгаагүй ба намаг ихтэй байсны улмаас хүч хавсарсан хэрэглэлүүд хоцорч, барилгыг дайрахад оролцож чадаагүй юм.

Дайрах нэг бүлэг, гудамжны баруун талаар явж нөгөө нь дайсны ухрах замыг таслахын тул түүний ар хударгаар оржээ. Хоёр бүлэг, байшинд нэг зэрэг ойртож байв. Дайралтын дохио бол түрүүч Корчагины хаясан гранатын дэлбэрэлт болжээ. Корчагин, байшинд сэмхэн гэтэж очоод, доод давхрын цонхоор гранатыг хаяж дараа нь цонхны дээр үсрэн гараад эсэргүүцлээ тавиагүй байсан японуудыг дайруулан автоматаар хэдэн ээлж галалж улмаар коридорт орох үүдийг чиглэн шуурхайлж хоёрдахь гранатыг тэр зүгт хаяв.

Анх дорд давхарт, дараа дээд давхарт дайран орсон бүх бүлэг, түрүүч түүний жишээг дагаж тэнд Японы офицеруудтай дайралдаж тэднийг олзлогдон бууж өгүүлэв. Дайсан, дороо эсэргүүцээр байсан боловч түүнийг хоёрдугаар дайрах бүлэг, автоматын галаар устгажээ.

Бас нэг хотын төлөө байлдахад ахлах дэслэгч Плужниковын автоматчны рот, мөн ийм аргаар ажиллажээ. Энд 4—5 хүнтэй сөнөөгч жижиг бүлгүүд бий болж артиллерийн бэлтгэлийн дараа танкийн хойно даган гудамжинд орж түүнийг галаар самнан дараа нь дайсныг байшин зоорь дотор ховх цохиж байжээ.

Сөнөөгч бүлгийн дотор үүрэг хуваагдаж байсан нь: нэг байлдагч гранатыг хаяж, хоёр нь автоматаар галлан, бас нэг буюу хоёр нь шинэ тэмдэгт өөрөөр хэлбэл дайсны гэнэт буудаж болох газрыг «тасалж» байжээ.

Бага дэслэгч Кузнецовын бүлэг тийм аргаар ажиллан богино хугацааны дотор бүхэл гудамжны баруун талыг ариутгаж дайсны хэдэн цэрэг, офицерыг устгажээ.

Гудамжны байлдааныг амжилттай хийх нь ил хараагаар буудах их буугийн тоот нар ба миномет танкийн экипажуудтай дайрах бүлгүүд хоорондоо тодорхой харилцан ажилласнаас болно. Үүнд байлдааныг удирдах даргын чадвар чухал холбогдолтой. Туршлагаас үзэхэд радиогоос гадна дарцаг, гарын гэрэл, даллаж, исгэрэх, гэрэлт сум, пуужин зэрэг холбооны хялбар хэрэглэлүүд туйлын ашигтай байдаг. Эдгээрийг цэргийн сургуульд байнга хэрэглэлбэл зохино.

ДАЙРАХ БҮЛГҮҮД ГУДАМЖИНД ТУЛАЛДАХ НЬ

Дайрах бүлгүүд, гудамжны тулалдааныг их хэмжээгээр явуулдаг байв. Тэдгээр бүлгүүдийг манай цэрэг, чадамгай хэрэглэж байсан учир хот газар хориглосон дайсны давуутай зүйлүүдийг дарж арилгадаг байв. Дайрах бүлгүүд нь санаачлагатай шийдэмгий ажиллаж, дайсны хориглолтын чухал голломтуудыг дараад, түүний байлдааны журмыг сарниулж, манай гол хүчний ахилтыг хөнгөн болгож өгдөг байлаа.

Аль нэгэн үед дайрах бүлгүүдийн тэр хэмжээ нь хот орны байшин барилга, дайсны хориглолтын системийн байдлаас нөлөөлөгдөн тогтоогддог байв. Бас дайрах бүлгүүдийг танк эсэргүүцэх хорооны ба дивизийн их буу, танк, өөрөө явах их буу, хүнд пулемет, миномет зэргээр хүч нэмэгдүүлж өх нь чухал юм. Чухам ингэж хүч нэмэгдүүлснээр дайрах бүлгүүдийн хөдөлгөөн, маневрал, мөн байлдааны үүргийг амжилттай шийдвэрлэхэд чухал болох галын хүчээр хангалттай болгодог байв.

Дайрах бүлгүүд нь атаклах, бэхжүүлэх, галлах ба бэлтгэл эдгээр дөрвөн хэсэгт хуваагддаг байлаа. Тэгээд дайрах бүлэг нь хөнгөн зэвсэглэл бүхий идэвхтэй ажиллах анги, хүнд зэвсэглэл бүхий туслах анги гэх зэрэг 2 хэсгээс үндсэндээ бүрэлддэг байжээ. Харин дайсантай тэмцэх гол бэрхшээлийг атаклах ба бэхжүүлэх эхний хоёр хэсэг нь нуруундаа үүрдэг байв. Тэдгээр хэсгүүд нь дайсанд буудагдахгүй байгаа цэцэрлэг, гудамж зэргийг ашиглаж хотын гүнд цөмрөн, зарим орон, байшинг эзлэн аваад өөрийнхөө галаар дайсанд цохилтыг өгч, түүний холбоо ба удирдлагыг алдагдуулж байв.

Дайны туршлагаас үзэхэд дайрах бүлгүүд нь хотын доторхи бэхлэлт бүхий орон байшинг эргэн тойрон ороож, гудамж ба хашааны талаас нэгэн зэрэг дайрах арга нилээд тустай байдаг байлаа. Ийм аргын жишээ болгож Кенигсберг хотын гудамжинд болсон явдлыг хэлж болно.

Дайрах бүлгийг тулалдах газартаа ойртон очмогц, давшигч ангийн 45 мм-ийн их буу ба хорооны их буунууд нь тэнд байгаа дайсны галт байруудыг буудаж байшингийн дорд давхарагануудын цонхыг эвдэлж өгөв. Мөн дивизийн их буунууд нь хуяг нэвтлэх сумаар байшингийн дорд ханануудыг буудан эвдлэж, 122 мм-ийн их буу, танк өөрөө явах их буунууд нь байшингийн дээд талыг буудан нурааж байв. Ийм журмаар 20 минут гал нээв.

Энэ үед явган цэрэг нь атак хийх газартаа 50—100 метр ойртож эхлэх байрыг эзлэн авав. Инженерийн цэргүүд, саад боомтыг эвдлэж явах замыг гаргав. Галын дайралт дуусмагц, явган цэргүүд нь буудагдаж эвдэрсэн хана, цонх зэргийг

ашиглан урагш давшив. Бас нэгэн жижиг салбар байшингийн ар талаар нь давшиж, хойт талын хаалгыг дэлбэлээд ар талаар нь орж ирэв. Тэгээд хоёр талаас нь давшсан салбарууд, тохилдсон тасалгаануудыг цэвэрлэсээр, бие биетэйгээ учрав. Дараагийн тасалгаануудыг эзлэхийн тулд хаалгыг эвдэх буюу эсхүүл гранат хаяж дэлбэлдэг байлаа. Үүний дараагаар нүх гаргасан газраараа гранат шиддэг байв. Давшигч салбарууд нь ганцхан цагийн дотор бүх дорд давхаргыг цэвэрлэж, 200 гитлерчүүдийг устгаад 250-ыг баривчлав. Давшигчид нь дорд давхаргыг бүрэн эзлэж, түүнд хориглох бэлтгэлийг хийгээд цаашид бүх байшинг эзлэх тэмцэлд бэлтгэв.

Мөн хотын төвд давшилтыг хийсэн салбар нь байшинд ойртон очиж, их буугаар буудан нүх гаргаад дараа нь захын байшингуудыг эзлэн авч ойр зэрлэгдээ байгаа байшингуудыг германуудаас бүрмөсөн цэвэрлэв.

Нэгэн салбарыг гудамжны талаас атаклаж байхад нөгөө салбар нь эзэлж авсан байшингийн дээд давхаргаас зэргэлдээ байшингийн дээд давхаргыг буудаж, улмаар эзэлдэг байв. Дайрах бүлгүүдийн эрчимтэй давшилтын дүнд дээд давхарт байсан германууд дорогш бууж ороход хүрээд гудамжнаас давшиж байгаа салбартай тулгаран, устгагддаг байв.

Энэ жишээнээс үзэхэд хэрэв зэргэлдээ гудамж тийш цөмрөн орж болохгүй байвал их буу буюу дэлбэлэх хэрэгслээр түүний байшингийн ханыг эвдлэх нь чухал юм. Атаклаж байгаа салбарууд нь гудамжаар явж чадахгүй байгаа бол тэрхүү эвдэлсэн нүхээр дамжин нөгөө гудамжинд нэвтэрч болдог байна.

Хотыг эзлэн авахад дотор нь байлдаж байгаа салбарууд ихээхэн жижиглэгддэг бөгөөд тэдгээр жижиг бүлгүүдийн санаачлага ямар байгаагаас болж тулалдааны амжилт шийдвэрлэгдэх болно. Тэд нар орон байшинд цөмрөн ормогц, юуны өмнө дайсныг их буугийн давшилтын үед хоргодож байсан нүхнээс нь гаргахгүй болгох арга хэмжээг авах хэрэгтэй. Үүнд хэрэв бололцоо байвал тэдгээр нүхнүүдийн аман дээр отолтыг тавих ба дээш гаргах шатуудыг эвдлэх нь ашигтай юм.

Нэгэнт эзэлж авсан байшиндаа удаан байж хэрхэвч болохгүй, учир нь дайны явцыг удаашруулахад хүрэх болно. Дайрах тасаг (Салаа) нь дараагийн байшингийн зүг хамгийн хурдан давших цаашдын газруудыг эзлэн авах үүрэгтэй байна. Туслах бүлэг нь атаклах бүлгийн хойноос тасрахгүй дагалдах ба бэлтгэл хэсэг нь эзэлсэн байшинг бүрмөсөн цэвэрлэх ёстой.

Хотын дотор байлдахад явган цэрэг нь атаклах байрыг дагаж явж болохгүй ба ар тал, цэцэрлэг, буудагдсан нүх зэргийг ашиглан ахиж хэрэгтэй юм. Үүнд: их буунууд нь явган

цэргээс хоцрохгүй, түүний хамт атаклах шинэ байранд шилжин явах хэрэгтэй.

Хэрэв дайсан этгээд нь автомат ба пулеметоор буудаж атаклах газарт хүргэхгүй байвал дайрах бүлгийн бүрэлдэхүүнд яваа танкийг ашиглах хэрэгтэй. Явган цэрэг нь танкийн хуягаар халхлуулан атаклах газарт ойртож, цагийн байдлыг харгалзан ажиллах хэрэгтэй.

Газрын байдал нь битүүлэг байвал хотын дотор байралсан дайсны галт чигүүдийг илрүүлэхэд хүнд бэрх байх болно. Ийм дээрээс дайрах бүлгийг ажиллуулахын өмнө нарийн тагнуулыг явуулах хэрэгтэй. Түүнээс гадна дайсныг цохих ба дайрах бүлгийг тасралтгүй зузаатгаж өх бэлтгэл хүчтэй байх нь чухал юм.

Гадамжны тулалдаанд дарга нар ба бүх хүмүүсийн санаачлага, шийдэмгий байдал, цэргийн уран заль эдгээр нь онц чухал ач холбогдолтой байх болно.

ТУШААЛЫГ ӨХ БА ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ

Манай офицерүүд улсын өмнө маш их итгэл найдварыг хүлээсэн хүмүүс мөн. Бид нарт, захирагдсан хүмүүст тушаал өх эрхийг олгожээ. Энэ эрх үүргийг эрхэм сайнаар биелүүлэх ёстой байна. Даргын тушаал бол захирагдсан хүмүүст хууль мөн. Түүнийг хаана боловч, хэзээ ямагт, үг дуугүй тодорхой, цаг хугацаанд нь биелүүл гэж манай сахилга журмын дүрэм дотор заасан байдаг. Энэ бол сахилга журам ба цэргийн доторхи эмх дэглэмийн нэгэн үндэс бөгөөд цэргийн албан хаагчдын үндсэн үүргийн нэг нь мөн.

Тушаал зааврыг өх ба гүйцэтгэх тухай дотоодын албаны дүрэмд тодорхой заасан байдаг. Бүх тушаал зааврыг журам мэт, захирагдах журмыг баримтлан өх ёстой. Өөрөөр хэлбэл ахлах тушаалын дарга шууд захирагдсан хүнээр гүйцэтгэгч хүнд тушаалаа өгнө. Тушаал авсан цэргийн албан хаагч «мэдлээ» гэж хариулдаг. Энэ нь тэр тушаал авсан цэргийн албан хаагч уг тушаалыг зөв ойлгосон ба тушаасан ёсоор нь гүйцэтгэнэ гэсэн хариулт юм. Дарга өгсөн тушаалыг зөв ойлгосныг магадлахыг хүсвэл, өгсөн тушаалаа доод тушаалын хүнээс товчоор давтахыг шаардах эрхтэй байна.

Авсан тушаалыг гүйцэтгэсэн тухай цэргийн албан хаагч бүхэн тушаал өгсөн даргад эргэж заавал мэдэгдэх үүрэгтэй.

Зарим нэгэн чухал цаг үед шууд захирсан даргыг алгасан тушаалыг шууд өх явдал тохиолдоно. Ийм үед тушаал авсан хүн уг тушаалыг гүйцэтгэж, энэ тухай өөрийн шууд захирсан даргадаа илтгэх үүрэгтэй.

Бас дүрэм дотор дурдсан нь хэрэв тушаал гүйцэтгэж яваа цэргийн албан хаагч, өөр даргаас шинэ тушаал авбал, нэгдүгээр тушаалыг гүйцэтгэхэд саад болохоор байвал, энэ тухай шинэ тушаал өгсөн даргад илтгэх ёстой бөгөөд тэр даргаас дахин шаардвал сүүлийн тушаалыг биелүүлнэ. Шинэ тушаалыг өгсөн дарга нэгдүгээр тушаалыг өгсөн даргад мэдэгдэх бөгөөд эцсийн хариуцлагыг хүлээнэ.

Тушаал, зааврыг дарга өөрийн биеэр, амаар буюу бичгээр өхөөс гадна дохио, тэмдгээр, офицер, холбоочин байлдагчаар дамжуулан өх, бас холбооны янз бүрийн хэрэгслийг ашиглан өгч болно.

Ямар нэгэн байдлын дотор, аль нэгэн аргаар дамжуулан өгсөн, даргын тушаал бүхэн захирагдсан хүмүүсийн өмнө тавьсан хатуу шаардлага мөн. Даргаас тушаал өх явдал бол өөрийн хүсэл эрмэлзэлгээг доод тушаалын хүмүүст нэвтрүүлэн мэдэгдэж байгаа хэрэг бөгөөд доод тушаалын хүмүүст цэргийн үүргийн хувиар оногдсон албан үүргэд нь тулган шаардаж байгаа хэрэг мөн. Үүнд манай зарим нэгэн дарга нараас өгсөн тушаал тэр болгон тодорхой биелэдэггүй, биелэгдсэн болвоч дутуу дунд биелэгдсэн байдаг. Үүний шалтгаан нь ганцхүү доод тушаалын хүмүүсийн сахилга сул байгаад холбогдоод зогсох биш, тэр дарга нараас тушаалаа зөв өгч ойлгуулж чаддаггүй, өгсөн тушаалынхаа биелэлтийг шалгадаггүй явдалд оршино.

Даргаас өөрийн шаардлагыг зөв тодорхой гаргаж чадах явдал бол доод хүмүүсээс тушаалыг зөв тодорхой гүйцэтгэх чухал нөхцөлийн нэг мөн. Товч тодорхой өгсөн тушаал доод тушаалын хүмүүст тавьсан шаардлагыг түргэн ухаж мэдэх бололцоог олгоно. Тодорхой бусаар өгсөн тушаал, гол төлөв эргэлзэх байдалд оруулж, тайван цагт цэргийн ёс журмыг эвдэхэд хүргэдэг ба байлдааны цагт улам хүнд байдалд учруулж болно.

Түүнээс гадна, дарга тушаал өхдөө ямар нэгэн эргэлзэх байдалгүйгээр, өгсөн тушаалынхаа бүх хариуцлагыг өөртөө хүлээн авахад хэзээч бэлхэн байхаар хатуу өгвөл зохино. Цагийн байдал хэцүү хүнд болох тутам, тушаал улам тодорхой, эрс хатуу байвал зохино.

Тушаал өх үед ялангуяа хүнд цагт, тушаал өгч байгаа даргын дуу онц ач холбогдолтой байдаг. Тогтуун, эрс зоригтой дуугаар өгсөн тушаал, доод тушаалын хүмүүсийн санаа сэтгэлд батаар хадагдаж, тэд нарт тушаалыг гүйцэтгэх зориг, шийдвэрийг оруулана. Эмх журамгүй, өгсөн тушаал, доод ту-

шаалын хүмүүсийг эргэлзэх байдалд хүргэж тушаалын гүйцэтгэлийн чанарыг сулруулдаг байна. Энэ тухай зарим нэгэн, жишээнүүдийг авч үзье. Манай офицерүүдийн дотор тушаалыг асуултын буюу гүйврын чанартайгаар, маш дорой байдалтайгаар өгдөг хүмүүс цөөнгүй үзэгддэг. Жишээ нь: «таа! хувцсаа зас» гэж эрс тушаахын оронд «таа хувцсаа яагаад засахгүй байгаа юм бэ?» гэж асуудаг «Тасгаа сургуульд нь гарга» гэж тушаахын оронд «тасгаа сургуульд нь гаргаж үз хүү минь» гэж хэлдэг. Энэ мэтээр асуух буюу гуйх чанартайгаар тушаал өгсөн уршгаас болж доод тушаалын хүнийг тэр даргын өөдөөс юм ярих шалтгаан дурдах тайлбар өх, тэр ч байтугай адрах байдалд хүргэнэ, үүнээс даамжраад тэр даргаас, доод тушаалын хүндээ арга хэмжээ авах байдалд хүргэдэг байна. Тушаал өгч байгаа дарга цагийн байдлыг үнэлж, тушаалыг тодорхой гүйцэтгэж болох бүх бололцоонуудыг бодож үзэх ёстой.

Биеийн хүчин чадал ба ерөнхий мэдэц, тэрчлэн алба хаасан туршлагаараа, үнэхээр хүчин үл хүрэлцэх зүйлийг доод тушаалын хүмүүсээс заавал гүйцэтгэ гэж шаардаж болохгүй гэдгийг мартаж болохгүй. Бас цагийн байдлыг бодож үзэх хэрэгтэй. Зарим тушаалыг гүйцэтгэхэд хэдэн минут хэрэгтэй байдаг, нөгөө нэг тушаалыг гүйцэтгэхэд их хугацаа хэд хэдэн цаг буюу өдөр хэрэгтэй байдаг. Иймд тушаал өгч байгаа дарга уул тушаалыг гүйцэтгэхэд хэчнээн цаг хугацаа хэрэгтэйг урьдаар бодож үзээд тушаал гүйцэтгэх хугацааг заавал заасан байвал зохино.

Хүмүүсээс тушаалыг гүйцэтгэхэд өөр нэг чухал зүйл байдаг. Энэ нь өгч байга тушаалууд нэг нь нөгөөдөө харштай байж болохгүй. Цэргийг сургаа хүмүүжүүлэх ба дотоодын эмх журамд холбогдсон бүх дарга нарын тушаал хоорондоо, зөвлөсөн ба нэг нь нөгөөдөө туслах байвал зохино. Үүнд сумангийн дарга нар өөрийн сумангийн офицерүүд ба бага дарга нарын тушаал заавар нэгдмэл байх, хорооны дарга, сумангийн дарга, штабын бусад офицерүүдийн тушаал заавар нэгдмэл байх явдал хянан үзэх ёстой байна.

Өгсөн тушаал тэр ёсоороо гүйцэтгэгдэж байгаа эсэхийг хянан үзэх явдал, тушаал өгсөн даргын ариун үүрэг мөн. Үүнийг өгсөн тушаалын гүйцэтгэлийг үргэлж шалгах замаар гүйцэтгэнэ. Аль ч албаны шугамаар өгсөн тушаал бүхний гүйцэтгэлтийг шалгалтгүйгээр өнгөрүүлж, болохгүй гэдгийг дарга бүхэн мартажгүй, үргэлж хичээн ажиллавал зохино. Энэ нь доод тушаалын хүмүүсийг дарга бүхний тушаалыг хэзээ ямагт тодорхой биелүүлдэг заншилтай хүмүүжүүлж чадна.

Тушаалын гүйцэтгэлтийн шалгалтыг зарчимгүйгээр хааяа нэг санахдаа явуулах юм бол түүнээс ямар нэгэн ач тус гар-

даггүй .Ийм зарчимгүйгээр явуулсан шалгалт нь нэг их үйм-ээн шуугиан болж, салхи шуурга мэт хуйлран өнгөрөхөөс биш, хүнийг ямар нэг юманд сургадаггүй. Хамгийн сайн ажиллагаатай хүний бүтээсэн үйл хэргийг түүний ахлагчаас үнэлж үзэхгүй өнгөрүүлбэл тэр сайн ажиллагаатай хүн ажил хэрэгтээ хоомой оролцдог болж болно. Үүнд тушаал зааврыг идэвх санаачлагатай гүйцэтгэсэн хүнийг ахлагч даргаас нь өргөн сайшааж байх, хэрэв тушаал зааврыг гүйцэтгэхдээ цалгар назгай ,хойрго, залхуу, байдлыг гаргасан хүнийг зэмлэн шийтгэж байх нь маш чухал юм .Ганцхүү даргын зүгээс, тушаалын гүйцэтгэлтийг цаг ямагт анхааралтайгаар хатуу шалгаж байвал сая түүнийг биелүүлж болно.

Дарга хүн албан үүргээ гүйцэтгэх, хууль дүрмийг хатуу баримтлан сахих, ахлагчийн бүх тушаал зааврыг үг дуугүйгээр зөв тодорхой биелүүлэх талаар өөрийн дор захирагдсан хүмүүст хэзээд үлгэр дууриал болж байх хэрэгтэй.

«Бусдыг захирахаас өмнө, өөрөө захирагдаж сур» гэж алдарт их жанжин Суворовын хэлснийг хэзээд санаж явах хэрэгтэй. Дарга хүний албан үүргээ цуцалтгүй чин зоригтойгоор гүйцэтгэх явдал захирагдсан хүмүүст сайн нөлөөг үзүүлнэ. Өөрийнхөө даргыг дууриаж, захирагдсан хүн, даргынхаа нэгэн адил тушаал зааврыг тодорхой гүйцэтгэдэг болно.

ШТАБЫН ОФИЦЕРУУДЫН СУРГУУЛИЙГ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Штаб нь цэргийг удирдах явдлыг зохион байгуулах ба хангах болно. Иймд штабын албаны офицер нар тактикийн ба цэргийн бусад мэрэгжлийн талаар өндөр чадвартай байх хэрэгтэй. Одоогийн төрөл бүрийн цэргийн штабын бүх ажиллагаа нь туйлын нарийн цэгц боловсон, зохион байгуулалттайгаараа ялгардаг байх ёстой. Байлдааны явц дундуур штабын албаны дадлагатай офицерууд нь дайсны тухай мэдээг дүүрэн олж, түүнийг сайтар боловсруулан дүгнэж даргадаа илтгэх, дээд штабтаа цаг тухайд нь мэдэгдэж, даргын шийдвэрийг, анги нэгтгэлдээ түргэн хүргэнэ. Даргын шийдвэрийг анги нэгтгэл нь зөвөөр биелүүлж байгаа эсэхийг цаг тухайд нь сайнаар шалгаж, дутагдлыг түргэн засаж чаддаг байна. Дээр дурдсан ажлыг чадвартайгаар гүйцэтгэхэд зохион байгуулах уран арга, цэргийн мэдэц хэрэгтэй болно. Иймд штабын албаны

офицер нар нь нь өөрийн үүрэгт ажилд мэрэгжсэн байхын гадна, штабын ямар ч ажлын офицерыг сольж аваад ажиллах чадвартай вайх ёстой. Штабын албаны офицер бол штабын ажлын арга техникт онцоор сурсан байх үүнд: байлдааны бичиг ба зургаар хийх бичиг баримтыг нягтаар түргэн үйлдэж чадах, дайсны ба цагийн байдлын тухай мэдээнүүдийг олж аваад, түүнээс зөв дүн гаргаж чадах, дайсны ба цагийн байдлын зургийг үнэн зөв бөгөөд цэврээр хөтөлж чадах хэрэгтэй. Анги нэгтгэлийн дарга нь өөрийн штабыг удирдах гол эзэн мөн гэгчийг хатуугаар мэдэж штабаа бэлтгэх үүргийг шууд хүлээх ёстой. Анги буюу нэгтгэлийн дарга нар, өөрсдөө штабын ажлыг сайн мэдэх ба штабыг сургаж чадах чадвартай байх ёстой. Цэргийн боловсрол муутай, штабын ажлин арга дадлагагүй ангийн дарга нь штабыг сургах ч байтугай ангиа удирдаж чадахгүй болно. Штабыг сургах арга бол олон янз байдаг юм. Штабын албаны ямар мэрэгжлийн офицерыг юунд сургах, хэнээр юуг судлуулах, штабын албаны төрөл бүрийн мэрэгжлийн офицеруудыг тус тусын мэрэгжилд сургах ба аль алиныхаа ажлыг хэн нь ч гүйцэтгэж чадах болгоход олон зүйлийн арга ба мэдрэл шаардагдана.

Иймд штабыг сайнаар бэлтгэхийн тулд дор дурдсан аргыг хэрэглэвэл зохино.

1. Штабын хээрийн сургуулийг холбооны хэрэглэлтэйгээр хийх.

2. Командын ба штабын сургуулийг бүх төрлийн цэрэг, ардын албаны хамтаар гарч хийх.

3. Цэрэгтэйгээр хээрийн сургууль хийж, цэргийг жинхэнэ байлдааны журмаар удирдаж дадлага олох.

Эдгээр нь хамгийн зөв сайн арга бөгөөд ийм сургууль хийхэд бүх төрлийн цэргийг байлдааны цагт ашиглах ба удирдах, тэдгээрийг удирдах аргад сурахад хялбар болно.

Штабын сургуулийн зорилго бол штабыг байлдааны хүнд бэрх цаг үед цэргийг удирдах аргад сургахад оршино. Штабын дадлагын сургуулийг хээр явуулахдаа хоёр талын буюу, дайсныг бодитойгоор дүрсэлж явуулна. Үүнд тагнуул, хамгаалах зэрэг байлдааны бүх хангалтын ажлыг бүрэн хийж сургуулилна.

Штабын сургуулийг явуулахдаа, дайсныг зураг дээр дүрслэхдээ газар орны байдлыг харгалзан өөрийн хүч хүрэлцэх, сургуулийн зорилгыг биелүүлж чадахаар зохиох хэрэгтэй. Дайсны байралсан газарт дайсны тийм ийм галын систем байна гэх зэргээр үзүүлж, дарга нарын тагнуулыг явуулах ба хяналтыг зохиох, газар орны байдлыг сургуулилах зэргийн асуултад сургах, ар талыг хэдэн тэрэг ба машинаар үзүүлж болно.

Ангийн штабын сургуулийг ангийн дарга удирдвал дундын хянагчаар штабын сургуульд оролцохгүй нэг офицерыг томилж болно.

Штабын сургуулийн удирдагч нар ба дундын хянагч нарыг бэлтгэх нь штабын сургуулийн бэлтгэлийн нэгэн чухал хэсэг нь мөн. Штабын сургуулиар боловсруулах үүрэг нь хичнээн бэрх байвал төчнөөн сайнаар дундын хянагч нарыг бэлтгэх ба удирдагч өөрөө ч сайнаар биеэ бэлтгэх нь чухал болно. Сургууль явуулах төлөвлөгөөндөө дайсны ажиллагааны тухай нэмэгдэл үүргийг тохируулан цаг тухайд нь өх явдал дээр онц анхаарлыг тавих нь чухал. Цагийн байдлаар дайсны ажиллагааны тухай нэмэгдэл үүргийг өхдөө сургуулийн үүргийг гүйцэтгэхэд тохирсон ба дайсны байдлыг нарийн нямбай тодорхойгоор үзүүлэх нь чухал юм. Нэмэгдэл үүрэг нь доороос дээш, өөрөөр хэлбэл салбарууддаа мэдэгдэх болно. Мөн нэмэгдэл үүрэг мэдээнүүдийг амаар буюу бичгээр, телефон утсаар, байлдааны мэдээгээр, хяналтын дуугаар ч мэдэгдэж болно. Сургууль явуулах газрыг сонгон олох, дайсныг дүрслэн үзүүлэх, галын системийн зохион байгуулалтыг үзүүлэх, тагнуулын байгууллагуудын баххяналтын ажиллагаа, практикийн ажиллагааг шалган үзэх энэ бүх ажил нь цөм штабын сургуулийг жинхэнэ байлдааны ажиллагаагаар ажиллуулахад үялдсан байх ёстой.

Штабын сургуулиас, штабын ажиллагааны арга маягийг олж авч чадахаар, сонирхолтойгоор зохион явуулагдсан байх ёстой. Дарга өөрийн штабын офицеруудын хийх тактикийн сургуулийг хэрхэн хийх тухай шийдвэр өгнө.

Штаб нь хээрийн сургуулийн бэлтгэлийг даргын өгсөн үүргийн ёсоор сайтар хангах хэрэгтэй. Ингэж чадвал штабын сургууль сайн-чанартай болно.

ДОТООД ЖУРАМ БОЛ АНГИЙН АЖИЛ, СУРГУУЛИЙН ЗӨРЦӨШГҮЙ ХУУЛЬ!

Анги, салбар бүхэнд дотоод журмыг хатуу баримталж хонгийн харуулын албыг тодорхой гүйцэтгэх нь өвлийн үеийн байлдааны ба улс төрийн бэлтгэлийн үүргийг амжилттай биелүүлхийн нэгэн үндсэн нөхцөл болно,

Дээд сахилга, зөрцөшгүй журам бол байлдааны сургуулийн үнэн амжилтыг хангадаг. Эдгээрийн үндэс бол, өдрийн цагийн хувиар мөн. Сургуулийг чанаржуулах ба байлдагч нарыг манай цэргийн дүрмийн шаардлагын ёсоор зөв хүмүүжүүлэх нь түрүүч, ахлагч нар, түүнчлэн офицерүүд, өдрийн цагийн хувиарыг хэрэг дээр нь хэрхэн биелүүлэхтэй шууд холбогдоно.

Дотоод журам бол албан ажил ба байлдааны үүргийг тодорхой гүйцэтгэхэд дайчин нарыг дадлагатай болгоно.

Юм бүхэнд ба ер нь цэргийн дотор, дотоод журмыг сахиулах шаардлага бол онц хатуу байх ёстой. Олонхи түрүүч, офицер үүний учрыг сайн ойлгожээ. Ялангуяа манай тэргүүний ахлагч, жагсаалын дарга нар ангидаа алдаршин, байлдагч нарыг яг цагт нь босгож, биеийн тамирыг заавал хийлгэн, өглөөний үзлэгт жагсаан, сургуульд нь саадгүй болгож байна. Ингэж ажиллагч түрүүч, ахлагч нар бол жижиг ангийн дотор зөрцөшгүй журамтай болгоход нь өөрийн даргыг үнэнч туслагч нар мөн болно. Эдгээр бага дарга, цэргийн сахилгыг чин сэтгэлийн үүднээс чангатган, ганц ч байлдагчийг сургуулийн цагаар дэмий сэлгүүцүүлэхгүй, бүгдийг байлдааны бэлтгэрээр хичээллүүлхийн төлөө тэмцэж байна. Ийм сайн ажилтай бага дарга нарын удирдсан салбарууд, ангидаа тэргүүн суурийг эзэлж байгаа ба өвлийн үед байлдааны бэлтгэлийн төлөвлөгөөт сургууль амжилттай болох нь аргагүй. Тэргүүний жижиг ангийн дарга нар бол цэргийн журмыг бататгахын төлөө тэмцэхдээ, тасгийн дарга, түрүүч нарыг түшиглэж, офицеруудын зүгээс, ялангуяа сумангийн даргаас үргэлжийн дэмжилгэтэйгээр ажиллаж байна.

Манай түрүүч бүхэн захирагдагч нарыг аяж чадамгай хүмүүжүүлхийг ажил нэгтэй бөгөөд тэргүүний туршилгыг олсон нөхдөөсөө сурах хэрэгтэй. Байлдагч бол, наад зах нь, байвал зохих газартаа хэзээ ямагт оногдсон цаг, минутын дотор заавал бэлэн байх үүрэгтэй. Жагсаал ба өглөөний үзлэг, оройн шалгалтад хожидон, босохдоо удаан буюу ор, дэрээ муу засаж, улмаар хуураангийн дотор, тогтсон журмыг зөрдөг цалгар байлдагчийг чанга шаардлагатайгаар хүмүүжүүлэх хэрэгтэй.

Цэргийн аж байдал дээр цэгцтэй, нямбай сураагүй байлдагчийг түрүүч өөрөө, хамгийн хатуу шаардан сургаж, даргын эрхийнхээ ёсоор сахилгын шийтгэлээ бүрэн хэрэглэн хүмүүжүүлэх ёстой.

Дотоод журам бол тун сайн замбараатай, суман салаанд өдөр ирэх тутам, улам батаждаг байна. Гэтэл зарим жижиг ангид байлдагч нарыг «чухал» ажлаар шалтаг болгож сургуулиас хөндийрүүлж замбараагаа алдаж одоо болтол байлдааны сургуульд хүнийг жигд оролцуулж чаддаггүй байна.

Хаяа жижиг ангид сургуулийн оногдолт цагийг ондоо «шалтгаанаар» гарз болгосон байна.

Хэрэв хичээлийн цагийг хий дэмий үрэгчидтэй шийдэмгий тэмцэхгүй бол, хожим хайран цагийг нөхөж болохгүйд хүргэнэ. Энэ гэмийг эцэс болгон элдэв «шалтгаанаар» сургуульд гаад хийхийг эрс зогсоох хэрэгтэй. Цэргийн ангиас харуулын ба дотоодын аливаа аж ахуйн ажилд хүнийг томилохдоо ангийн даргын баталсан төлөвлөгөөг яг баримтлана. Харин жагсаалын дарга буюу жижиг ангийн аль нэг тохиолдсон даргын мэдэх хэрэг биш. Манай цэргийн бүх хүмүүсийн байлдааны бэлтгэлийг заах аргын шаардлагыг ухралтгүй биелүүлэх хэрэгтэй.

Байлдагчийг сургуулийн цагаар ангийн даргын төлөвлөгөөнд ороогүй ажилд хэрэглэх нь хориотой байх ёстой. Хурал, зөвөлгөөнийг сургуулийн гадна цагт хийх хэрэгтэй. Цэргийн хуаран, танхим, сууцад дотоодын албаны дүрмийн ёсоор байх нь чухал. Жишээлбэл: Шинел, үстэй дээл зэрэг хэрэглэл бол тусгай оногдолт газарт өлгүүр дээр хадгалагдах ёстой. Бас бүх байр боловсон, эмхтэй, цэбэр байх ёстой. Энэ бол санахад «ялимгүй» боловч байлдагчийг сахилгажуулдаг зүйлийн нэг мөн бөгөөд түүний биеийг дээш татаж, гадаад үзэмж ба зан авир дээр нь ч нөлөөлдөг байна. Хоногийн харуул болдог дежур, дневалын албыг тодорхой гүйцэтгэх нь дотоод журмыг сахихад их рольтой байдаг.

Энэ бол хоногийн харуулд гардаг байлдагч, түрүүч нарт замбараа ба журамтай байхын хамгийн практик сургууль мөн байна. Дневал буюу дежур бол өөрийн пост дээр хэзээ ч сэрэмжтэй байж, сумангийн дарга, жагсаалын даргын аливаа нэгэн тушаалыг биелүүлэхэд байнга бэлхэн байх ёстой.

Дежур дневал бол гадаад үзэмжээр биечлэн үлгэрэлж, албаа гавшгай гүйцэтгэн, сумангийн дотоод журмыг өдөр шөнийн хорин дөрвөн цагт зөрцөшгүй баримтлан, босхоос унтах хүртэл байлдагч нарын бүх ажил ба сургуулийг өдрийн цагийн хувиарын ёсоор яг гүйцэтгэх, хуараны дотор дүрмийн бүх шаардлагыг зүйлчлэн биелүүлхийн төлөө идэвхтэй ажиллах үүрэгтэй. Харуулынхан бол үүргээ гүйцэд мэдсэн байх ёстой. Энэ талаар дежур, дневал, «дарга ба захирагдагч нар» гэдэг номын дотор гардаг сургаалыг дагавал зохино. Бүрэн журамтай байхын тул тэр номноос авч ажил дээр хэрэглүүштэй сургамж зөндөө бий.

Байлдааны бэлтгэлийн сургууль өдрөөс өдөрт улам ахиж байна.

Монголын дайчин бүхэнд одоо нэмэгдсэн шаардлага тулгаран байна. Манай байлдагч, түрүүч, офицер, генерал, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүхт 25 жилийн ойг угтаж анги бүхэнд ажлын их амжилтыг гарган, өвлийн сургуулийн

төлөвлөгөөг дүүрэн гүйцэтгэхийн төлөө улс төрийн урам зоригтойгор, хүч хөдөлмөрөө шавхан дайчилж байна.

Анги, салбар бүхэнд дотоод журмыг хичнээн тодорхой болгохын хирээр, цэргийн сахилга батжиж, байлдааны ба улс төрийн бэлтгэлд шинэ амжилт гарч, манай мандан цэцэглэж байгаа Эх Орны өмнө монголын цэргийн дайчны үүргийг бид алдартайгаар гүйцэтгэж чадна.

ХАЙГУУЛЫГ ДУТУУ ҮНЭЛЭХ НЬ ЮУ БОЛОХ ВЭ?

Дарга, байлдах шийдвэрийг гаргахдаа цагийн байдлын бүх мэдээ, мөн дайсанд хамаарах мэдээг харгалздаг байна. Байлдаан бүхэн, өөрийн ялгарах онцлог зүйлүүдтэй билээ. Тэдгээр онцлог зүйл бол заримдаа газрын шинж, заримдаа давшилтын дунд туулагдах хориглолтын байрын бэхлэлтийн чанараар ялгарана.

Цагийн байдлыг шинжлэхдээ байлдаан болохтой уялдуулан, түүний нөхцөл бүрийн холбогдлыг тодорхойлох хэрэгтэй юм. Хайгуулын хүрэлцэх дэлгэрэнгүй мэдээтэй байгаа офицер бол, байлдаанд нөлөөлж болох бүх нөхцөлийг зөв бүртгэж чадна. Дайсныг зүйлчлэн судлах нь, амжилтын шийдвэрлэх нөхцөлийн нэг мөн. Энэ бол манай цэргийн хийж байсан ялалттай байлдаануудаар олон удаа батлагдсан. Бас туршлагаас үзвэл, хайгуулыг басамжлах буюу түүнийг чадваргүй зохиох нь, сүрхий бүтэлгүй явдалд хүргэдэг байна. Энэ тухай дараахь жишээ гэрчилнэ.

... Дугаар буучийн хорво. «Германыг хөөсөөр Тиссийн ойролцоо газарт хүрч, тэнд дайсны ширүүн эсэргүүцэлтэй тохиолджээ. Энэ газарт дайсны хориглолт, намагшсан газарт хоёр хажуугаараа тулсан тууш шугамын траншегаар бүрэлдэж байв. Голын яг эрэг дээр суурин газар, түүний цаана гүүр байв. Өндөр ургасан бут байсан, бас суурин газарт жимсийн ба бусад мод элбэг, түүнчлэн баруун талаас үргэлжилсэн шугуй байсан нь, дайсны гүүрийн тэнд голын эргийг манай хянагч нараас нууж байв. Германууд, сүрхий эсэргүүцэж байснаар үзвэл, тэд суурин газарт тэртээ эргэд гаталж амжаагүй үлэмж хүчтэй байсан гэж бодож болохоор байв.

Хушууч Козловын командалсан хоёрдугаар батальон, хорооны гол цохилтын чигт байлдаж байв. Батальоны үүрэг бол өөрт оногдсон газарт германыг траншегаас ховх цохиж, суу-

рин газрын баруун гарын (зүүн) хагас ба гатлуурыг эзэлж Тиссийг дамжих гүүрээр гатлан эргийн түшцийг эзлэх байжээ. Баруан гараас хажуугийн батальон цохив.

Энэ явдал болж байхад германууд, өөрийн хориглолтыг нилээд ондоо янзаар байгуулжээ. Тэд нэгдүгээр байрыг траншегаар хангаж, цааш ноёлогч өндөрлөгүүд ба суурингуудад заримдаа зүгээр тэгш газарт, ялангуяа түүний өмнө явахад хэцүү газар байсан бол тэнд дайсны мэдлийн түшигт газрууд байжээ. Эдгээр түшигт газар бол давшигч цэрэгт сүрхий саад болж байв. Тэнд траншег давсны дараа давшигч нарын байлдааны эрэмбэ ямар нэгэн хэмжээгээр эвдэрч байснаар бэрхшээлүүд нэмэгдэж байсан юм. Хэдий тийм боловч, шуурхайлан байлдах, түргэн ажиллах нь, түшигт газруудыг амжилттай бут ниргэх гол нөхцөлүүд байжээ Хажуугийн атакууд, хамгийн их амжилтыг өгч байв.

Батальоны дарга Германы траншег ротуудын шугамд орсон байлдааны эрэмбээр атаклаж, дараа нь түшигт газрыг пулеметийн хоёр салаагаар хүчлэгдсэн буучийн хоёр ротоор цохих шийдвэрийг гаргажээ. Эдгээр ротыг суурин газрын зүүнтэй гурван зуун метрт шугуйн захад урьдаар бөөгнөрүүлэх хэрэгтэй байв. Гуравдугаар рот, суурин газарт хүрэх замын дагуу фронтын зүгээс байлдах ёстой байв. Минометийн батаре, дайснаас ариутгагдсан транше дотор гол байрыг эзлээд, түшигт газрыг атаклахад өөрийн галаар дэмжих ёстой байв.

Артиллерийн сүрхий бэлтгэлийн дараа манай салбарууд, германы гтранше дотор нилээд хялбар ховх цохив. Хоёрдугаар батальон, түшигт газрыг дайрахад бэлтгэж байв. Бага зэрэг намдуун болсны дараа баруун хажуугийн хоёр рот, хавсаргагдсан пулеметийн салаадын хамт суурин газрыг тойрон, ойг чиглэн хөдлөв. Гуравдугаар рот, замыг түшиглэн буттай заагт бөөгнөрч байв. Учир нь баруунтай газар нь сүрхий намагшсан байжээ. Минометч нар, транше дотор байрыг эзлээд суурин газрыг дайруулан галлав

Энэ үед голын цаанаас германы артиллерийн батаре цохив. Хожим мэдэгдсэн нь, дайсан, өөрийн траншег урьд онож буудаж байсан тул одоо түүний их буугийн сум, минометч нарын галт байран дээр яг онож байжээ. Ийм бололцоотой байхыг урьдаар мэдэж болох байсан уу? гэвэл, Германы тактик бол шинэ биш, батальоны дарга, түүнийг харгалзах үүрэгтэй байсан боловч, шийдвэрийг гаргахдаа үүнийг гүйцэтгэсэнгүй дайсны онож буудаж, байсан байранд минометийн батарейг тавиад, түүнийг ажиллагаагүй болгоход хүргэжээ.

Манай артиллери, минометч нарын байрыг буудаж байсан Германы батарейг «тэмтэрч», байхад, батальонд бас нэг сүрхий бүтэлгүй явдал тохиолдож, түшигт газрыг атаклах төлөвлөгөөг бүрэн эвджээ. Юү гэвэл, суурин газрыг баруунаас

нь тойрсон ротууд шугуйд хүрмэгц, тэд пулеметийн сүрхий галд оржээ. Байлдагч нар, хэвтэж окоплох болов. Энэ завсар буттай заагт бөөгнөрсөн ротыг тосгоны тэндээс гарсан» Германы танкууд сөрөн атаклажээ. Батальоны дарга, танк — эсэргүүцэх артиллерийг авчирч амжаагүй тул рот гэдрэг ухрах болов.

Транше дотор тогтож чадаагүй дайсан, төчнөөн хүчийг ханаас авав? гэдэг асуулт гарна. Энэ бол хорооны дарга, салбаруудыг дахин бүлэглүүлж, галын далдлагдсан дэмжлэгтэйгээр баруунаас, нь цохиж суурин газрыг эзэлсэн хойно, сая илэрхий болов.

Манай явган цэрэг, дайсны цэргийн гатлуурыг халхалж байсан дайсны түшцэд ойртохоос өмнө зөвлөлтийн нисэх онгоцууд, Тиссийг гатлах гүүрийг эвдсэн байжээ. Германууд, түүнийг засварлаж, харин тэдний саатсан цэргүүд, суурин газар ба шугуйд бөөгнөрч, тэртээ талын эрэг дээр гатлахын тулд өөрийн ээлжийг хүлээж байв. Эдгээр цэргээс зарим нь манай давшигч салбаруудыг эсэргүүцэн сөрөх атакад оржээ.

Иймд хоёрдугаар батальоны хийсэн атак, амжилтгүй болов Яагаад? гэвэл нэгд, энэ бол батальоны ажиллагаа удаан байснаар тайлбарлагдана. Танк эсэргүүцэх их буунууд, явган цэргээс хоцорч хэрэглэгдэх үед түүний чармайлтыг дайсны танктай эсэргүүцэн тэмцэхэд дэмжиж чадсангүй. Хоёрт, дээр тэмдэглэгдсэн ёсоор, бтаальоны дарга, минометч нарт галт байрийг буруу заасны харгайгаар ийм галт сүрхий хүч, байлдааны явцад ямар ч нөлөөг үзүүлжчадсангүй.

Гэвч батальоны даргын хамгийн сүрхий алдаа бол хайгуулыг басамжилсанд оршино гэж мэдвэл зохино. Байлдааны дүрмийн шаардлагын ёсоор жижиг суурин газар буюу хотын хагасыг атаклахад суурин газрын ойролцоо ба түүний зах, барилгын шинж ,гудамж дайсны хориглолт ба байруудын байгаа газрыг нарийвчилсан хайгуулаар урьдаар мэдэх ёстой юм. Энэ удаа батальоны дарга, хамгийн урьдаар шугуйг хайгуулаар мэдэж, дайсанд эзлэгдсэн эсэхийг нарийвчлан магадлах үүрэгтэй байв. Үүний тул хяналтыг чадамгай зохиож, урагшаа гарах хайгуулын жижиг бүлгийн ажиллагаагаар гүйцэтгэж болох байсан.

Хэрэв дайсан гатлуурыг тийм сүрхий хориглож байсан бол, энэ нь түүнд хэрэгтэй байсан ба голын тэртээ талд гатлуураар гачигдсан цэрэг бий болох тухай батальоны даргын санаанд орсонгүй. Учир иймд ахлах даргад найдахгүйгээр өөрийн хайгуулын хэрэглэл ба бололцоогоо ашиглан дайсны хүчний тоог аль болохоор нарийвчлан магадлах хэрэгтэй байжээ. Хайгуул бол байлдааны амжилтын үндэс мөн. Дарга аль ч байлдааны бүх үед хайгуулыг хийх үүрэгтэй юм.

Хайгуулыг зохиох ба хийх практик дадлага бол, дарга, өөрийг хичнээн их боловсруулах тутам, төчнөөн түргэн олдоно.

ТАГНУУЛЫН ОТРЯД

Морьт дивизээс гарсан Тагнуулын отряд бол, байлдаж буюу хяналтаар дайсны тухай хамгийн үнэн мэдээг олдог юм. Тагнуулын отрядыг чухал чиг, объект газар, дайснаас гэнтээр аюулыг учруулж болзошгүй чиг, өөрөөр хэлбэл, дайсан байна гэж сэдэв мэдэгдсэн чигт томилно.

Тагнуулын отрядын хүч бол, тавьсан үүрэг, газар орны байдлаас болох боловч дүрэмд зааснаар хүч нэмэгдүүлсэн сумангаас хоёр суман хүртэл хүчийг 20 километрт хоёр хоногийн хугацаагаар ажиллуулж болно. Тагнах зурвасын өргөн нь 4—5 км. байж болно.

Тагнуулы нотряд нь өөрийн явах зурвасын дотор дайсныг шууд эрж олхын тулд морин ба механикжуулсан хэсүүлийг томилох хэрэгтэй. Морин хэсүүл бол, гол хүчнээсээ 8 км., механикжуулсан хэсүүл бол 15 км. хүртэл ажиллах ёстой.

Тагнуулын отрядын дарга бол, хэсүүлүүддээ үүргийг тавьж, тааруулах рубежийг 8—10 км-ээр тогтоож өх хэрэгтэй. Тэхдээ тагнуулын отрядын гол хүчний явах хурдын хэмжээг нэг цагт 5 км-ээр бодож рубежийг авбал зохино.

Тагнуулын отряд бол дайсантай удаанаар байлдахгүй, мэдээ авах, дайсны жижиг салбаруудтай тулгарвал түүнийг гэнт дайран устгаж, хэл олзлох үүрэгтэй. Харин тагнуулын отрядын явж байгаа чигээс өөр нэгэн чигт их хүчтэй дайсан явж байгаа нь илэрвэл өөрийн явж байсан чигтээ тусгай хэсүүлийг томилж явуулаад, гол хүчээрээ шинэ илэрсэн дайсныг дагаж тагнах хэрэгтэй. Тагнуулын отрядын дарга нь хэрэв ийм зохион байгуулалтыг хийвэл, энэ тухайгаа үүрэг авсан даргадаа түргэн мэдэгдвэл зохино. Шинээр үүрэг авсан тусгай хэсүүлийн дарга нь тагнуулын отрядын үүрэг авсан даргын мэдэлд шууд шилждэг юм.

Тагнуулын отрядад үүргийг авьхад заах зүйл нь

Дайсан хаа юу хийж байгаа, түүний хүч, ямар чигт ажиллах гэж байгааг.

Өөрийн үүрэг, тагнуулын отрядын явах чиг, хүч, эхлэн хөдлөх цаг, рубеж, мэдээ ирүүлэх журам, мэдээ хураах байр, агаарын онгоцтой харилцах журам зэргийг хэлж өх ёстой.

Тагнуулын отрядын дарга үүргээ авсны дараа хийх зүйл нь

- Үүргээ судлах,
- Үүрэг авсан даргын цагтай цагаа тааруулах,
- Газрын зургийг авч готлох ба дохионы таблицыг авах.
- Цагийн хувиарыг хийх, үүнд эхлэн хөдлөх хүртэл хичнээн цаг байгаа, хүнийг ямар ажилд зориулхыг хувиарлана.
- Өөрийн орлогч нарт хүмүүс агт, буу зэвсэг, галт хэрэгслэл, хоол тэжээл, хүн бүрийн бие хамгаалах хэрэглэл, агаартай харилцах холбооны хэрэглэл зэргийг бэлтгэх тухай үүргийг өх.

Цагийн байдлыг үнэлнэ.

Тагнуулын отрядын дарга нь эхлэн хөдлөхийнхөө өмнө өөрийн биеэр хүмүүс, агт морьд, бүх хэрэглэлүүдийг шалгаж дутагдалтай зүйл дээр нь арга хэмжээ авах хэрэгтэй.

Тагнуулын отрядын даргаас хэсүүлүүддээ үүргийг тавих нь

- Дайсны тухай сүүлийн мэдэгдхүүн.
- Отрядын үүрэг.
- Зэргэлдээ ангийн үүрэг.
- Хэсүүлийн ноймор, орон тоо, ахлагч, явах чиг, үүрэг, эхлэх ба дуусах цаг.
- Тааруулах рубеж, түүнийг өнгөрөх цаг,
- Хэсүүлийг солих журам.
- Мэдээ ирүүлэх журам,
- Үүргийг биелүүлсний дараа тэдний юу хийхийг тодорхой хэлж өгвөл зохино.

Тагнуулын отрядын дарга нь тогтоосон цагаасаа өмнө тагнах хянах ажиллагаагаа зогсоож болохгүй. Харин хугацаа дуусан авч цагийн байдлаас болж цааш үргэлжлэн ажиллаж болно. Баригдагсадыг байцаахдаа зөвхөн өөртөө хэрэгтэй зүйлийг товч асууж мэдээд, онц чухал мэдээ олбол даргадаа радиогаар түргэн мэдэгдэх хэрэгтэй.

Тагнуулын отрядын дарга нь өөрийн явж байгаа замд ямар нэгэн саад тохиолдвол, түүнийг шалган үзэж таних тэмдэг тавих ба харин энэ ажлыг хийдээ гол хүчнийг зогсоохгүй чухалчилвал зохино. Тагнуулын отрядын дарга нь өөрийн байлдааны журмыг сайн зохиож дайсны агаар танкийн дайралтыг эсэргүүцэхэд бэлэн байх хэрэгтэй.

ГОЛ ДЭЭР ТАГНУУЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НЬ

Усан заагууд ба ялангуяа өргөн голуудыг газрын цэргүүд түүнд ойртон ирэхээс аль өмнө судалдаг нь журам болсон хэрэг билээ. Үүнд агаараас зургийг авах, баригдлуудыг байцаах, том хэмжээний зургуудыг судлах зэргээр бага бус чухал мэдээнүүдийг авдаг юм. Гэвч гагцхүү газрын тагнуул нь гатлалт хийх шийдвэрийг гаргаж байгаа даргад нилээд бүтэмжтэй бүрэн мэдээг олж өгдөг байна. Тэгээд урьд авсан мэдээнүүд нь гатлалтын үед хуучирсан байж болох учир тэдгээрийг шалгах хэрэгтэй. Газрын тагнуул нь голын хөрсний чанар ба дайсны хориглолтын системийн зэрэг, зургийг судлах буюу агаараас хянах явдлаар мэдэж болохгүй мэдээнүүдийг олох үүрэгтэй.

Голын тагнуул нь өөртөө үүрэгтэй байдаг. Ямар нэгэн усан саад бол давахад бэрхтэй саад байдаг юм. Шөнө ба өтгөн манантай цагт бас өргөн усан саадууд дээр бол агаарын байдал тунгалаг байхад ч эргүүдийн тэмдэгт газрууд үзэгдэхгүй болдог ба усан дотор бел эдгээр тэмдэгтүүд нь их төлөв байдаг ч үгүй байна. Түргэн урсгалтай гол дээр зохих чигийг барьж, тэмдэгт газрыг алдахгүй дагаж явах нь ихднх тагнуулчин нарт бэрхтэй байдаг. Эд бүхэн нь голыг судлах арга хэлбэр дээр өөрийнхөө дардасыг тавьдаг байна.

Усан заагийг тагнах хоёр жишээг дор үгүүлье. Үүнд эх орны их дайны туршлагын дотроос өөрийнхөө үүрэг зорилт, хэмжээ далайцаараа уул сэдэвт нилээд зохицох тулалдаануудыг авсан юм.

Нэгдүгээр жишээ нь N дугаар нэгтгэлийн ангиуд Висла мөрний зүүн эрэг дээр Юзефов-Аннополийн оролцоот газар гурван сарын турш хориглов. 11 дүгээр сарын дундуур голын баруун эрэг дээр дайсны цэрэг хүч нэмэгдүүлэн хоёр тийшээ ахиж байхыг төрөл бүрийн хяналтаар мэдэж авав. Тэгээд бүлэглэлүүдийн шинж байдлыг илрүүлэх хэрэгтэй байв. Үүнд баригдлуудыг олзлон авч, дайсны ангиудын дугаар ба тоо, түүний минийн саадын байдал, тэргүүний захын үнэн зургийг мэдэх гэж шийдвэрлэсэн билээ.

Тагнуулыг нууц явуулахаар төлөвлөв. Энэхүү бодлыг биелүүлж амжисан юм. 8 хоногийн турш хоёр хянах байрнаас одоо болох гэж байгаа ажиллагааны район ба ялангуяа дайсны хориглолтын өмнөд захыг судлав. Тэгээд траншенүүдийн байрлал ба төмөр утсан саадуудын зарим оролцоот газруудыг олж, дайсны зарим галын цэгүүдийг илрүүлэн мэдэв. Гэвч, энэ нь гүйцэд бус байлаа. Хэрэв гол мөрөнд дайсан хориглосон бол түүнийг тагнахад бэрхшээлтэй болдог. Түүний гадрагыг хянах ба хавтгайруулан галлахад хялбар байж болно. Тү-

үнээс гадна, дайсан, эргүүд дээр ба шууд усан дотор инженерийн ба минийн өргөн хөгжүүлсэн саадуудыг бий болгох гэж эрмэлздэг. Үүнээс үндэслэн зөвхөн орон нутгийн бус, харин дайсны галын цэгүүд, түүний бэлтгэл хүчний байрлал галаар маневрлах бололцоо зэргийг их төлөв тодорхой судлах хэрэгтэй. Түүнчлэн, дайсны хориглолтын гүнд оршиж байгаа галын цэгүүдийг илрүүлэхийн тулд их буугийн хянах байрнаас хяналтыг хийж байв. Бас шөнийн цагаар чагналтыг хийж байлаа.

Хяналтын мэдээ ихээхэн хуралдаж байсан боловч, тэр нь баруун эрэг дэрх хориглолтын байдлын бүрэн зургийг гарган өгч чадахгүй байв. Ийм дээрээс олсон мэдээгээ газар дээр нь лавлах, дайсны галын шинэ цэргүүдийг илрүүлэх, түүний төмөр утсан саадыг тодорхой тагнах гэж шийдвэрлэв. Офицеруудаас зохих зааврыг авсан бүлэг тагнуулчин нар дайсны талын эрэг дээр шөнө гарч, тэндээс ихээхэн үнэт мэдээг цуглуулав. Баруун талын эрэг дээр бараг усны дэргэд минийн хоёр талбарыг байгуулсан байлаа. Тагнуулчин нар түүний хил хязгаарыг тодорхойлон мэджээ. Дайсны дүүлэг дундуур гарсан траншений өмнөөс төмөр утсан саад ба Бруногийн торыг илрүүлэв. Түүнчлэн тагнуулчин нар, германчуудын хамгаалалтын бүх бүрэлдүүн нь зөвхөн шөнийн цагаар ажилладаг болохыг мэдэв. Өдөр болохын хамтаар траншений дотор дежурийн пулеметчин нар ба хянагч нар үлдэж, бусад нь хоёр дугаар траншений цаад тал дахь газар нүхэнд орцгоодог байна.

Эдгээр бүх мэдээнүүд нь тодорхой төлөвлөгөөний үндэс болов. Түүний дотор ерийн тооцоо хүмүүсийг шилж, сонгон бэлтгэх гол гатлах хэрэгслэлтэй харилцан ажиллах явдлыг боловсруулах асуудал дээр ихээхэн анхаарлыг тавив. Пулемет, миномет, их буугийн салбарын дарга нар нь манай өмнөт зах дээр очиж өөрийн үүрэг зорилт ба зохио тэмдгүүдтэй нарийн танилцав. Бас тэдэнд гал нээх цэгүүдийг зааж өгөв. Тэд нар тагнуулын хэсгийг удирдагчийн тарншетэй телефон холбоогоор шууд холбогдсон байв.

Нэгдүгээ ртраншед байралсан хөнгөн пулеметийн номероос баригдлыг олзлон авахаар шийдвэрлэв. Ахлах дэслэгч нөхөр Бывалыхаар удирдуулсан хайгуулын бүлэгт 11 хүн оролцооноос: хоёр нь саадыг эвдэх дөрөв нь баригдлыг олзлох, гурав нь хангалтын үүргийг гүйцэтгэх нэгэн байлдагч нь завийг хамгаалахаар тус тус хувиардагджээ. Тэд ар талд нээн нуур дээр завийг түргэн ачаалах, түүнээс гал нээх дадлагыг хийж, шөнийн цагт газар дээр тэмдэгт авах сургуулийг үйлдэж байв. Урьдаас боловсруулуулсан байв.

Бас тагнуулыг явуулах хэд хэдэн чиглэлийг боловсруулсан байв. Урьдаас боловсруулсан чигийг өөрчлөж чадахаар ца-

гийн байдал гэнэт хувирч болохыг анхааралдаа авав. Ийм бэлтгэл нь хэрэг дээрээ зөв зүйтэй болжээ. Тагнуулчин нар нь тал бүрээсээ бэлтгэлтэйгээр хайгуулд гарав.

Хайгуулыг шөнө явуулав. Хэдийгээр тун их харанхуй манантай байсан боловч, тагнуулчин нар нь орон нутаг дээр тэмдэгтийг сайтар авч явлаа. Тэд нар дайсанд мэдэгдэлгүй хоёр завиар явж, дайсны талын эрэг дээр гараад, миний талбар дундуур гарсан сүвээр дамжин гарч, урьдаас төлөвлөсөн газартаа транше рүү орж, германы пулеметийн номеруудыг гэнэт халдав. Богино тулалдааны дүнд ганц герман амид үлдэв. Түүнийг бусад алагдагсдаас авсан баримтуудын хамтаар командлалдаа авчирч өгчээ. Тагнуулчдыг нэгэнт зүүн эрэг дээр гарсны хойно германчууд түргэн байдалд орж гал нээцгээсэн байна. Манай хянагч нар дайсны хэд хэдэн галын шинэ цэгүүд ба их буу, минометын батаренуудын байрлалыг илрүүлэв.

Баригдлыг байцаасны дүн олзолсон баримтууд, урьд цуглуулсан мэдээнүүд нь дайсны бүлэглэлийг бүрэн илрүүлэхэд бидэнд туслав. Энэ мэдээнүүдийн үндсэн дээр германчуудын өмнөт захын байдал, түүний инженерийн байгуулалт, галын цэгүүдийн байрлалыг бүртгэн мэдэв.

Үүнд, манай ангиуд дайсантай удаан цагаар тулгаран байсан үеэр тагнуулчин нар ажиллаж байв. Тэд, голын байдал, орон нутаг, дайсны салбаруудын байрлалын тухай мэдээнүүдийг аажмаар хуралдуулж байлаа.

Харин урьдаас голыг хориглохоор бэлтгэх гэж түргэн ухирч байгаа дайсныг мөрдөн хөөх үед усан заагийг тагнах явдал нь үүнээс өөр хэлбэртэй байна. Энд, тагнуулын ажиллагаа нь төлөв, богинохон цагаар хязгаарлагдаж, газар орныг мэдэхгүйн улмаас бэрхшээлийг учруулдаг юм. Энэ ажиллагааны зарим жижиг зүйлийг хоёр дугаар байлдааны жишээгээр авч үзье.

Германчууд, Орел-Курскийн тойрогт бут цохигдсоны дараа өргөн голын цаана өөрийн бут цохигдсон дивизүүдийн үлдэгдлүүдийг бүгүүлэх гэж горидоод Днепр мөрний цаадахь урьдаас бэлтгэсэн хориглолтын зааг уруу яаралтай ухирч эхлэв. Манай нэгтэлийн ангиуд гитлерчүүдийг мөрдөн хөөсөөр 1943 оны 9 дүгээр сарын 19-д Шульговкийн районоор Днепр мөрөнд ойртон очив. Энд тэд нар гүүр ба битоноор гатлах явдлыг халхлаж байгаа дайсантай байлдааныг хийв. Командлаас Днепр мөрнийг явуут гатлах бэлтгэлийг хийж эхлэв. Голд ойртох газар ба түүний эрэг дээрх цагийн байдлыг түргэн судлах хэрэгтэй болов. Тагнуулчин нар Днепр мөрөнд шурган орж голыг гатлаад бэхжих явдал тулгарав. Даргаас энэ үүргийг явган цэргийн батальоны бүрэлдүүн бүхий таг-

нуулын отрядад найдварлаж, автомашинад суулгаад, саперчин нар ба их буугаар хүч нэмэгдүүлж өгөв.

Тагнуулын отряд биеэ дааж байлдаж чадах байв. Голчлох нь дайснаас өрсөж, баруун эрэг дээр гараад, тэндээ бэхжиж, тагнуул хийхэд оршиж байлаа. Отрядын ажиллагаа нь зориг санаачлагатай бөгөөд тулалдааныг урсгал болгон хувиргахгүй ба хэрэгтэй мэдээг олхуйц идэвхтэй байхын тулд уян хатан байх ёстой байв. Иймд тулалдааныг төлөвлөх ба зохион байгуулах нь бэрхтэй боловч, чухам ийм үесэд офицерын хатуу бөгөөд залуурч гар мэдэгдэхүйц байх нь чухал болохыг туршлага үзүүлэв.

Энэ үүргийг штабын офицерууд сайтар гүйцэтгэж чадав. Тагнуулын төлөвлөгөөг 4 үе шаттай хийв. Нэгд ухиралтыг халхалж байгаа дайсны салбаруудын байрлал, дугаар, бүрэлхийг тодорхойлох ба гармыг эзлэн авах. Гурав дугаар үед голын цаадахь Германы халхалтын бүлэглэлийн ухирч эхлэхийг тодорхойлох ба гармыг эзлэн авах. Гурав дугаар үед гатлалтыг зохион байгуулж, Пушкаревский арлыг эзлэн авах. Эцсэд нь, дөрөвдүгээр үед, баруун эрэг дээрх хориглолтын зурвасыг сэтлэх үед гитлерчүүдийн хүчийг илрүүлж тэдний сөрөг атаклаж болзошгүй чиглэлийг тодорхойлох эдгээр болно. Бас нисэх онгоц, танк их буучин нараар тагнуул хийлгэх мэдээг өгсөн байв.

Гэвч, штабын ажил үүрээр дуусангүй. Учир нь отрядын бүрэлдүүнд олон жижиг хайгуулын бүлгүүд ба төрөл бүрийн цэргүүдийн төлөөлөгч нар орж ажиллан хяналт ба тагнуулыг хийж байсан тул эдгээр мэдээнүүдийг түргэн цуглуулж, нэгтгэх нь тун чухал байв. Бүлгүүдийн хооронд байлдааны иймэрхүү мэдээллийг штабын офицеруудаас зохион байгуулж солилцуулах нь их ашигтай байв. Түүнээс гадна, офицерууд нь тагнуулын боловсон мэрэгжлийн хүчийг ашиглаж, хайгуулын бүлгүүдийг өөр нэгэн зорилт уруу чиглүүлсэн бөгөөд энэ нь дайсан чухам одоо юу хийж байгааг зөвхөн тодорхойлох бус харин тэр нь ойрын ирээдүйд юу хийхээр төлөвлөж байгааг илрүүлэх ёстой байв. Үүний чухал болохыг туршлага илрүүлэв. Одоо үед дайсан юу хийж байгаа тухай мэдээ нь тактикийн цагийн байдлыг бүрэн мэдэх бололцоог өхгүй шүү дээ. Төлөвлөсөн маневр нь зөвхөн эдгээр мэдээнүүд дээд үндэслэгдэж чадахгүй, харин тэр нь ойрын цагийн турш дахь дайсны болзошгүй ажиллагаагаар тодорхойлогдсон байх ёстой.

Бид энэ тулалдаанд аль болохоор нарийвчлан бэлтгэв. Туслах хэрэгслүүдтэй харилцан ажиллагааг зохион байгуулав. Үүргийг хүн бүрд мэдүүлсэн байлаа. Сайн зохион байгуулалтын ачаар төлөвлөгөө нь ширхэг дараалын биелэгдэв. 9 дүгээр

сарын 19-нд манай тагнуулчин нар жижиг хэсгээрээ явж Алферовка ба Кабаковка районуудаар голд шурган орж баригдлыг олзлон авав. Бид тэдний өчиг ба баримтууд дээр үндэслэн Днеприйн баруун эрэг дээр манай нэгтгэлийн фронтын өмнө 10 дугаар моторчилсон дивизийн ангиуд, 106 дугаар явган дивизийн зарим ангиуд үхирч байна гэж дүгнэлтийг хийв. Бас орон нутгийн хүмүүсээс асууж голын баруун эрэг дээр германчууд босоо хүний окопоор хориглолтын заагийг бэлтгэж, эргийн ойр мод шороогоор хучсан галын цэг хэд хэдийг хийсэн болохыг мэдэв.

Ахлах дэслэгч Грязновын тагнуулын бүлэг нь энэ мэдээнүүдийг аваад, 25 хүнтэйгээр Германы автоматчны жижиг бүлгүүдийг цохиж, 9 дүгээр сарын 21-нд Днепрт хүрэлцэн очив. Гатлах хэрэгслийг авчираагүй байлаа. Түүнийг хүлээж, цаг хожимдохыг хүссэнгүй учраас дарга нь байлдагч Чеботаревийг германчуудын талын эрэг дээр явуулав. Тэр байлдагч голыг самран гатлаж, тэндээс завь олж ирэв. Даргаас өөрийн цэргүүдийг түргэн зохион байгуулж гатлуулав. Өглөөний 6 цагт Пушкаревский арлын хагасыг эзлэн авав. Энэ нь цагаа зөв олж чадсан бөгөөд түүний зүгт Германы явган цэргийн батальон хандаж явсан боловч хожимджээ. Зөвлөлтийн цэргүүд дайсны 6 удаагийн сөрөх атаккийг няцааж, эзэлсэн байрлалаа барьж байлаа.

Германчууд баруун эрэг дээр танк бүхий явган цэргийн хөдөлгөөнтэй. отрядиудаар хориглож, өөрийн хориглолтыг ихээхэн тооны танк үзэгдэх байрлал болгох гэж оролдов. Энэ бол цэргийн заль мэх юм. Гэвч, түүнийг тагнуулчин нар тааж мэдсэн билээ. Тэд тасралгүй хяналтыг хийж, баригдлыг олзлон аваад, дайсны хориглолт хийхэд хүрэлцхүйц хэрэгслэлгүй болохыг мэдэв. Тэр нь ч зөв болов Манай гол хүчнийг гатлаж эхлэх үед германчууд Пятихатка — Александрия зааг руу байлдан үхирав.

Энэ хоёр жишээгээр тагнуул нь командлалын хүссэн мэдээнүүдийг олж байв. Энэ бол санамсаргүй тохиолдсон хэрэг биш юм. Энд офицеруудын зохион байгуулах роль илэрсэн билээ. Тэдний урьдчилан үзэх явдал, бэлтгэлийг нарийвчлан хийдэг, төлөвлөсөн төлөвлөгөөгөө биелүүлэхдээ шаргуу зэрэг байдлууд нь туйлын хүнд үеийн дундуур тагнуулын амжилтыг тодорүүлж байлаа.

АГААРЫН ТАГНУУЛ

Одоогийн дайны агаарын тагнуул бол ямар нэгэн тулалдаанд зөв шийдвэрийг гаргахын хамгийн чухал зүйлийн нэг мөн.

Агаарын тагнуул бол богино хугацаанд ихээхэн хэмжээний газрыг тагнаж дайсны хүчийг мэдэх зорилготой.

Агаарын тагнуул бол замын холд, газар орны саадуудаас бэрхшээхгүй явж дайсны гүнд байгаа хүчийг тодорхойлж чаддаг юм.

Агаарын тагнуул нь ерөнхий, байлдааны, тактикийн гэж хуваагдана. Стратегиг тагнуулыг ерөнхий командлагчаас, байлдааны тагнуулыг арми, фронтын командлагчаас, тактикийн тагнуулыг дивиз, корпусын дарга нараас гаргана. Агаарын тагнуулын үндсэн үүрэг бол дайсны цэргийн байрлал, ажиллагааны чанар, их буу танк, моторжуулсан анги ба агаарын хүч, дайнд холбогдолтой завод фабрика, төмөр зам зэргийг тодорхойлход оршино.

Агаарын тагнуул бол бусад төрлийн тагнуулаар авагдсан мэдээнүүдийг өөрчлөх биш, харин дэлгэрэнгүй нарийн болгох, тодруулах, нотлох ёстой.

Зөвлөлтийн эх орны дайнд агаарын тагнуулыг хийхдээ дайсны гүнд ганц хоёр онгоцыг нууцаар оруулах буюу, хэрэв дайсан хүчтэй эсэргүүцвэл байлдааны талбарын тактикийн гүнд сөнөөгч дайрагч хэсгүүдээр тагнах нь их ашигтай байжээ.

Агаарын тагнуулын амжилт бол цаг улирлын байдал онгоцны чанар, тагнуулыг хийх хэрэгсэл жолооч нарын тактикийн мэдэц зэргээс шийдвэрлэгдэнэ.

Агаарын тагнуулыг хийх гэж байгаа даргад үүргийг тодорхой, товч тавихын гадна уул үүргийг гүйцэтгэх бололцоог бололцох хэрэгтэй. Агаарын тагнуулыг сургахдаа марш, давшилт, хориглолтын үенүүдэд дайсны юу юуг тагнах тухай тактикийн талаар сайтар бэлтгэх нь их тустай.

ГАЗРЫН ГАДАРГЫГ СУДЛАХ ТУХАЙ

Цэргийн газрын зургийг мэдэх явдал бол, офицер нэг бүрээс заавал гүйцэтгэвэл зохих зүйд мөн. Хэрэв цэргийн албан хаагч, зургийг зөвөөр уншиж чадахгүй, газар дээр нь тоймлон мэдэж чадахгүй байвал тэр хүн байлдааны цаг үеийн байдал дээр өөрийн үүргийг тодорхой биелүүлж чадахгүй

болно. Цэргийн ямар нэгэн офицерээс өөрийн ахлах даргадаа байлдааны цаг үед өөрийн ба дайсны цэргийн байрлаж байгаа байдлыг зураг дээр буруугаар тоймлон тэмдэглэж, буруу мэдээ хүргүүлснээс болж бага биш будлиан болдог байна. Ийм алдаа гаргадаг явдлын ихэнх нь үг мэдээг зохиогч нь цэргийн газрын зургийг муу мэддэгээс болдог байна.

Зарим офицерууд, цэргийн газрын зураг гэдэг бол туйлын хялбар бөгөөд түүнийг судлах явдалд их цаг гарзасны хэрэггүй юм гэж ойлгодог байна. Ингэж ойлгодог офицерууд бол буудалгын ба бусад төрлийн цэргийн офицеруудаас цэргийн газрын зургийн талаар мэдвэл зохих мэдцийн хэмжээг дутуу юм уу буруугаар ойлгодог хүмүүс юм.

Дайны үед аль ямар салбар, ангийн дарга, өөрөө газар орны байдалтай тохируулан ажиллаж чаддаггүй ба өөрийн харьяа захирагдагсан хүмүүсээ энэ талаар сургадаггүй байвал тэр салбар анги хамгийн их хохирлыг үздэг болох нь бидэнд илэрхий үзэгдэв. Газрын гадарга дахь өндөрлөг, гүвээ, гуу, жалга гэх мэтийн тэгш биш байдал нь тактикийн талаар маш их ач холбогдолтой байдаг. Хэдий тийм боловч газар орны тэгш биш байдлыг байлдааны зорилгоор ашиглах ба цэргийн аялан явах маршрутыг сонгон олох, дайсны хяналт ба түүний галаас нууц далд ажиллах газрыг олж ашиглахын төлөө офицер хүн бол зураг дээр газрын гадаргыг зөвөөр ялган мэдээд үнэлж чаддаг байх хэрэгтэй.

Мөн газрын зургийг жинхэнэ газартай нь тохируулан нийлүүлж тоймлон мэдэж чаддаг байх явдал чухал байдаг. Хэрэв уг газар нутгийн байдал хувиралтгүй байвал газар дээрэх мэдэгдхүйц юмаар тоймлон мэдэхэд хялбар болох нь дамжиггүй.

Гэтэл дайн байлдааны үед газар орны байдал үргэлж хувиралтгүй байдаг биш. Дайны туршилгаас үзэхэд байлдааны ажиллагаа явагдаж өнгөрсөн газар нь ихээхэн өөрчлөгдсөн байдаг байна. Зарим хашаа, байшин буюу түүгээр ч үл барам, бүхэл бүтэн суурин газрууд артиллерийн галаар устгагдан арчигдсан байдаг. Германууд бол өдий төдий суурин газруудыг үндсээр нь сүйтгэж байшин, барилгууд ба түүний доторхи пийшингүүдийг хүртэл өргүй арилгаад ой, мод, таримал цэцэрлэг, талын ганц нэгэн модыг хүртэл цөмийг огтчин сүйтгэдэг байв. Дайны үед дардан сайхан зам боловч тоймлох тэмдэг болж чадахгүйд хүрдэг. Учир нь дайны үед зам нэгэн хэвээр байж чаддаггүй олон болоод түүний чиг нь өөрчлөгдөн солигддог байна. Ийм үед ганцхан хувиршгүй арга гэвэл дайны хөлд өөрчлөгдөхгүй газрын гадаргын өндөр нам байдлаар тоймлох арга байдаг байна.

Үүнээс үзвэл газрын гадаргыг судлах явдал бол цэргийн газрын зургийн нэгэн чухал хэсэг мөн болох нь илэрхий бай-

на. Гэтэл манай цэргийн офицер нэг бүр үүний чухал учрыг төдийл ойлгож чадаагүй явдал гардаг байна. Газрын гадарга судлах явдалд сургуулийн тусгай цаг гаргаж өгдөггүй боловч газрын зургийг уншиж судлах хичээл дээр газрын гадаргын тэгш биш байдлыг хэрхэн тэмдгэлдэг ба өндөр, намыг хэрхэн мэдэх ёстой болохыг сурагчдад таниулдаг байна.

Офицер, түрүүч нарын газрын зургийн бэлтгэлийг үндсээр нь дээшлүүлэх явдал чухал байна. Үүнд юуны урьд офицер, түрүүч нарыг газрын зураг дээр газар нутгийн гадаргын байдлыг онц сайнаар уншиж чаддаг болгох хэрэгтэй. Энэ талаар газрын зургийг нүдэн хэмжээгээр ба хэрэглэлээр буулган авах аргыг хэрэглэж хээр ажиллах явдал ихээхэн ашигтай бөгөөд ингэж ажиллахдаа газрын гадаргыг заавал горизонталь шугам татах журмаар буулгах хэрэгтэй.

Газар орны зургийг ингэж буулган авах дадлага нь өндөрлөгүүд ба гуу, жалга мэтийн газрын гадаргатай тэгш биш байдлыг зураг дээрээс туйлын тодорхойгср ойлгоход сурч байгаа хүмүүст ихээхэн тусламж болно. Сурч байгаа хүн бол газар дээр ажиллаж горизонталь шугам бүхний учрыг биечлэн танилцаад газрын гадаргаар тоймлож сурна. Түрүүч юм уу, эсхүүл тагнуулчин хүн ингэж горизонталь шугамыг татаж ажиллахдаа тийм хэмжээний тахир шугамын дэргэд бүхэл бүтэн салбар анги хоргодож болох юм байна гэгчийг ойлгох болно.

Газрын гадаргын байдлаар тоймлоход тохиодох бас нэгэн бэрхшээл гэвэл горизонталь шугамыг өндрөөр татаснаас болдог байна. Ийнхүү өндөр татасны улмаас манай үндсэн зургуудын горизонталь шугамын тоо цөөн байдаг. Газрын гадаргыг уншиж мэдэх явдал нь унших материал нь байсан цагт сая гүйцэтгэж болно. Гэтэл манай зарим зургууд дээр тийм материал нь байдаггүй ба уг газрын бүх онцолгуудыг ширхэгчлэн тодорхойлдоггүй байна. Зарим зураг дээр үзэхэд нэг хоёрхон горизонталь шугам байх атал жинхэнэ газар дээр нь үзэхэд олон тооны жалга, гүвээ мэтийн зургийн ороогүй зүйлүүд байдаг юм. Ийм учраас 1:50 000-ын зургийн горизонталлийн өндрийг 5 метр хүртэл багасаж 2,5 метрээр хагас горизонтал ьтатах явдал онц чухал байна. Техникийн талаар үүнийг гүйцэтгэж болох дүүрэн бололцоо байгаа юм.

Офицер, түрүүч нарыг газрын гадаргыг уншиж сургах, түүгээр тоймлож сургах болон манай дарга нарт газрын гадаргыг туйлын тодорхойгоор үзүүлж бүхий тийм зургийг олгох явдал бол цэргийг газрын зургийн талаар сурган бэлтгэх ажилын тэргүүний ээлжийн асуудал мөн.

БЕРДЯЕВТЭЙ ТОХИОЛДСОН ЯВДАЛ

— Тэгээд танай Бердяев яаж байна? гэж Ракитинийг тусаал аваад яавхаар бэлтгэж байхад ротын дарга санамсаргүй мэт асуув.

— Нөхөр ахмадаа! одоохондоо түүнд хүнд байна. Бидэнд гомдож байна.

Ахмад Малышев, Ракитинийг сонирхон анхааралтайгаар харав. Тэд гурван жил нэгэн ротод сууж, хамт байлдсан юм.

— А, тийм үү? гомдож байна гэнэ? Сонихон хэрэг байна даа. Бердяев юунд гомдсон юм бол? гэж ахмад хэлэв.

— Хялбархан амь зууж тасаад, жаалхан хүндрэхтэй зэрэг тэгэж байхгүй юу. Ракитин, багш хүн, сурагчийн алдааг үзээд инээмсэглэхтэй адил инээмсэглээд, харин биднийг өөртөө их хатуу шаардлага тавьдаг юм гэж боддог байна гэж хэлэв.

— Түүнтэй ярьсан уу? гэж ахмад огцом асуув.

— Тийм ээ, ярьсан гэж түрүүч хариулсан ба түүний нүдний харц Малышевийн дуугаар энэ яриа тус болсонгүйг мэдэв. Тэр юм бодож байгаад гэнэт инээмсэглэв. Босоод Ракитины дэргэд очиж шууд асуусан нь.

— Миний тусламж хэрэгтэй юү? гэхэд Ракитин, цохигдсон мэт цочив. Малышев, өөрийн захирагдсадыг сайн мэддэг бөгөөд ахмадын тусламж авах гэдэг бол өөрийн асрамжинд итгэгдсэн залуу цэргийг хүмүүжүүлж чадахгүй болов гэдгээ хүлээх гэсэн үг болно.

— Одоохондоо хэрэггүй гэж Ракитин аажмаар хэлээд түүний нүд нь гяласхийв. Ёстой цэрэг болно гэдэг амар хэрэг биш. Гэвч түүнд заавал хүрэх хэрэгтэй . . . гэж түрүүч бодож амандаа үгүүлэнэ. Орой болоход цасан шуурага эхлэв. Рот, ойн замаар шөнийн сургууль хийхээр явж байв. Эхлэж хөдлөхөөс нэгэн цагийн өмнө штабын даргаас хорооны даргад эргэн тойрон цас унасан тухай илтгэсэнд хурандаа таван жилийн өмнө Москвагийн төлөө энд, хүйтний дунд тулалдаж байснаа санаж үгүүлсэн нь:

— Их сайн, Залуучуадыг хатуужуулахад хамгийн сайн нөхцөл мөн. Яахав хэцүү бэрхтэй дасч аваг. Сүүлд хөнгөн болно гэв.

Ахмад Малышев ротын хамт явав. Хатуу цас нүүр өөд цохиж, шинелийн залгаадсаар чихинэ. Өндөр гачуур модон их баярт очсон мэт шинэ малгай өмсөөд, барбагар мөнгөөр цутгасан мэт навчаа ганхуулна. Солдадууд винтов, автоматаа оосроор үүрч хурц үг солилцно. Малышев, хүмүүсийн алиалж байгаад нь баярлаж инээмсэглэнэ. Түүнд рот бол амьд чухал эрхтэн болж хөдлөл бүр, амьсгал бүрийг цөмийг нарийн мэддэг байлаа. Ротын дотор түүний ярилцдаггүй ба түүний мэддэггүй хүн нэг ч үгүй. Тэр дарга хүн харьяалагдагсдын

тус бүрийн авьяас ба тус бүрийн сайн чанарыг мэддэг бол өөрийн захирагдагсдын төлөө хариуцаж чаддаг болохыг дайнд сурч авчээ.

Тэр одоо «Хууччууд» хэрхэн энгийн алхалж байхад, мөн залуучуудын нэг нь хоцроод хэрхэн тэдэнтэй зэрэгцэхийг эрмэлзэж байгаа, бас нэгэн хүн хоцроод сүрхий цаснаас нүүрээ нууж байгаа зэргийг анхааран ажиж явлаа. Тэр хоёрдугаар салаанд Бердяевийн дорой байдлыг олж мэдээд түүнийг онцгой анхааран харав, Бердяев, ганхан алхалж хөлөө соливод салхины өмнөөс толгойгоо бүхийжээ.

Өвлийн сүрхий харанхуй, газрыг бүрхэв. Модны дүрс улам улам тодорхой биш болж давтагдсан замын хуурай цасыг салхин шүүрдэхэд замын тэгшхэн биш нь мэдэгднэ. Замын уулзар дээр Малышев, ротыг зогсоож газрын зургийг гаргав. Модны дор салхин өөд ууцаа хандуулан зогсоод салаадын ба тасгийн дарга нарыг дуудаж үг бүрээ тасалж тэдэнд байлдааны үүргийг тайлбарлав.

Малышев, хорин гурван настай, түүнээс 4 жилд нь байлджээ. Байлдааны үед буугийн дуу сонсоогүй, мина, ихбуугийн сумны тэсрэлтээс мэгдэж газрыг ашиглан, газрыг түргэн ухаж, дайсныг хянаж чаддаггүй болхи хүмүүс тохиолдож байсан ба тэд дараад нь чадвартай туршлагатай солдат болж дэлхий дээр хамгийн хүчирхэг байлдааны үнэнч нөхөрлөгөөр Берлин хүртэл хамт явсанаа санана.

Тэр нь Перелино гэдэг тосгон ба Дубосековийн төмөр замын зөрлөгний хооронд дахь газруудыг тагнаж хорооны гуравдугаар батальонтой холбоо барих үүрэгтэй байлаа. Энэхүү газарт алдарт тулалдаан болсон бөгөөд энд Панфиловийн дивизи Москваг хамгаалж байсан ба түүний нэгэн хороо хурандаа Капровийн командын дор чухам энд тулалдаж өөрийн зүүн жигүүрээр 251 тоот өндөрлөгийг тэмцэж байжээ.

Малышев, Ракитинийг олж харав. Түрүүч түүнийг харсаар өчүүхэн урагш тонгойж ахихад Малышевийн байлдааны маневрт бэлтгэж байхдаа хөдөлсөн сэтгэлээ дарж байдаг заншил нь түүний нүдэнд үзэгдэнэ.

— Хоёрдугаар салаа яг Дубосековд хүрч гуравдугаар батальонтой холбоо барих ажлыг хангана гэж Малышев аажимхан үгүүлэв.

Тэр завсар харанхуй боллоо. Салаад, заагдсан чигүүдэд чимээгүй тархан явав. Тэр алсад тосгоны гал өчүүхэн төдий гялалзав. Ракитин явган суугаад гар фонараар газрын зургийг гэрэлтүүлж захирагдагсаддаа үүргий нь тайлбарлаж байв. Тэр, нэгэн минут хир гайхсан мэт бодсоноо Бердяевийг дуудав.

— Бердяев, чамд итгэж байна. Энэ үүрэг бол хашир солдатад ... Анхааралтай сонс гэж тэр хэлэв.

Бердяев итгэмжгүйхэн харж байлаа. Түүнийг 2 дугаар са-
лааны доторхи муухан цэргийн нэгд тоолно. Гэтэл түүнд байл-
дааны чухал үүргийг итгэжээ. Яагаад энэ вэ?, Энэ тухай ям-
ар нэгэн шалтгаан байгаа юм уу? Тэр Ракитиний царайг ха-
ранхуйн дундаас олж харахыг эрмэлзэв.

— Би чамд итгэж байна. Ихэд итгэнэ ... гэж Бердяевийг
тушаал давтасны дараа түрүүч хэлэв. Тэгээд залуу солдатын
гарыг атгав.

... Бердяев, гагцаараа үлдэж нөхдийн чимээ замхарсан
хойно винтовчоо үүрч, сумтай дайзнууд гэдсийг дарж, суран
бүс чанга барьсан эвгүй шинелтэй, зориггүй нүүрээр улир-
лын хүйтэнд дааран зогсож гагцхүү өөртөө итгэхээр байгаа-
гаа бусдын нүдээр үзэх мэт олж мэдэв. Түүний явбал зохих
замыг зааж өгсөн компус (Луужин) байсан боловч тийм ам-
архан төөрч болох байдалд урьд удаа огт орж байсангүй ...

— Эвдэрхий балгасан дээр хүрмэгц баруун гар дахь нуруу-
н дээр гурван хус мод үзэгдэх бөгөөд түүний дэргэд улбаа
зам техиолдно. Түүнийг дагаад яваарай гэж түрүүч хэлж би-
лээ ...

Бердяев, энэхүү дууг дахин сонсохсон гэж санагдана. Гэвч
хаашаа харавч шөнө, салхи үлээж, цас нүүрийг шавах бөг-
өөд түүнд хэн ч тусалж чадашгүй. Энэ бодлого нь түүнийг
намжуулав гэж хэлж болохгүй. Туршлагагүй усчин аврах эрэг
үзэгдэхгүй долгионт далайд гэнэт хаягдсан мэт түүнд бодог-
дож байлаа.

Бердяев амьсгаадсаар урагш алхалав. Модон дотор ор-
могц санаанд үгүй гараа урагш сунгахаар тийм харанхуй бол-
лоо. Гэвч удалгүй урагш харж улбаа замыг хөлөөр тэмтэрсээр
аяархан алхлав. Тэр нилээд удаан явж дахин талд гарав.
Тэнд зогсож амьсгал авахаар тийм салхи түүнийг үлээж байв.
Мөстэй ус, шинел хувцасыг нэвтлэх адил салхи үлээж Бердя-
евд осгочмоор бодогдлоо. Сандран тэвдэж амьсгаадаж тавар-
цагласаар гүйхэд нэг юм тээглэж арай л ойчсонгүй. Ингэж
гүйсэн нь түүнийг дулаацуулав. Улбаа зам нэгэнт үгүй болж
эргэн тойронд гагц ч гал үзэгдэхгүй ба Бердяев энэхүү өвли-
йн сүрхий шөнө гагцаараа байх нь хүчирхэг мэт санагдаж
байлаа ... Тэр гэдрэг харахаа зэвүүцээд алхалтыг хурдатган
явдал гэнэт түүний өмнө гурван мод сүрчигнэв. Түүний нэг
нь өмнө нь ба нөгөө хоёр нь жаалхан хойно нь байлаа. Тэр
түүнд хүрч Ракитиний түүнд хэлсэм гурван хус мөн бишийг
шалган үзэв. Энэ нь хус байв. Бердяев баярлаж түрүүчийн
хэлсэн улбаа замыг эрж гарав. Цас нэлэнхийд нь жигд дар-
сан тус зам олж чадсангүй. Тэгээд түүнээс хагацхад хайран
санагдах тэр хусан модыг ширтэж байгаад, өөртөө зөв мэт
санагдаж байгаа тэр зүг уруу явав. Одоо тэр дундаа пишин-
гийн яндан гозойсон эвдэгхий байшинг олох, ийм ондоо ба-

римжааг эрэх ёстой боллоо. Зүүн талд шугуй харанхуйлна. Баруунталд ижлээсээ тасарсан хоёр гачуур мод зогсоно. Гачуур шугуй хоёрын хооронд цас бүрхэсэн товцог мэт үзэгдэнэ.

Бердяев эцэж ядарсан нь хэтэрхий тул шугуйг хүрэлгүй салхинаас хоргодох газрыг эрж товцог хүрч малгайгаа дарж, эрүүгээ элгэндээ нааж суув. «Жаахан амрья» гэж бодлоо.

Анхандаа хүйтэн байсан бөгөөд хөрсөн биенийг хөдөлгөж, дулаацуулахаар босохыг хүсэж байв. Гэвч хүнд зүдрэлт түүнийг даржээ. «Хэрэв босвол хөлдөнө» гэж бодоод босохын чадал ч үгүй, хүсэл ч үгүй болжээ. Тэр Ракитинийг гэнэт үзээд түрүүч энд ирсэнийг огт гайхсангүй. Ракитин, байлдааны хамгаалалттай малгай өмсөж зүүн гар нь сулраад дорогш биенийн дагуу унжсан ба харин баруун гартаа танк эсэргүүцэх гранат далайжээ.

«Тэр нь Ельнийн дэргэд гараа шархдуулсан бөгөөд одоо юу уруу гранат далайсан хэрэг вэ? Мөн тэнд галт тэрэгний дуу ба станц дээр ирэхдээ бүх тэргийн дуугардгийн адил үргэлжилсэн сигналыг сонсжээ. Галт тэрэг хаанаас ирдэг билээ гэж Бердяев бодтол галт тэрэг биш, түрүүчийг чиглэн давхиж яваа хуяг дээрээ хар хэрээстэй танкийг үзэв. Энэ нь ефрейтор Ключков манай ротод ярьдаг түрүүчийн алдар гэдэг одон авсан тэр байлдаан байна шүү» гэж Бердяев бодоод: Дайрлаа, «нөхөр түрүүч таныг дайрлаа! Гранатаа хаяач! Хаяач!» гэж цөхрөн хашгирав.

Ракитин, түүнийг хараад инээмсэглэв. «Халуухан тулалдах хэрэгтэй. Тэхгүй бол хөлдөнө шүү» гэж тэр хэлэв.

— Хөлдөнө шүү, хачин хүн, хөлдөнө шүү гэх дуу Бердяевийн бүр чихэнд сонсдож хэн нэгний гар түүний шинелийн захнаас хүчтэй угзрав. Тэр булингарт нүдээ нээв. Түүний өмнө тосон шар өнгөтэй хонин нэхий дээл өмссөн өндөр нуруутай, сахалтай хүн зогсоод түүнийг чанга чичигнүүлэв.

Бердяев босох гэсэн боловч хөл нь бусдын буюу мод мэт болсон тул уначив. Тэгээд богино дээлтэй хүн, түүнийг гараар барьж хэд дахин чичигнүүлэв.

— Дэвхэц, хөл дээрээ хүчтэй зогс! За ... гэж тэр ууртайгаар хэлэв.

Түүний хоолойн дуу нь Бердяевийг тэр дороо тушаалыг биелүүлэхээр тэмцүүлэх тийм сүрхий байлаа. Тэр нударга мэт хүч гарган хөлийг зөөн гарыг сарвалзуулан нуруугаар гулсаж байсныг хажуугаас харвал үнэхээр инээдэмтэй байжээ. Гэвч сахалтай хүн инээсэнгүй.

— Чанга, чанга гэж командлан ээ харал, чи... Солдат хүний байж болдог юм уу? гэж намхан дуугаар үгүүлэв.

Бердяевийн хөл хөвөнд боолттой юм шиг бамбаганаж, хөлийн улнаас маш олон зүүгээр шивэх мэт болно.

— Алгаа яаж ташдаг билээ? гэж сахалтай хүн ууртай хашгирч, үүнийг яаж хийхийг тушаав.

Богино дээлийн энгэр задаж, энгэр дээр нь партизаны медал гялалзна.

Шуурга зогсов. Сар гүйх үүлний завсраар цайран гэрэлтүүлэв. Бердяев гайхав. Тэр дүнзэн мод мэт овгорын дэргэд хажуудуулсан хуучин окопын дэргэд зогсож байлаа.

— Энэ юу вэ? гэж тэр асуугаад үл таних хүний сүрхий харцад тохиолдов.

Аа мэдэхгүй байна уу? Окоп биш үү Панфиловын окоп! гэж дургүйцэн хариулаад шоолсон маягтайгаар Панфиловинхний тухай дуулсан уу? . . . гэв.

Бердяев, сандарч окопыг ширтэв. Тэр хар дарж зүүдлээд сэрсэн хүн шиг болов. Энэ бүхэн энд болсон хэрэг гэж үү? тэр баруунтайх хоёр гачуурын тэндээс германы танк нааш чиглэн ирэхэд түүний адил Зөвлөлийн цэрэг байлдаанд амь үрэгдэж, танкийн гинжинд дарагдаж байсан боловч германуудыг Москва уруу оруулаагүй юм, оруулаагүй юм! . . . Энд энэхүү хуучин окопын дотор улс төрийн удирдагч Клочков: «Орос орон агуу их юм ухрах газар алга, Ард Москва байна» гэж хэлсэн юм.

Энэхүү үгс Бердяевд аргагүй окопыг харж үгийг сонсоход хүргэв. Гараар овгорыг арчин, шар шороо цухуйтал цасыг арилгаж байлаа. Бердяев энэ газрыг сайнаар мэдэж авахын тул түүнийг хурц ширтэж, бээлийгээ бас авчээ. Манай анги дубосековийг дахин эзэлж аваад Панфиловинхний түүхт тулалданы газрын цасыг арилгаж байсан тухай тэр тун саяхан уншсан билээ.

Ямар нэгэн хар юм түүний сэтгэлийг бүрхэж далайн давалгаа мэт улам улам дээшилж . . . Бердяев окоп уруу хорогсголттой харж тэр 28-ын хүүрийг үзэхсэн гэв. Тэдэнтэй байсан хорин есдөх байлдагч нь аймттай ба санаа амар этгээд болох тул түүнийг өөрсдөө алжээ. Бердяев арай түүн шиг болоогүй биз. Тэр даарсан мэт дагжин чичрэв. Ямар аюултай юм санагдав!

— Дубосеков хаа байна? гэж түүний аяархан асуухад сахалтай хүн гараар зааж:

Тэр шугуйн цаана бий. Чамд төмөр замын зөрөлгөн дээр очиход нэг минут л хэрэгтэй байжээ гэж хэлэв.

Бердяев толгойгоо унжуулав. Тэгээд тэр үнэн хэрэг дээрээ галт тэрэгний дуу сонсохуу? Энэ нь зүүдэлсэн хэрэг биш байжээ. Түүний бүх бие халууцаж зүрхэнд нь гал ноцох мэт боллоо. Бушуул бушуул, тэр бас амжина!

Тэр винтовоо мөрнөөс авч төмөр замын зөрөлгөн уруу бараг гүйх шахам хурдан явлаа . . .

МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ ЦЭРГИЙН САХИЛГА БАТЫН ДҮРЭМЭЭС ГАРГАСАН ЗҮЙЛ

ЕРӨНХИЙ ЖУРАМ.

1. Цэргийн сахилга бат бол, цэргийн албан хаагчдаас дагаж мөрдөж байгаа хууль болон цэргийн дүрмээр тогтоогдсон ёс журмыг чанга нарийвчлан сахихыг хэлнэ.

2. Цэргийн сахилга бат бол, цэргийн албан хаагчдаас өөрийн Эх орон — Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг батлан хамгаалах дайчны үүрэг ба өөрийн хариуцлагыг мэдэрсэн дээр үндэслэгдэнэ.

3. Цэргийн сахилга бат бол:

— цэргийн дүрмийн шаардлага, захирах дарга нарын тушаалуудыг тодорхой гүйцэтгэх;

— цэргийн албан хаагчдад тохиолдох бүх брхшээлийг зоригтой давах, дайчны үүргийг биелүүлэхэд өөрийн халуун амь, бүлээн цусыг хайрлахгүй;

— улсын ба цэргийн нууцыг чанд хадгалах;

— үнэнч шудрага байж, цэргийн эрдмийг сайнаар судалж, цэргийн ба ардын хөрөнгийг бүх аргаар хайрлах;

— захирах ба ахлах дарга нарыг хүндлэх, дайчны эслдэг байдал ба ёсыг гүйцэтгэх журмыг чанга сахихыг цэргийн албан хаагч бүрд үүрэг болгоно.

4. Эх орныг хамгаалах эрмэлзэл бол, захирагдагч нарын нэг ч буруу явдлыг өнгөрүүлэхгүй, осолдогчдыг чанга шийтгэх; зүтгэл бүтээлийг гаргасан ба албандаа шалгарагчдыг сайшаахыг захирах дарга нараас шаардана.

5. Захирах дарга бүр цэргийн сахилга батыг журамлахыг шийдэмгий хатуу шаардаж, түүний бүх шаардлагыг гуйвалтгүй биелүүлэх болгож, өөрийн захирагдагч нарыг байнга хүмүүжүүлэх ба цэргийн сүр, цэргийн үүргийн мэдрэлийг тэдэнд бий болгон хөгжүүлж сургах үүрэгтэй.

6. Захирах даргын тушаал бол, захирагдагчдад хууль мөн. Тушаал бол үг дуугүй, тодорхой, хугацаандаа биелэгдэх ёстой.

7. Дэглэм ба сахилгыг сэргээхийн тулд, нөлөөлөх аргыг хэрэглээгүй захирах дарга үүний төлөө хариуцлагыг хүлээнэ. Цэргийн албан хаагч бүр цэргийн сахилга ба дэглэмийг тогтооход захирах даргад туслалцах үүрэгтэй.

8. Сахилгын шийтгэлийг зөвхөн шууд захирах дарга ба 7 дугаар бүлэгт заагдсан дарга нар оногдуулж болно.

9. Доод захирах дарга нарт олгогдсон сахилгын эрх бол, ахлах тушаалын захирах дарга нарын мэдэлд хэзээд байна.

10. Энэ дүрэмд дор дурдаагүй албан тушаалын түрүүч, аглагч цолтой захирах дарга нар өөрийн захирсан хүмүүсийн хувьд тэр албан тушаалд оногдсон цэргийн цолын ёсоор сахилгын эрхийг эдэлнэ:

а) бага түрүүч, түрүүч цолтон — тасгийн даргын эрхтэй;

б) ахлах түрүүч цолтон — салааны туслахын эрхтэй;

в) ахлагч цолтон — суман (рота, команд)-ын жагсаалын даргын эрхтэй.

11. Энэ дүрэмд дор дурдаагүй албан тушаалын офицер, генерал цолтой захирах дарга нар өөрийн захирсан хүмүүсийн хувьд тэр албан тушаалд оногдсон цэргийн цолын ёсоор сахилгын эрхийг эдэлнэ:

а) бага дэслэгч, дэслэгч, ахлах дэслэгч цолтон бол — салаан даргын эрхийг;

б) ахмад цолтон бол — суман даргын эрхийг;

в) хушууч, дэд хурандаа цолтон бол — батальоны даргын эрхийг;

г) хурандаа цолтон бол — хорооны даргын эрхийг;

д) хушууч-генерал цолтон бол — дивизийн даргын эрхийг;

е) дэслэгч-генерал, хурандаа генерал цолтон бол — Бүх цэргийн жанжны орлогчийн эрхийг тус тус эдэлнэ.

12. Салбар, анги, нэгтгэлийн орлогч (туслах) түүнчлэн штабын дарга нар өөрийн захирсан хүмүүст шууд захирах даргаас нэг зэрэг дутуугаар сахилгын эрхийг эдэлнэ.

13. Албан тушаалыг түр гүйцэтгэх тухай тушаалаар зарлагдсан байвал орлож байгаа албан тушаалын сахилгын эрхийг эдэлнэ.

14. Батальон, суман (рота), салааны дарга нар, тэдний адил тушаалтан салбар буюу командын хамт албан хэрэгээр томилогдож, тэдний захирах дарга болж байгаа үед буюу түүнчлэн өөрийн ангиас тасархай биеэ даасан үүрэг гүйцэтгэж байгаа бол, тэр албан тушаалаас нэг зэрэг илүү сахилгын эрхийг эдэлнэ. Үүнд захирах даргаар томилогдсон байлдагч, түрүүч, ахлагч нар сумангийн жагсаалын даргын сахилгын эрхийг эдлэх ба харин ахлагч цолтой түрүүч хүмүүс бол салаан даргын эрхийг эдэлнэ.

15. Цэргийн сургуулийн доторхи курс, салбарын дарга нар нь захирсан хүмүүсийн хувьд тэр албан тушаалаас нэг зэрэг илүү сахилгын эрхийг эдэлнэ.

16. Энэ дүрэмд хамаарагдах хүмүүс нь:

а) Монгол Ардын Хувьсгалт Цэргийн бүх албан хаагчид;

б) цугларалт, маневр зэрэг цэргийн сургуульд суралцаж байгаа цэргийн бүх бэлтгэл албан үүрэгтэн;

в) бэлтгэлд, чөлөөнд гарсан буюу энгийн албан газар ажиллахаар томилогдсон офицер, генералууд цэргийн формыг хэрэглэн яваа үедээ тус тус хамаарагдана.

ЦЭРГИЙН САХИЛГЫГ ГАЖУУДУУЛАГЧДЫГ ЦЭЭРЛҮҮЛЭХ ТУХАЙ

17. Цэргийн албан хаагчид, цэргийн сахилга, нийтийн журмыг гажуудуулсан бөгөөд түүний өдүүлсэн хэргийг шүүхэд шилжүүлэх явдалгүй байвал сахилгын хувьд шийтгэгдэнэ.

18. Өдүүлсэн хэрэг нь эрүүгийн хуульд заагдсан янз бүрийн шийтгэл оногдох боловч гэмт этгээдийг цэргийн мөрдөн байцаах байгууллаганд шилжүүлэх буюу сахилгын шийтгэлээр хязгаарлах алин болох нь захирах даргын мэдэлд байна.

19. Шүүх таслахын тогтоолоор шийтгэгдсэн зохих хуульд харштай хэргийн учир сахилгын хувьд шийтгэгдсэн этгээд шүүхэд шилжхээс чөлөөлөгдөхгүй.

20. Удаашруулж үл болох чухал удаа тохиолдвол офицер, генералуудыг албан тушаалаас зайлуулах эрхийг олгох нь:

а) хорооны дарга, түүний нэг адил эрхийг эдлэгчид бол тусгай ба тусгай бус салааны дарга, түүний нэгэн адил ба түүнээс дорогш тушаалтныг;

б) дивизи, бригадын дарга нар ба түүний нэгэн адил эрхийг эдлэгчид бол тусгай ба тусгай бус суман, ротын дарга нар, түүний адил ба түүнээс доош тушаалтныг;

в) Бүх цэргийн жанжны орлогч ба түүний адил тушаалтан бол тусгай ба тусгай бус батальон, дивизионы дарга нар, түүнээс доош тушаалын бүх хүмүүсийг.

Өөрийн захирагдагсдыг албан тушаалаас зайлуулсан захирах дарга энэ тухай шат дараалан уламжилж дарий мэдэгдэх ба албан тушаалаас зайлуулах болсон шалтгааныг тодорхойлон илтгэх үүрэгтэй.

Учир дутагдалтайгаар өөрийн захирагдагсдыг албан тушаалаас угцруулсан дарга нь тухайн хариуцлагыг хүлээнэ.

21. Хороо, бригад, дивизийн дарга нар, түүний штабын дарга нар ба түүнээс дээш тушаалтныг албан тушаалаас угцруулах явдлыг Бүх зэвсэгт хүчний жанжны тушаалаар гүйцэтгэнэ.

БАЙЛДАГЧ, ТҮРҮҮЧ, АХЛАГЧ НАРТ ОНОГДУУЛАХ САХИЛГЫН ШИЙТГЭЛИЙН ТУХАЙ.

22. Байлдагчдыг шийтгэх хэмжээг дурдвал:

а) донгодох;

б) хуаран, ангийн байрнаас гадагш явах чөлөөг нэгэн сар хүртэл хасах;

- в) ээлжгүй цагийн манаа буюу ажилд таван удаа хүртэл томилох, (харин харуулд томилж болохгүй);
- г) 20 хоног хүртэл жир хорих;
- д) 15 хоног хүртэл хатуу хорих.
23. Хугацаат албаны түрүүч, ахлагч нарыг шийтгэх хэмжээг дурдвал;
- а) донгодох;
- б) хуаран, ангийн байрнаас гадагш явах чөлөөг нэг сар хүртэл хасах;
- в) ээлжгүй цагийн манаа буюу ажилд 3 удаа хүртэл томилох, (харин харуулд томилж болохгүй);
- г) 20 хоног хүртэл жир хорих;
- д) 10 хоног хүртэл хатуу хорих;
- е) албан тушаалаас бууруулах;
- ё) алдар цолыг жагсаалын цэрэг хүртэл бууруулах.
24. Улиран суусан ахлагч нарыг шийтгэх хэмжээг дурдвал:
- а) донгодох;
- б) 20 хоног хүртэл жир хорих;
- в) албан тушаалаас бууруулах.

ОНЦГОЙ УДАА ТОХИОЛДОХОД САХИЛГЫН ШИЙТГЭЛИЙГ ОНОГДУУЛАХ ТУХАЙ.

45. Гарнизон, лагерын байрлал, цэргийн авто тээврийн цувааны дарга, цэргийн хот гарнизоны комендант нар бол, өөрийн харьяа биш цэргийн албан хаагчдыг тус тусын захирагдагсад эдлэх эрхийн дотор хорих эрхтэй болох үүнд:

а) нийтийн журмыг алдагдуулах буюу нийтэд хортой хэрэг өдүүлбэл;

б) гарнизоны харуулын буюу гарнизоны бусад ямар нэгэн албан үүргийг гүйцэтгэж байхдаа хэрэг өдүүлбэл;

в) нутгийн чөлөө, тусгай албан ажил, эмнэлгийн газар буюу гарнизоны гянданд байхдаа хэрэг өдүүлбэл;

г) төмөр зам, усан зам буюу бусад ямар нэгэн зам тээвэрт явж байхдаа хэрэг өдүүлбэл;

д) хэрэг өдүүлэгчдийн захирсан дарга нь дээр дурдсан дарга нараас бага эрхтэй байвал.

46. 45-р зүйлийн ёсоор хорьж шийтэгсэн дарга бол, тэр хэрэг өдүүлэгчдийн харьяат анги, албан газар, сургуулийн дарга, захирал нарт тухайн учрыг мэдэгдэнэ.

Тэр цэргийн албан хаагч, өөрийн ангид буцаж ирмэгц ший-

тгэгдсэн буюу хоригдсон тухайгаа шууд захирсан даргадаа илтэгнэ.

Хэрэв тэр цэргийн албан хаагч, шийтгэгдсэн тухайгаа илтгэхүй бол энэ тухай сахилгын хувьд шийтгэгдэнэ.

47. Бэлтгэлд байгаа буюу чөлөөнд гарсан бөгөөд цэргийн формыг хэрэглэж яваа үедээ, цэргийн сахилга буюу нийтийн журмыг алдагдуулсан офицер, генералуудыг сахилгын хувьд шийтгэх нь:

а) офицеруудыг, дутагдлыг тэмдэглэх ба донгодох үүнд: амаар, бичгээр; гэрийн газар буюу гянданд хорьж шийтгэх үүнд: дунд офицеруудыг 7 хоног хүртэл; ахлах офицеруудыг 3 хоног хүртэл;

б) генералуудыг, дутагдлыг тэмдэглэх ба донгодох үүнд: амаар буюу бичгээр.

48. Бэлтгэлд байгаа ба чөлөөнд гарсан офицер, генералуудыг сахилгын хувьд шийтгэх эрхтэй хүмүүсийг дурдвал:

а) дунд офицеруудыг, гарнизоны дарга нар ба дивизион, батальоны даргын эрхтэй аймаг, хотын цэргийн хэлтсийн дарга нар;

б) ахлах офицеруудыг, хорооны даргын эрхтэй хот гарнизоны дарга нар ба батальоны даргын эрхтэй аймаг хотын цэргийн хэлтсийн дарга нар;

Бэлтгэлд байгаа ба чөлөөнд гарсан хурандаа нарыг хорих явдлыг зөвхөн Жанжин штабын даргын тушаалаар гүйцэтгэнэ;

в) генералуудыг, Бүх цэргийн жанжны тушаалаар гүйцэтгэнэ.

49. Бэлтгэлд байгаа ба чөлөөнд гарсан офицер, генералуудаас цэргийн алдар нэр ба цэргийн цолд харштай хэрэг өдүүлбэл, Бүх зэвсэгт хүчний жанжны тушаалаар тэдний цэргийн форма хэрэглэх эрхийг хасна.

50. Нэгэн дор ажиллаж байгаа цэргийн албан хаагчид нь нэг, нэгэндээ зохирагдаагүй боловч албан тушаалаар ахлах буюу хэрэв албан тушаал нь адилхан байвал алдар цолоор ахлагч нь захирах дарга болж өөрийн эдлэн яваа албан тушаалд оногдох сахилгын эрхийг эдэлнэ.

51. Доод тушаалын албан хаагчид нь ахлах дарга нарын дэргэд цэргийн сахилга, олон нийтийн журмыг алдаршуулах буюу хүндлэх, ёслах журмыг орхигдуулбал, ахлах дарга нь доод тушаалын албан хаагчдыг сануулахаас, хорих хүртэл шийтгэх эрхтэй болно.

Хорих эрхтэй хүмүүсийг дурдвал:

Байлдагч, түрүүч, ахлагч нарыг-генералууд ба бүх офицерууд;

Дунд офицеруудыг-генералууд ба ахлах офицерууд;

Ахлах офицер (энэ дүрмийн 35—36-р зүйлд зааснаас бусдыг) — генералууд.

Хорих явдлыг гүйцэтгэх журмыг 4 дүгээр хавсралтын 16-р зүйлд үз.

52. Ахлах хүмүүсийн шаардлага заавар хоригдохоор явах тушаалыг биелүүлээгүй хүмүүс (51-р зүйлд дурдсан ёсоор) даргын тушаал биелүүлээгүйн хувьд хариуцлага хүлээнэ.

САХИЛГЫН ШИЙТГЭЛИЙГ ОНОГДУУЛАХ ЖУРАМ.

53. Сахилгын ямар нэгэн шийтгэл бол, өдүүлсэн хэргийн холбогдол ба хүнд хөнгөнтэй тохирсон байвал зохино.

Сахилгын шийтгэлийг оногдуулахдаа анхаарвал зохих нь: өдүүлсэн хэргийн байдал; өдүүлсэн үеийн орчин тойрны нөлөө; дутагдал гаргагсдын урьдын байдал; албан хаасан хугацаа; албан хаах журмыг хэр мэдсэн зэрэг болно.

54. Дарга нь өөрийн захирагдагсдыг сахилгын хувьд шийтгэх, албан үүргийг сануулахдаа захирагдагсдыгаа доромжлох ба хэрцгий загнаж болохгүй.

55. Нэгэн төрлийн алдааг хэдэн удаа шийтгэх буюу нэг шийтгэлийг нөгөө шийтгэлтэй нэгтгэх явдал цээртэй. Хугацааг тогтоохгүйгээр сахилгын хувьд хорьж болохгүй.

56. Нэгэн төрлийн хэргийг хэд, хэдэн удаа өдүүлсэн бөгөөд албан үүргээ гүйцэтгэх цагтаа ёс журмыг ноцтой зөрчсөн бол сахилгын шийтгэлийг улам чангаруулна.

57. Дарга өөрийн захирагдагсдын өдүүлсэн хэргийг ноцтойд үзэж сахилгын хувьд шийтгэх эрх хүрэлцэхгүй гэвэл түүнийг сахилгын хувьд шийтгүүлэхээр ахлах тушаалын даргад мэдүүлнэ.

58. Сахилгын хувьд оногдсон эрхийг хэтрүүлэн хэрэглэсэн дарга нь зохих хариуцлагыг хүлээнэ.

59. Ахлах тушаалын дарга нараас, доод тушаалын дарга нарын шийтэгсэн шийтгэлийг хэрэв эрхээ хэтрүүлээгүй бол, чанга шийтгэл гэж өөрчлөх буюу хөнгөвчлөх эрхгүй.

Ахлах тушаалын дарга нь доод тушаалын дарга нараас захирагдагсдаа шийтэгсэн тухай уг хэрэгт тохироогүй гэж үзвэл сахилгын шийтгэлийг нэмэгдүүлэх эрхтэй.

60. Дарга нь ямар нэгэн гэмийг мэдснээс хойш тав хоногийн дотор шийтгэх эрхтэй. Хэрэв мөрдөх буюу лавлах хэрэг тохиолдвол түүнийг дуусмагц шийтгэнэ.

61. Хэрэв уул этгээд согдуу байвал түүнийг эрүүл болтол сахилгын хувьд шийтгэх явдлыг хойшлуулах бөгөөд чухалчлагдвал урьдчлан гянданд хорьж болно.

САХИЛГЫН ШИЙТГЭЛИЙГ ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ.

62. Сахиглын шийтгэлийг даруй гүйцэтгэнэ. Хэрэв онц шалтгаан тохиолдвол 1 сараас хэтрүүлэхгүй гүйцэтгэнэ. 1 сар өнгөрвөл сахилгын шийтгэлийг ёсоор гүйцэтгэхгүй боловч шийтгэл, сайшаалын карточкад тэмдэглэнэ.

63. Гомдол өрөгдлийг мэдүүлсэн боловч шийтгэлийг өөрчлөх тухай ахлах даргын тушаал гараагүй бол, сахилгын шийтгэлийг биелүүлэх явдлыг хойшлуулахгүй.

64. Сахилгын талаар шийтэгсэн шийтгэлийг зарлах үүнд:

Байлдагч нарыг биеэр буюу жагсаалын өмнө;

Түрүүч, ахлагч нарыг, биеэр буюу түрүүч, ахлагч нарын жагсаалын өмнө;

Офицеруудыг биеэр, бичгээр, офицеруудын хурал дээр буюу тушаалаар тус тус зарлана.

65. Байлдагч, түрүүч, ахлагч нар ба офицеруудыг хорих журмыг 4-р хавсралтанд тодорхойлов.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ХУВЬСГАЛТ ЦЭРГИЙН ДОТООДЫН ДҮРМЭЭС ГАРГАСАН ЗҮЙЛ.

Цэргийн албан хаагчид ба
тэдний хоорондын харилцаа

ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧДЫН ЕРӨНХИЙ ҮҮРЭГ

1. Монгол Ардын Хувьсгалт Цэргийн албан хаагчид бол, өөрийн Эх орон-Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг хамгаалагчид мөн.

Цэргийн албан хаагчид бол, цэргийн тангаргийг гуйвалтгүй ариунаар сахих, дайчны үүргийг гүйцэтгэхдээ үнэнч, шударгуу, зоригтой бөгөөд өөрийн хүч, амь биеийг хайрлахгүй зүтгэх, дарга нарт үг дуугүй захирагдаж, байлдаанд даргаа хамгаалах ба өөрийн ангийн тугийг нүдний цэцгий мэт хамгаалах үүрэгтэй.

2. Цэргийн албан хаагчид бол, өөрийн үүргийг сайтар мэдэж, түүнийгээ зүтгэл, чармайлттайгаар биелүүлэх, цэргийн ба улс төрийн мэдэлгээ үргэлж өндөржүүлэх, цэргийн ба ардын хөрөнгө, өөрийн буу зэвсгийг гамнах, цэргийн албаны

бүх бэрхшээл, зүдгүүрлийг тэсвэртэйгээр давах, дайчны нөхөрлөлийг хүндэтгэж, нөхөртөө ажил хэрэг дээр туслах, түүнийг гэмт хэргээс зайлуулан, аюулаас аврахад өөрийн амь биеийг хайрлахгүй зүтгэх, цэргийн ба улсын нууцыг хатуу хадгалж, сонор сэрэмжтэй явах үүрэгтэй.

3. Цэргийн албан хаагчид бол, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Зэвсэгт Хүчний ба цэргийн ангийн байлдааны яруу алдар, өөрийн алдар цолны нэр хүндийг үргэлж эрхэмнэн хайрлах үүрэгтэй.

4. Цэргийн албан хаагчид бол, дарга, захирал, ахлах нарыг үргэлжид хайрлан энэрч, ёсолж хүндлэх журмыг хатуу сахих ба зохих формын хувцсыг нямбай цэвэрхэн хэрэглэж явах үүрэгтэй.

5. Цэргийн албан хаагчид бол, хувийн ба албаны хэргээр өөрийн шадар захирах даргатай харилцана. Хэрэв түүний ахлах даргатай харилцах хэрэг тохиолдвол ганцхан өөрийн шадар захирах даргын зөвшөөрлөөр гүйцэтгэх үүрэгтэй.

Цэргийн албан хаагчдаас, гомдол, өрөгдөл мэдүүлэхдээ сахилга батын дүрмийн 15 дугаар бүлгийг баримтална.

Цэргийн алдар цол.

6. Монгол Ардын Хувьсгалт Цэргийн газрын ба агаарын хүчний албан хаагчид бол, байлдагч нар, түрүүч нар, офицерууд, генералууд ба маршалууд гэж ялгаварлагдана.

7. Цэргийн албан хаагч бүрд, цэргийн албан хаах тухай хуулийн ёсоор цэргийн алдар цол шагнана. Цэргийн албан хаагчдын алдар цолны тухай тус дүрмийн 4-дүгээр хавсралтад тодорхойлов.

Дарга, захирагдагсад

8. Цэргийн албан хаагчид бол, алдар цол, албаны хувьд нэг нь нэгэндээ дарга ба захирагдагсад байх болно.

Дарга бол, захирагдагсад тушаал өх эрхтэй ба түүний биелэлтийг шалгах үүрэгтэй. Захирагдагсад бол, дарга, захиралдаа үг дуугүй харьяалагдах үүрэгтэй.

9. Өөрийн, цэргийн алдар цолны хувьд: — улсын маршал бол — бүх генерал, офицер, ахлагч, түрүүч нар ба байлдагчдын;

— төрөл бүрийн цэргийн генералууд ба хурандаа нар бол бүх дунд офицер, ахлагч, түрүүч нар ба байлдагчдын;

— офицерууд бол бүх байлдагчдын;

— түрүүч, ахлагч нар бол — өөрийн ангийн байлдагчдын захирал нь болно.

10. Цэргийн албан хаагчид, албаны хувьд бүр буюу түр харьяалагдсан даргыг шууд захирах дарга гэнэ.

Захирагдагсад хамгийн ойр бөгөөд шууд захирч байгаа даргыг шадар захирах дарга гэнэ.

11. Тус дүрмийн 9 ба 10 дугаар зүйлүүдэд дурдагдсан цэргийн албан хаагчид бол, цэргийн алдар цол, албаны хувьд цэргийн бусад албан хаагчдын дарга, захирал буюу захирагдагсад биш боловч нэг нь нөгөөгийнхөө ахлах байж болно.

Үүнд хэрхэн ахлах тухай дурдвал:

— улсын маршал бол — генералуудын;

— генералууд бол — өөрөөс доош цолтой генералууд ба бүх ахлах офицеруудын;

— офицерууд бол — өөрөөс доош цолтой офицерууд ба түрүүч, ахлагч нарын; хурандаа нар бол, бусад ахлах офицеруудын;

— түрүүч, ахлагч нар бол — өөрөөс доош цолтой түрүүч нар ба бүх байлдагчдын ахлах болно.

12. Албан ажлыг хамтран гүйцэтгэж байгаа цэргийн албан хаагчид, хэн нэгэндээ харьяалагдаагүй бол, ахлах албан тушаалтай буюу хэрэв адил албан тушаалтай бол, ахлах цолтой нь дарга болно.

Тушаал өх ба гүйцэтгэх журам

13. Тушаалыг, захирах дарааллын журмыг баримталж өгнө. Хэрэв даргаас онц шалтгаанаар, өөрийн захирагдагсад, түүний шадар захирах даргыг дамжуулахгүй тушаал өгвөл, тушаал авагсад нь, түүнийг даруй гүйцэтгээд, тухайн учрыг өөрийн шадар захирах даргад илтэгнэ.

14. Тушаал авсан цэргийн албан хаагчид бол «гүйцэтгэе» гэж хариулаад уг тушаалыг гүйцэтгэнэ.

Дарга, өгсөн тушаалаа, захирагдагсдаас хэрхэн ойлсныг лавлах хэрэгтэй гэж үзвэл, тушаалыг товчоор давтахыг шаардана.

Цэргийн албан хаагчид бол, авсан тушаалыг гүйцэтгэсэн тухайгаа тушаал өгсөн даргад илтгэх үүрэгтэй.

15. Тушаалыг биелүүлж яваа цэргийн албан хаагчид, өөр даргаас, түрүүчийн тушаалыг гүйцэтгэхэд саад болох шинэ тушаал өгвөл, тухайн учрыг тэр, шинэ тушаал өгсөн даргад илтэгнэ. Хэрэв даргаас баталж тушаавал, сүүлчийн тушаалыг биелүүлнэ.

Шинэ тушаал өгсөн дарга нь, энэ тухай, түрүүчийн тушаал өгсөн даргад мэдэгдэх ба тухайн хариуцлагыг хүлээнэ.

Ёслох тухай

16. Цэргийн албан хаагчид, уулзахдаа бие, биедээ ёслолцох үүрэгтэй.

Захирагдагсад ба бага цолтон урьдаар ёсолно.

17. Цэргийн албан хаагчид, дээрхээс гадна:
— цэргийн ангийн туг;
— цэргийн анги дагалдан явж байгаа хүүр оршуулалтад ёсолбол зохино.

18. Цэргийн анги, салбаруудын жагсаж ёслох нь:
— Улсын Бага Хурлын Дарга, Сайд нарын Зөвлөлийн Ерөнхий Сайд, Улсын Маршал, Цэргийн Явдалын Яамны Сайд ба түүний орлогч:

— цэргийн дээд командын генералууд, бүх шууд захирах дарга нар ба анги (салбар) уудыг шалгаж байгаа шалган зааварлагчдын дарга нарт жагсаж ёсолно.

Дээр дурдсан дарга нарт ёслоход жагсаалыг байрлуулан ахлах дарга нь «**номхон, зэргэц, баруун (зүүн буюу дунд) тийшээ**» гэж командлаад угтаж рапорт өгнө. Жишээлбэл: «**нөхөр генералд 136 — дугаар морьт хороо, жагсаалын үзэлгэнд бэлэн, хорооны дарга дэд хурандаа Хайдав**» гэнэ.

Жагсаалаар явж байгаад ёслоход, дарга нь ганцхан зохих командыг өхөөс биш, рапорт өхгүй.

19. Цэргийн анги, салбаруудын ёслох нь:

— Зэвсэгт Хүчний Жанжны тушаалаар зарлагдсан дурсгалын хөшөөнүүд ба Ленин — Сүхбаатарын хөшөө;

— нэг, нэгэнтэйгээ уулзахад;

— цэргийн ангийн туг;

— цэргийн анги дагалдан явж байгаа хүүр оршуулалт эдгээр болно.

20. Улсын Бага Хурлын Дарга, Сайд нарын Зөвлөлийн Ерөнхий Сайд, Улсын Маршал, Цэргийн Явдалын Яамны Сайд буюу түүний орлогчид, цэргийн ангийг жагсааж ёслоход хөгжимөөр «**угтах марш**» ба улсын сүлдэн дууллыг хөгжимдөнө.

Дээр дурдсан удирдагч нар гарнизонд ирэхэд хүндэт харуулыг жагсааж угтана.

Цэргийн ангиудаас өөрийн ангийн дарга түүнээс дээш тушаалын шууд захирах дарга нар ба шалган зааварлагчдын даргад ёслоход хөгжимөөр «**угтах марш**» ийг хөгжимдөнө.

21. Цэргийн анги, салбарууд нь, хичээл сургууль хийж байгаа буюу түүний чөлөө цаг зэрэг жагсаал биш үед ганцхан командаар ёсолно.

Үүнд ахлах дарга буюу захирлын ирэхийг хэн урьд үзсэн цэргийн албан хаагч «**бос**» буюу «**номхон**» гэж командална.

Энэ командаар, цэргийн албан хаагчид нь цөм босч «**номхон**» зогсох ба хэрэв офицерууд малгайтай байвал ёсолж «**болно**» гэж командлах хүртэл хэвээр байна. Ахлах дарга нь тэр ирсэн даргыг угтаж рапорт өгнө.

22. Штабууд ба удирдах газрууд нь шууд захирах дарга ба шалган зааварлагчдын даргад командаар ёсолно.

Даргын ирэхийг хэн урьд үзсэн цэргийн албан хаагчид «бос» буюу «номхон» гэж ёслох командыг өгнө.

23. Даргыг анги, салбартаа ирэх бүрд «номхон» гэж командалж рапорт өгнө.

Ахлах даргын байх үед түүнээс доош тушаалын даргад рапорт өхгүй.

Рапорт өх үед жагсаалаас гадна байгаа цэргийн албан хаагчид, тус дүрмийн 21 — дүгээр зүйлд заасан ёсоор зогсоно.

24. Зөвлөлт улсын сүлдэн дуулал ба Монгол улсын эх орон гэдэг дууг хөгжимдөхөд жагсаалд байгаа цэргийн албан хаагчид бол, командыг хүлээхгүй «номхон» зогсох ба офицер, генералууд бол гарыг малгайн тус өргөж ёсолно.

Дээр дурдсан сүлдэн дуулал ба эх орон гэдэг дууг хөгжимдөхөд, жагсаалаас гадна байгаа цэргийн албан хаагчид «номхон» зогсох ба хэрэв малгайтай бол, гарыг малгайн тус өргөж ёсолно.

25. Цэргийн анги салбаруудын ёслохгүй цаг үе:

— тактикийн сургууль ба аяны амралт дээр;

— галын рубеж дээр буудлага үйлдэж байгаа үед;

— аж ахуй буюу сургуулийн тусгай ажил түүнчлэн тусгай хичээл сургууль, засвар, гараж, ангар, лаборатори, зургийн газар, телефон, цахилгааны ба радио станцуудад ажиллаж байгаа үед;

— хоолны цаг, өдрийн амралт ба «төгслөө» гэдэг дохио өгснөөс хойш «бос» гэдэг дохио өх хүртэл;

— өвчтөний байранд;

— ший кино ба концерт дээр.

Дээр дурсан үед даргыг ирэхэд зөвхөн рапорт өгнө. Хэрэв дарга ганц нэгэн цэргийн албан хаагчидтай шууд уулзах буюу харилцахад өвчтөнөөс бусад хүмүүс «номхон» зогсоно.

Хүүр оршуулахад оролцон явж байгаа цэргийн анги, салбарууд ёслохгүй.

26. Баярын угтлагын хурал, намын хурал, намын бага хурлууд дээр ёслох командыг өхгүй.

27. Офицер, генералуудын сургууль, хурал зөвлөлгөөн дээр даргын ирэхэд «нөхөд офицеруудаа» гэх буюу хэрэв зөвхөн генералууд байвал «нөхөд генералуудаа» гэж командална.

Энэ командаар бүх офицерууд босч «номхон» зогсох ба малгайтай бол гарыг малгайн тус өргөж ёсолно.

Дарга нь рапортыг авмагц «нөхөд офицеруудаа» гэж хариулан хичээлийг үргэлжлүүлэх буюу сул зогсохыг зөвшөөрнө.

28. Дарга буюу ахлахаас «сайн байна уу?» гэж мэндэлбэл жагсаал дотор буюу жагсаалаас гадна байгаа цэргийн албан хаагчид «амрыг эрьс» гэж хариулах ба хэрэв даргаас «нөхөд баяртай» гэж явахын баярыг хэлбэл цэргийн албан хаагчид «баяртай» гэж хариулна.

Үүнд цэргийн төрөл, албан «инженер» «техник» зэрэг мэрэгжлийг дурдахгүй зөвхөн цэргийн цолыг нөхөр гэдэг үгийн дараа нэмж товч хариулна. Жишээлбэл; «Нөхөр түрүүчийн амрыг эрье» «Нөхөр ахмадын амрыг эрье» «Нөхөр генерал баяртай» Хэрэв Маршалд хариулбал «Нөхөр, улсын маршал» гэнэ.

29. Даргаас албан ёсоор баярыг хүргэх буюу сайшаавал цэргийн албан хаагчид нь «Монгол улсын төлөө зүтэгье» гэж хариулна. Хэрэв даргаас цэргийн анги салбарт баяр хүргэвэл урт аялгуугаар «урай» гэж хариулах ба хэрэв даргаас сайшаалыг хүргэвэл цэргийн анги, салбаруудын бүх хүмүүс «Монгол улсын төлөө зүтэгцгээе» гэж хариулна.

Даргад мэдэгдэх журам

30. Цэргийн албан хаагчдаас өөрийн шадар захирах даргад мэдэгдэх цагууд:

- албан тушаалд томилогдсон тухайг;
- албан ажлыг хүлээлгэн өгсөн тухайг;
- улсаас шагнагдахад буюу ээлж дараагийн алдар цол шагнагдсан тухайг;
- албан ажил буюу амралт (чөлөөгөөр) явах ба эгэж ирсэн тухайг тус тус мэдэгдэнэ.

31. Цэргийн албан хаагчдаас даргадаа өөрийн албан тушаал, алдар цол ба мэдэгдэх зүйлийг тодорхой дурдана. Жишээлбэл «Нөхөр хушуучид, нэгдүгээр сумангийн дарга ахмад Ойдов, ахмад цол шагнагдсаныг илтэгье» гэх мэт.

32. Хороо ангид шинэ томилогдон очсон офицерууд бол, хоороны дарга ба дараалан түний орлогч нарт мэдэгдэнэ. Суманд томилогдмогц суман, ротын даргад мэдэгдэнэ.

Үүнээс гадна хорбоны дарга буюу түүний орлогч нь тэр шинэ ирсэн офицеруудыг офицеруудын хурал дээр бүх офицеруудад мэдэгдэнэ.

Шалган зааварлах үед мэдэгдэх журам

33. Хэрэв шалган зааварлахаар ирсэн цэргийн албан хаагчид нь ангийн даргатай адил буюу ахлах цолтой бол ангийн дарга нь тэр ирсэн даргад мэдэгдэнэ. Хэрэв шалган зааварлагчид нь ангийн даргаас доош цолтой бол, тэд нь ангийн даргад мэдэгдэнэ.

Шалган зааварлах ажлыг эхлэхээс өмнө ангийн дарга нь шалгагдах салбарыг шалгах дарга нарт мэдэгдэнэ.

34. Шалгагч нарыг хүрэлцэн очиход шалгагдах салбарын дарга нь тэднийг угтаж рапорт өгнө.

Хэрэв шалгагч нар ангийн даргын хамт шалгагдах салбаруудад хүрэлцэн очих бол шалгагч нар нь ангийн даргатай адил буюу ахлах цолтой бол тэдэнд рапорт өгнө.

35. Цэргийн албан хаагчид ахлах даргаас даалгасан тусгай

албан үүргийг гүйцэтгэхээр ангиудад хүрэлцэн ирэхэд ангийн дарга нь ганцхан өөрөөс ахлах цолтой бол мэдэгдэнэ.

Үүнээс бусад ямар нэг хэргээр ирсэн дарга нар нь ангийн даргад мэдэгдэж ажлын зорилгоо илтэгнэ.

36. Шалгагч нар буюу ахлах даргын даалгаварыг гүйцэтгэхээр ирсэн дарга нараас заавар өхдөө ангийн даргаар дамжуулна.

Цэргийн албан хаагчын эелдэг зан ба биеэ авч явах тухай

37. Цэргийн албан хаагчид нь хоорондоо ямагт эелдэг, намуухан тэвчээртэй байдлаар харилцвал зохино. Цэргийн албан хаагчид нь албан хэргээр хоорондоо харилцахдаа биесийг «та» гэж дуудвал зохино.

Захирах буюу ахлах дарга нар нь албан хэргээр өөрийн захирагдсан буюу доод тушаалтантай харилцахдаа, тэд нарын цол ба нэр буюу хэрэв ганцхан цолыг дурдвал өмнө нь «нөхөр» гэдэг үгийг нэмж хэлнэ.

Захирагдагсад буюу доод тушаалын хүмүүс нь албан хэргээр захирах буюу ахлах даргатай харилцахдаа өмнө нь «нөхөр» гэдэг үгийг нэмж цолыг дурдана.

Хувийн хэргээр харилцахдаа цэргийн төрөл, албан ба «инженер, техник» гэх зэрэг мэрэгжлийг дурдахгүй зөвхөн цолыг дурдана.

Жишээлбэл: «байлдагч Лувсан, түрүүч Содном, нөхөр түрүүч, ахлах-түрүүч Жамбал, нөхөр ахлах-түрүүч, дэслэгч Дорж, нөхөр дэслэгч, ахлах-дэслэгч Базар, нөхөр ахлах-дэслэгч, нөхөр ахмад, нөхөр хурандаа, нөхөр генерал» гэх мэт. Улсын маршалыг нэрлэвэл «нөхөр, улсын маршал» гэнэ.

Бичгээр харилцахдаа цэргийн алдар цолыг төрөл, албаны хамт бүрэн дурдана.

38. Жагдаалын гадна хоорондоо харилцах, тушаал өх ба авах алин боловч цэргийн албан хаагчид нь «номхон» зогсох ба малгайтай бол малгайн тус гарыг өргөж ёсолмогц гарыг буулгана.

Цэргийн албан хаагчид нь рапорт авах ба өх үед гарыг өргөн ёслох бөгөөд рапорт өгч дуусмагц ёсолсон гарыг буулгана.

39. Цэргийн албан хаагчид нь, захирах ба ахлах даргын дэргэд харилцан уулзахдаа, тэр захирах буюу ахлах даргаас зөвшөөрөл авбал зохино. Жишээлбэл: «Нөхөр хурандаад, ахмад Данзантай харилцахыг зөвшөөрнө үү?» гэнэ.

40. Цэргийн албан хаагчдаас захирах буюу ахлах даргын асуусан зүйлийг баталж хариулах явдал тохиолдвол «тиймээ» гэж хариулах ба татгалзан хариулах явдал тохиолдвол «үгүй» гэж хариулна.

41. Цэргийн албан хаагчид нь захирах буюу ахлах даргын дэргэд түүний зөвшөөрөлгүйгээр суух буюу тамхи татахыг цээрлэнэ.

Цэргийн албан хаагчид нь олон нийтийн газар буюу автобус, галт тэрэг зэрэг бусад газруудад, ахлах даргыг орж ирэхэд хэрэв сул суудалгүй байвал өөрийн суудлыг тавьж өгвөл зохино.

Цэргийн албан хаагчид нь галт тэрэг, автомашинаар явж байгаад, тэндээс гадагш гарахдаа ямагт зохих журмаар хувцалсан байвал зохино.

42. Генерал, офицерууд ба улиран суусан түрүүч, ахлагч нар бол, албан ажлын чөлөө цагт ангийн байрнаас гадагш явахдаа цэргийн форма хольцолдоогүй дан энгийн хувцас өмсөж болохыг зөвшөөрнө.

43. Бэлтгэлд халагдсан буюу чөлөөнд гарсан генерал, офицерууд бол, цэргийн формыг хэрэглэж яваа үедээ, цэргийн албан хаагчдын зохих журмыг заавал сахивал зохино.

ШУУД ЗАХИРАХ ДАРГА НАРЫН ҮҮРЭГ ЕРӨНХИЙ ҮҮРЭГ

44. Захирах арга бүхэн өөртөө даалгагдсан анги, салбарын байлдааны ба дайчлгааны бэлэн байдал, бүх хүмүүсийн аж байдлын ба хэрэглэгдэхүүний хангалт, улс төр, байлдааны бэлтгэл, хүмүүжил, сахилгыг бүрэн хариуцана.

Захирах дарга бүр өөрийн анги, салбарын жинхэнэ чанар байдлыг аль ч нэгэн талаар тодорхой мэдэж байлдааны ба дайчлагааны бэлэн байдлыг дээшлүүлэх, хэрэглэгдэх зүйлээр хангахын тулд бүх арга хэмжээг авах үүрэгтэй.

45. Захирах дарга бүр, өөртөө даалагдсан анги, салбарын улс төр, байлдааны бэлтгэлийг шууд удирдах ба бүх хүмүүсийг нэгэд нэгэнгүй судалж тэдгээрийг хүмүүжүүлэхийн тул үргэлж санаачлах, захирагдагсдын тус тусын чадварыг мэдэх, тэдгээрийн байлдах арга чадварыг тасралтгүй өндөржүүлэх үүрэгтэй.

Захирах дарга, өөрийн улс төр, цэргийн мэдлэгийг өндөржүүлэхийн тулд цаг үргэлж ажиллах үүрэгтэй.

46. Захирах дарга бол, өөрийн анги, салбарт хатуу дотоодын дэглэмийг тогтоож түүнийг сахиулах, албаны ёс журам гажуудуулсан явдлыг даруй арилгах ба өөрийн анги салбарын байлдах чадварт хор нөлөө учруулж болох ямар нэгэн үзэгдлийг шийдвэртэйгээр тас цохих үүрэгтэй.

47. Захирах дарга бол, захирахдагсдад өгсөн заавар тушаалыг хугацаанд нь яг үнэнээр гүйцэтгүүлэхийн тулд шаардах ба санаачлага гаргагсдыг сайншаах осолдогчдыг хайр найргүй цээрлүүлэх зэргээр, өөрт олгогдсон эрхийн дотор биеэ биеэ дааж ажиллах үүрэгтэй.

48. Захирах дарга бол, өөрийн захирагдагсдыг цэргийн тангаргийг гуйвалтгүй ариунаар биелүүлэх ухамсартай болгон хүмүүжүүлэхийн хамт бүх хүмүүсийг албан ажилдаа үнэнч зориг тэсвэртэй, санаачлагатай бөгөөд өөрийн Эх оронд дайсагнагчдыг бүрмөсөн ялахын тулд хүч чадал, амь биеэ хайрлахгүй байлдахад, бэлэн байдалтай болгон хүмүүжүүлэх үүрэгтэй.

49. Захирах дарга бол хууль, дүрэм, тушаал зааварын шаардлагыг яг үнэнээр биелүүлэх сэргэлэн, тэсвэртэй хэлбэршгүй үлгэр жишээ үзүүлэх ба захирагдагсдыг хэрцгий аашлах буюу тэдний хувийн хүндэтгэлийг доромжлохгүй шударгуу явбал зохино.

50. Захирах дарга бол, өөрийн захирагсдын эрүүл мэндийг хамгаалахын төлөө санаачлан, тэдний аж байдал, эрэлт хэрэгцээг тодорхой мэдэж улсаас олгогдсон оногдлыг гүйцэд олгож байгаа эсэх ба түүний чанарыг хянан шалгах, хэрэв чухалчлагдвал өөрийн зөвлөлгөөн өх буюу ахлах даргад мэдүүлэх зэргээр захирагдагсаддаа туслах үүрэгтэй.

51. Захирах дарга бол, өөрийн анги, салбарын данстай ба бэлэн байгаа хүмүүс, бүү зэвсэг, байлдааны техник, агт морь, тээврийн хэрэглэлийн тоо мэдээг ямагт үнэн тодорхойгоор мэдэж явах үүрэгтэй.

52. Захирах дарга бол, ямар нэгэн шалтгаанаар түр гадагш явахдаа орлогчийг томилоогүй бөгөөд, орон тооны орлогчгүй бол, ахлах албан тушаалтай буюу, ахлах алдар цолтой дарга түүнийг орлож тухайн учрыг дээд даргад мэдэгдэнэ.

Албан хэрэг ба албан тушаалыг хүлээлцэх үеийн үүрэг

53. Шинэ томилогдсон ангийн дарга бол, ахлах даргын албан бичиг буюу тушаалын ёсоор ажилдаа орж тэр тухай ангийн тушаалаар зарлахын хамт дээд даргадаа мэдэгдэнэ.

54. Ангийн дарга нар, албан хэрэг ба албан тушаалыг хүлээлцэхдээ, дээд даргын бие төлөөлөгчийн дэргэд гүйцэтгэнэ.

Ангийн даргын албан хэрэг ба албан тушаал, ангийн зэвсэглэл, аж ахуйг хүлээлцүүлэхийн тулд дээд даргын тушаалаар тусгай комиссийг томилно. Тэр комисс нь, ангийн ерөнхий

чанар байдал, бэлэн байгаа буу зэвсэг, эд аж ахуй, түүний чанар байдлыг тус тус шалгаж акт гаргана.

Албан хэрэг ба албан тушаалыг хүлээлцсэн актад ангийн данстай ба бэлэн байгаа хүмүүсийн тоо, тэдний улс төрийн санал, сэтгэл сахилгын байдал, улс төр, байлдааны бэлтгэл, байлдааны ба дайчилгааны бэлэн байдлуудыг дурдана.

Ангийн буу зэвсэг, байлдааны техник ба галт хэрэглэлийг хүлээлцсэний актад данстай ба бэлэн байгаа хэрэглэлийн тоо, буу зэвсэг байлдааны техник, галт хэрэглэлийн чанар техникийн байдал, тэдгээрийн хадгалалтын байдлуудыг дурдана.

Эд аж ахуйг хүлээлцсэний актад: орон сууцны байдал, бэлэн байгаа орон сууц, эд хогшил, түүний чанар, шаардагдах засвар, бэлэн байгаа мөнгөн санхүү, ачаа хувцасны хэрэглэл, техникийн хэрэглэл, бусад эд хэрэглэл, зарцуулан байгаа ба үл хөдлөх запас, хүнс тэжээлийн чанар байдал, тоо бүртгэл, хадгалан байгаа журам, бэлэн байгаа агт морьд, тээврийн хэрэглэл, түүний чанар байдлуудыг дурдана. Хүлээлцсэн актад, хүлээн авсан ба хүлээлгэн өгсөн дарга нар гарын үсэг зурж, рапорт дагалдуулан дээд даргад илтэгнэ.

55. Салбаруудын дарга нар, албан хэрэг ба албан тушаалыг хүлээлцэхдээ ангийн даргын тушаалыг баримтлан өөрсдөө гүйцэтгэнэ. Албан ажлыг хүлээлцсэн тухай ангийн даргад рапорт бичиж илтэгнэ.

Албан тушаалыг хүлээн авсан дарга нь салбараа хүлээн авсны актыг өөрийн рапортод хавсаргаж тэр актад: салбарын данстай ба бэлэн байгаа хүмүүсийн тоо, сахилгын байдал, улс төр, байлдааны бэлтгэл, бүх хүмүүсийн улс төрийн санал сэтгэл салбарын байлдааны бэлэн байдал, ангийн дансаар тэр салбарт байгаа ба бэлэн байгаа буу зэвсэг, байлдааны техник, эд хэрэглэлийн чанар байдлыг дурдана.

Хүлээлцсэн дарга нар актыг зохиож гарын үсэг зурна.

56. Албан хэрэг ба албан тушаал хүлээлцэх явдлыг хороодын дарга нар 10 хоног, хорооны аж ахуйн орлогч нар 20 хоног, батальон, дивизион, суман ротын дарга нар 5 хоногийн хугацаанд тус тус багтаана.

57. Шинэ томилогдсон ангийн дарга ба суман, рота хүртэл салбарын дарга нар, албан хэрэг, албан тушаалыг хүлээн авах үедээ салбар ангийн цэргийн албан хаагчдыг шалгах асуултыг явуулна. Үүнээс гадна анги, салбарын цэргийн албан хаагчдыг шалгах асуултыг шалгагч нараас явуулж болно.

58. Шалгах асуултыг явуулах цаг, журмыг, шалгахаас 1—2 хоногийн өмнө ангийн тушаалаар зарлана.

59. Шалгах хүмүүс нь, асуултыг явуулахаас өмнө анги, салбарын гомдол өрөгдлийн дансыг үзэж, гомдол бүрд гаргасан шийдвэртэй танилцах ба шалгах асуулт дээр гаргасан гомд-

лыг, тусгай дансанд бичиж тэмдэглэсэн эсэхийг лавлаж мэдэх үүрэгтэй.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЭХ ОРОН ГЭДЭГ ДУУ

Хөдөө тал нь малаар дүүрэн
Хөвч ой нь ангаар бүрэн
Хөрсөн дотор нь эрднээр арвин
Хүний хэрэгцээ цөм багтсан.
Яндаж болдоггүй далай шиг
Яасан баян нутаг вэ?
Ямар их хувь заяагаар
Бид нар эзэн нь болж төрвөө.

Дэлгэр Монгол орноо
Магтаж бид нар дуулахдаа,
Тэнэгэр сайхан жаргалаа
Бахдаж заавал оруулдаг.
Амьдралын хамаг жаргал нь
Эрх чөлөөндөө байдаг
Аль тэр чухлы нь
Ард бид нар эзэмшдэг.

Хөдөө тал нь малаар дүүрэн
Хөвч ой нь ангаар бүрэн,
Хөрсөн дотор нь эрднээр арвин
Хүний хэрэгцээ цөм багтсан.
Яндаж болдоггүй далай шиг
Яасан баян нутаг вэ?
Ямар их хувь заяагаар
Бид нар эзэн нь болж төрвөө.

Дэмжиж тусалдаг С С С Р минь
Дэлхийд ганцаар хүчирхэг
Дийлэгдэшгүй манай хүчин
Эвдрэшгүй найрамдалдаа байдаг
Ийм сайхан орныг
Эзэмшиж байгаа бид нарт
Зогсолтгүй өөртөө ажиллах
Зориг аяндаа ордог.

(Дахилт)

Ариун Монгол оронд минь
Аюул хэрэв тулгарвал
Аврага Чойбалсангийн дуудлагаар
Ард бүхэн босцоогоно.
Тэр сүрхий өдөр
Тэмцэж шатсан хилэн минь
Тэрслэх дайсны өмнөөс
Тэслэх аянга болж дэлбэрнэ.

(Дахилт)

Г А Р Ч И Г

	Стр.
СССР-ийн нарын Зөвлөлийн дарга, Зөвлөлт Холбоот Улсын генералиссим Иосиф Виссарионович Сталин танаа	3
Бүгд Найрамдах Монгол Ард Улсын зэвсэгт хүчний жанжны тушаал, № 468	4
СССР-ийн Сайд нарын Зөвлөлийн дарга Зөвлөлт Холбоот Улсын генералиссим Иосиф Виссарионович Сталин танаа	6
Монгол Ард Улсын зэвсэгт хүчний жанжны тушаал	7
Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ерөнхий сайд Маршал Чойбалсанд	8
Монгол Ардын Хувьсгалт Цэргийн тангараг	8
Шинэ цэргийн хүлээн авахад бэлтгэе	9
Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1946 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 27 дугаар хурлын тогтоол	12
Хувьсгалт Цэргийн баярын өдрийг тогтоожээ	13
Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 32 дугаар хурлын тогтоол	15
Улаан туг бол цэргийн алдрын бэлэг тэмдэг мөн	16
Харуулын албыг улам чангатгая	18
Давших үеийн нам, улс төрийн ажил	20
Гурван линий орос винтов	23
Мэргэн буудахад тусламж	26
Морьт цэргийн байлдааны бэлтгэл	28
Давшхад артиллеритэй харилцан ажиллагааг зохиох нь	32
«Танк эсэргүүцэх давшилтын» группийг зохиож суръя	34
Танк, хуягтын ангиудын галын бэлтгэл	36

Танкийн тэргүүний ангийн ажиллагаа	39
Танкийн шөнийн ажиллагаа	41
Танк эсэргүүцэх хориглолтын системд их буугийн ажиллах нь	44
Буудлагын батальон, тулгарах байлдаанд	46
Холбоочин нарын сургуулийг чанартай зохиоё	48
Морьт суманд зохиох холбоо	49
Инженерийн хэрэглэлийг зөв ашиглая !	52
Тайга, намаг дундуур давшсан нэг ангийн сапёр нарын байлдааны зам	54
Химийн бэлтгэлийг дээшлүүлье	57
Авто машиныг дулааны улиралд бэлтгэх нь	59
Тойрох маневр	63
Дайсныг уултай газарт орох ба бүслэх нь	67
Гудамжинд байлдах нь	70
Дайрах бүлгүүд гудамжинд тулалдах нь	73
Тушаалыг өх ба гүйцэтгэх журам	75
Штабын офицеруудын сургуулийг байгуулах тухай	78
Дотоод журам бол ангийн ажил, сургуулийн зөрцөшгүй хууль !	80
Хайгуулыг дутуу үнэлэх нь юу болох вэ ?	83
Тагнуулын отряд	86
Гол дээр тагнуулыг зохион байгуулах нь	88
Агаарын тагнуул	93
Газрын гадаргыг судлах тухай	93
Бердяевтэй тохиолдсон явдал	96
Монгол Ардын Хувьсгалт Цэргийн сахилга батын дүрмэ- эс гаргасан зүйл	101
Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Хувьсгалт Цэргийн дотоодын дүрмээс гаргасан зүйл	107
Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эх Орон гэдэг дуу	117

ОГЛАВЛЕНИЕ

	Стр.
Телеграмма Председателю Совета Министров СССР Генералиссимусу Иосифу Виссарионовичу Сталину 6 ноября 1948 г.	3
Приказ министра вооруженных сил Монгольской Народной Республики № 464, 7 ноября 1948 г.	4
Телеграмма Председателю Совета Министров СССР Генералиссимусу Иосифу Виссарионовичу Сталину 8 мая 1947 г.	6
Приказ министра вооруженных сил МНР № 374, 7 ноября 1947 г.	7
Телеграмма товарища Сталина Премьер-Министру МНР Маршалу Чойбалсану	8
Присяга Монгольской Народно-Революционной Армии	8
Подготовиться к приему цириков очередного призыва	9
Постановление 27-го заседания Совета Министров МНР от 26 апреля 1946 г.	12
Об установлении праздника Монгольской Народно-Революционной Армии	13
Постановление 32-го заседания Президиума Малого Хурала МНР	15
Красное знамя — символ воинской славы	16
Еще больше укреплять караульную службу	18
Партийно-политическая работа в наступлении	20
Трехлинейная русская винтовка	23
В помощь отличникам-стрелкам	26
Боевая подготовка кавалерии	28
Организация взаимодействия с артиллерией в наступлении	32
Подготовка противотанковой группы	34
Огневая подготовка бронетанковой части	36
Действие головной танковой части	39
Действие танка ночью	41
Действие артиллерии в системе противотанковой обороны	44
Встречный бой стрелкового батальона	46
Правильно организовать учебу связистов	48

Связь в кавалерийском эскадроне	49
Правильно использовать инженерные средства	52
Боевой путь одной саперной части, наступавшей по лесисто-болотистой местности	54
Улучшить химическую подготовку	57
Подготовка автомашины к летним условиям	59
Маневр на окружение	63
Окружение противника в гористой местности	67
Уличный бой	70
Уличный бой штурмовых групп (эпизод из Отечественной войны)	73
Отдача и выполнение приказов	75
Об организации подготовки штабных офицеров	78
Внутренний распорядок — нерушимый закон жизни и учебы части	80
К чему приводит недооценка разведки	83
Разведывательный отряд	86
Организация разведки на водных рубежах	88
Воздушная разведка	93
Об изучении топографии	93
Рассказ о разведчике Бердяеве	96
Из дисциплинарного устава МНРА	101
Из устава внутренней службы МНРА	107
Песня о Родине Монгольской Народной Республики	117

БИБЛИОТЕКА

**Ин-т Востоковедения
АН СССР**

~~**БИБЛИОТЕКА**~~
~~**Исторический Институт**~~

ОПЕЧАТКИ:

Напечатано	стр.	строка	следует читать
нийтдаяараа	5	сверху 10	ниит даяараа
хүмүүжүэхийн	11	» 17	хүмүүжүүлэхийн
Дүгд	12	снизу 2	Бүгд
анхидугаар	13	» 17	анхдугаар
бардын	13	» 12	баярын
хэуэгхэи	20	» 4	хэрэгтэй
нэмэгдүүэх	21	сверху 6	нэмэгдүүлэх
Квказын	24	снизу 17	Кавказын
байыхн	31	» 3	байхын
тэрүүний	39	» 10	тэргүүний
бэлнээр	47	сверху 15	бэлхнээр
байтдугай	53	снизу 7	байтугай
эээрхэг	54	сверху 19	эээрхэг
аюултүй	56	» 23	аюултгүй
байж доош ул болно	61	» 1	доош байж ул болно
эргүүл	61	снизу 18	эргүүлж
бүрыг	66	сверху 5	не читать
Япочуудын	67	снизу 8	япончуудын
биелэдэггүй	76	сверху 23	биелдэггүй
аяж	81	снизу 18	аяж
явхаар	96	сверху 2	явахаар

